

Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага



Жагсаал, цуглааны үеэр
хэв журам сахиулахад
баримтлах хүний эрхийн
гарын авлага

Энэхүү баримт бичгийг анх 2016 онд ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ)-аас «Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага» гэсэн нэртэй нийтэлсэн. Энэхүү монгол хувилбар нь АИХЭГ-ын дэмжлэгтэйгээр бэлтгэгдэж, хэвлэгдсэн албан бус орчуулга юм. Гарын авлагад тусгагдсан үзэл бодол, мэдээллийг АИХЭГ-ын албан ёсны байр суурь, баримталж буй бодлого гэж үзэхгүй бөгөөд бичвэрийн хувьд зөрүүтэй тохиолдолд эцсийн болон албан ёсны хувилбар болох англи хэл дээрх хэвлэлтэй тулгаж үзнэ үү.

Гарчиг

Талархал	5	Хүчийг эцсийн арга болгон ашиглах	34
Өмнөх үг.....	7	Цагдаа ба хэвлэл мэдээлэл.....	37
Танилцуулга	9		
		3-р бүлэг. Шийдвэр гаргах	
		ба эрсдлийн үнэлгээ.....	40
I Хэсэг		<i>Шийдвэр гаргах загвар</i>	<i>41</i>
Тодорхойлолт, Зарчим, Бодлого.....	13	<i>Эрсдэлийн үнэлгээ</i>	<i>44</i>
1-р бүлэг. Тайван жагсаал,			
цуглаан хийх эрх	14	II Хэсэг	
<i>Жагсаал, цуглааны төрлүүд</i>	<i>17</i>	Жагсаал, цуглааны өмнө: зохион	
<i>Хүчирхийлэл ба жагсаал, цуглаан... ..</i>	<i>19</i>	байгуулалт ба төлөвлөлт	47
<i>Жагсаал, цуглааныг хязгаарлах.....</i>	<i>20</i>		
<i>Жагсаал, цуглааныг хориглох</i>	<i>24</i>	4-р бүлэг. Командлалын бүтэц.....	48
<i>Зардал.....</i>	<i>25</i>	<i>Стратегийн командлал.....</i>	<i>50</i>
		<i>Үйл ажиллагааны командлал</i>	<i>52</i>
2-р бүлэг. Жагсаал, цуглааны үеэр		<i>Тактикийн командлал.....</i>	<i>55</i>
хэв журам сахиулахад баримтлах		<i>Үүрэг, хариуцлагууд.....</i>	<i>57</i>
үндсэн зарчмууд	25		
<i>Ардчилсан зарчмаар хэв журам</i>		5-р бүлэг. Стратеги төлөвлөлтийн	
<i>сахиулах</i>	<i>25</i>	үе шат	57
<i>Жагсаал, цуглаанд оролцогчийн</i>		<i>Мэдлэг</i>	<i>58</i>
<i>зан байдлыг ойлгох</i>	<i>27</i>	<i>Дэмжлэг үзүүлэх.....</i>	<i>59</i>
<i>Жагсаал, цуглаан дээр хэв журам</i>		<i>Харилцаа холбоо</i>	<i>59</i>
<i>сахиулахад баримтлах зарчмууд... ..</i>	<i>28</i>	<i>Ялгаатай байдал</i>	<i>63</i>
<i>Мэдлэг</i>	<i>28</i>	<i>Эрсдэлийн үнэлгээ</i>	<i>63</i>
<i>Дэмжлэг үзүүлэх.....</i>	<i>29</i>	<i>Стратегийн зорилго</i>	<i>64</i>
<i>Харилцаа холбоо</i>	<i>30</i>		
<i>Ялгаатай байдал</i>	<i>31</i>	6-р бүлэг. Ажиллагааны	
<i>Үр дүн.....</i>	<i>31</i>	төлөвлөлтийн үе шат.....	68
<i>Зарчмуудыг ерөнхийд нь</i>		<i>Мэдлэг</i>	<i>69</i>
<i>хэрэгжүүлэх</i>	<i>32</i>	<i>Эрсдэлийн үнэлгээ</i>	<i>70</i>
<i>Олон янз ба тэгш байдал</i>	<i>32</i>	<i>Дэмжлэг үзүүлэх.....</i>	<i>72</i>

Харилцаа холбоо	74	IV Хэсэг	
Ялгаатай байдал	75	Жагсаал, цуглааны дараа	123
Болзошиггүй нөхцөл байдал.....	75	10-р бүлэг. Практик асуудлуудыг	
Үйл ажиллагааны хувилбарууд.....	76	шийдвэрлэх	124
Цагдаагийн чиг үүрэг.....	78	Нөөцийн менежмент.....	124
Нөөц ба тусгай хэрэгсэл	85	Хүч хэрэглэсэн тухай тайлагнах....	125
Зэвсэг хэрэгсэл.....	88	Цагдаагийн алба хаагч гэмтэж	
Усан хөөрөг.....	90	бэртэх.....	125
		Тоног төхөөрөмж, хэрэгслийг	
7-р бүлэг. Тактикийн		буцаах.....	125
төлөвлөлтийн үе шат	98	Баривчлагдсан хүмүүс.....	126
Мэдлэг	98	11-р бүлэг. Мэдээлэл солилцох	
Дэмжлэг үзүүлэх.....	99	ба суралцах.....	128
Харилцаа холбоо	101	Мэдээлэл солилцох хурлын	
Ялгаатай байдал	103	төрлүүд	128
		Сурсан сургамж.....	132
III Хэсэг		Хавсралт	137
Жагсаал, цуглааны дундуур.....	105	Нэр томъёоны тайлбар.....	137
8-р бүлэг. Жагсаал, цуглаанд		Жагсаал, цуглааны өмнө,	
дэмжлэг үзүүлэх	106	дундуур, дараа командлалын	
Мэдлэг	106	түвшин тус бүрийн хүлээх үүрэг	
Дэмжлэг үзүүлэх.....	107	хариуцлагыг нэгтгэн тоймлосон	
Харилцаа холбоо	108	байдал	140
Ялгаатай байдал	109	Ашигласан ном зүй, хэрэгтэй	
Цагдаагийн зан байдал.....	110	холбоосууд.....	144
Аяндаа бий болдог жагсаал,			
цуглаан.....	111		
Оролцогчдод явах боломжийг			
олгох.....	113		
9-р бүлэг. Эмх замбараагүй			
байдал, хүчирхийллийг			
удирдах.....	116		
Хурцадмал байдлыг намжаах.....	117		
Албадан саатуулах.....	118		
Жагсаал, цуглааныг тараах	119		

Талархал

ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ) нь энэхүү «Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага»-ыг боловсруулахад мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэлээ зориулсан Хэв журам сахиулах олон улсын зөвлөх Аллан Жонс (Их Британи)-д гүн талархал илэрхийлж байна.

Мөн АИХЭГ болон ЕАБХАБ-ын Үндэстэн дамнасан аюул заналтай тэмцэх газар (TNTD/SPMU)-ын дэргэдэх Хэв журам сахиулах стратегийн асуудал эрхэлсэн албаны зүгээс уг удирдамжийн төслийг боловсруулахад үнэтэй санал зөвлөмж өгч, хувь нэмрээ оруулсан Жагсаал, цуглаан хийх эрхийн чиглэлээр ажилладаг шинжээчдийн зөвлөл болон бусад мэргэжилтнүүдэд гүнээ талархаж байна. Үүнд:

Отто Аданг, Нидерландын Цагдаагийн академийн Нийтийн хэв журам хариуцсан албаны дарга, Нидерланд;

Анжа Биенерт, Эмнести интернэшнл, Цагдаа ба хүний эрхийн хөтөлбөр, Нидерландын хэлтэс, АИХЭГ-ын Жагсаал, цуглаан хийх эрхийн асуудлаарх шинжээчдийн зөвлөл;

Томас Кайсар, ХБНГУ-ын Цагдаагийн газар, Үндэсний цагдаагийн товчоо, ХБНГУ;

Иан Чаппелл, Цагдаагийн ахлах ажилтан (чөлөөнд гарсан), Нийслэлийн цагдаагийн газар, Их Британи;

Давид Гөүлдбергер, АНУ-ын Охайо мужийн Их Сургуулийн Эрх зүйн хүндэт профессор, АИХЭГ-ын Жагсаал, цуглаан хийх эрхийн асуудлаарх шинжээчдийн зөвлөл;

Майкл Хамилтон, Их Британийн Зүүн Английн Их Сургуулийн Олон нийтийн эсэргүүцлийн тухай хуулийн ахлах багш, АИХЭГ-ын Жагсаал, цуглаан хийх эрхийн асуудлаарх шинжээчдийн зөвлөл;

Эддий Хендрикс, Олон улсын цагдаагийн шинжээч, Бельги;

Салли Жаксон, Жендэрийн шинжээч, «Хамтдаа зогсъё» ТББ, Их Британи;

Нэйл Жарман, Их Британий Зөрчилдөөн судлалын хүрээлэнгийн захирал, АИХЭГ-ын Жагсаал, цуглаан хийх эрхийн асуудлаарх шинжээчдийн зөвлөл;

Андре Конзе, Германы Цагдаагийн Их сургуулийн Цагдаагийн шинжлэх ухааны судалгаа, цаашдын сургалтын алба, Герман;

Катарзина Лопусзинска, Польш Улсын Үндэсний цагдаагийн газрын Ажиллагаа ба хямралын удирдлагын командлагч;

Мануэль Августо Магина да Сильва, Португалийн Цагдаагийн Газрын дарга, Португал;

Зоран Мисик, Сербийн Цагдаагийн удирдах газрын даргын туслах, Сербийн Цагдаагийн Газар;

Аннеке Оссе, Кени улсын цагдаа, хүний эрхийн зөвлөх;

Сергей Остаф, Молдавын Хүний эрхийн төвийн захирал (CReDO), АИХЭГ-ын Жагсаал, цуглаан хийх эрхийн асуудлаарх шинжээчдийн зөвлөл;

Ралф Прайс, АНУ-ын Чикаго хотын Цагдаагийн газар, Орлогч дарга, Ерөнхий зөвлөх;

Мартина Шрайбер, Олон нийтийн хэв журам сахиулах, олон нийт хариуцсан мэргэжилтэн, Герман;

Гилберт Синискалко, Францын Үндэсний цагдаагийн газрын Комендант, Франц;

Мартин Свенссон, Шведийн Үндэсний цагдаагийн газар, Швед;

Гайри Вайт, Их Британийн Ince групп, үйл ажиллагаа эрхэлсэн захирал.

Өмнөх үг

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичиг зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдсан хүний үндсэн эрх юм. Энэ нь ардчилсан нийгмийн үндэс суурь болж, хүн бүрт өөрийн санал нийлэхгүй, эсвэл өөр үзэл бодолтой байгаа талаараа олон нийтэд илэрхийлэх боломжийг олгодог. Улс орнууд энэ эрхийг хүндэтгэж, хамгаалж, биелүүлэх үүрэгтэй. Тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх нь тухайн жагсаал, цуглаан тайван байсан цагт л баталгаажна. Хууль бус хэдий ч тайван жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогч хүмүүс холбогдох хууль ёсны шаардлагыг биелүүлж чадаагүй байж болох ч тэрхүү жагсаал, цуглаан нь бусад тайван жагсаал, цуглаантай адил түвшний хамгаалалтыг эдэлнэ.

Жагсаал, цуглаан зохион байгуулахад цагдаагийн үүрэг оролцоо нэн чухал. Цагдаагийн байгууллага нь төрийн эрх мэдлийн хамгийн тод илэрхийлэл болдог учраас төрийн хууль дээдлэх, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг амлалтыг харуулж байдаг. Цагдаа нь өөрөө аяндаа болон өөр хоорондоо хамааралгүй ч нэгэн зэрэг зохион байгуулагдах цуглаан, эсэргүүцлийн жагсаал зэрэг бүх тайван жагсаал, цуглаанд хэв журам сахиулан, цуглаанд оролцогчдыг хамгаалж, тэдэнд зорилгот бүлэгтээ харагдаж, сонсогдох зайнд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох ёстой. Энэхүү гарын авлагаар дамжуулж жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулахдаа жагсаал, цуглааныг аюул занал учруулж болзошгүй үйл явдал гэж үзэх биш, харин цагдаагийн байгууллагын хүндэтгэж, хамгаалах ёстой хүний чухал эрхийн илэрхийлэл гэж хүлээн зөвшөөрөх хүртэл цагдаагийн алба хаагчдын сэтгэлгээнд өөрчлөлт гаргахыг хөхиүлэн дэмжихийг зорилоо. Ер нь жагсаал, цуглааны дийлэнх нь тайван замаар явагддаг бөгөөд олон нийтийн дэг журамд ямар нэгэн саад бэрхшээл учруулаад байдаггүй. Гэхдээ жагсаал, цуглаантай холбоотой аливаа зөрчил мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх, хурцадмал байдлыг намжаахын тулд цагдаагийн байгууллага сайтар бэлтгэгдэж сургагдсан байх нь нэн чухал юм.

Энэхүү гарын авлага нь жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хүрээнд ЕАБХАБ-ын хүлээсэн үүрэг амлалтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж

буй АИХЭГ-ын өргөн хүрээтэй ажлын нэг хэсэг юм. АИХЭГ нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудад болж буй олон нийтийн жагсаал, цуглаанд мониторинг хийж, улмаар холбогдох санал дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан гаргадаг ба үүнд жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах тухай асуудал багтана. Европын Зөвлөлийн Хуулиар дамжуулан ардчиллыг тогтоох Европын Комисс (Венецийн Комисс)-тай хамтран хэвлүүлсэн *АИХЭГ-ын Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх удирдамж* нь олон улсын хүний эрхийн стандартуудын хэрэгжилтийг үнэлэх гол жишиг, лавлагаа баримт бичиг юм. Эдгээр баримт бичгийг боловсруулахад АИХЭГ-ын Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх шинжээчдийн зөвлөлийн гишүүн, хараат бус шинжээчдэд талархах нь зүйтэй. Бид ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудын нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй холбоотой хуулийн дүгнэлт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаандаа тэдний туршлага, объектив дүгнэлтэд түшиглэх болно.

Энэхүү гарын авлага нь мөн ЕАБХАБ-ын Үндэстэн дамнасан аюул заналтай тэмцэх газар (TNTD/SPMU)-ын дэргэдэх Стратегийн цагдаагийн асуудал эрхэлсэн алба, АИХЭГ-тай хамтран боловсруулсан ардчилсан зарчмаар хэв журам сахиулах зарчим, сайн туршлагын талаарх цуврал гарын авлагуудын нэг болно. Энэхүү гарын авлагад тусгагдсан жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой сайн туршлагуудыг ЕАБХАБ-ын бүс нутагт түгэн дэлгэрч, цагдаагийн байгууллагууд өргөнөөр ашиглана гэдэгт найдаж байна.

Майкл Георг Линк
АИХЭГ-ын Захирал

Танилцуулга

Эсэргүүцлээ илэрхийлэх, жагсаал цуглаан хийх, баяр ёслол тэмдэглэх, дурсан санах, мөн өөрийн үзэл бодлоо эрх баригчдад болон бусад иргэдэд нийтээрээ илэрхийлэх зорилгоор тайван замаар цугларах эрх нь ардчилсан тогтолцооны гол тулгуур юм. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө зэрэг ардчилал, олон ургалч үзлийн бусад тулгын чулуутай нягт холбоотой. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг олон улсын хүний эрхийн олон баримт бичигт тусгаж, 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичигт баталгаажуулсан.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хангах нь эрх баригчдад хүндрэлтэй байж болох юм. Энэ нь ялангуяа жагсаал, цуглаан болж байхад бусдын эрх, эрх чөлөөнд саад учруулахгүйгээр нийтийн хэв журмыг сахиулах үндсэн үүрэгтэй цагдаагийн байгууллагын хувьд ихээхэн хүндрэлтэй байдаг.

Энэхүү гарын авлага нь тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хангахад нь цагдаагийн байгууллагад удирдамж өгөх зорилготой. Уг гарын авлагыг голчлон ЕАБХАБ-ын бүс нутагт олон нийтийн жагсаал, цуглаанд хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэн, аль ч түвшинд ажиллах цагдаагийн алба хаагч нарт зориулан бичсэн болно. Гарын авлагад тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зохицуулан дэмжихийг гол зорилгоо болгон, зохистой бөгөөд эмх журамтай хэв журам сахиулахад баримтлах үндсэн алхмууд болон зарчмуудыг тодорхойлж өглөө. Уг гарын авлага нь олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид тавигддаг шаардлагууд болон ЕАБХАБ-ын бүс нутаг даяар тогтсон сайн туршлага дээр үндэслэн жагсаал, цуглааныг амжилттай зохион байгуулах удирдамжаар хангана. Хэдийгээр гарын авлагын үндсэн сэдэв нь «жагсаал, цуглаан» гэж байгаа боловч энд тусгасан удирдамж, санал болгож буй арга туршлагыг бусад төрлийн жагсаал, цуглаан (жишээ нь, төрийн арга хэмжээ, спортын арга хэмжээ г.м) дээр авч хэрэгжүүлэх боломжтой.

Энэхүү гарын авлагад цагдаагийн байгууллага аливаа арга хэмжээг болохоос нь өмнө төлөвлөх, бэлтгэл ажлыг хангахад цаг хугацаа, нөөц

бололцоогоо зарцуулахын ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ. Энэ нь тухайн арга хэмжээг зохион байгуулагчдынх нь хүссэнээр, гэхдээ бусдын эрх, эрх чөлөөнд аль болох саад болохгүйгээр явуулахыг баталгаажуулж өгөхөд нэн чухал юм. Ийм арга барилаар ажиллах нь хүчирхийлэл, олон нийтийн эмх замбараагүй байдал үүсэх эрсдэлийг бууруулж, цагдаад итгэх олон нийтийн итгэлийг бий болгоход тустай. Энэхүү нөөц бололцооны гол цөмд цагдаагийн байгууллага мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахын тулд олон нийтийн арга хэмжээнд бэлтгэх, түүнийг зохицуулан хэв журам сахиулах бүх үе шатандаа анхаарч авч үзэх ёстой мэдлэг, харилцаа холбоо, дэмжлэг үзүүлэх, ялгаатай байдал гэсэн дөрвөн зарчим оршиж байдаг.

Уг гарын авлага нь цагдаагийн байгууллагын удирдлагад олон нийттэй харилцах, мөн үйл ажиллагаагаа төлөвлөх талаар удирдамж чиглэл өгнө. Үүнд тушаалын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, шийдвэр гаргах талаар авч үзнэ. Мөн янз бүрийн жагсаал, цуглаан дээр хэв журам хэрхэн сахиулах, жагсаал цуглаан доторх хувь хүмүүс, бүлгүүдийн зан үйлтэй холбоотой ямар тактик баримтлах талаарх зааварчилгаагаар хангана. Түүнчлэн хэв журам сахиулах зорилго, зорилтуудыг авч үзэхийн зэрэгцээ олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн хүрээнд цагдаагийн байгууллагын хүч хэрэглэх параметр буюу хэмжүүрийг тодорхойлж өгсөн.

Энэхүү бүтээлд урьдчилан төлөвлөсөн болон аяндаа бий болсон жагсаал цуглааны талаар авч үзсэн бөгөөд ийм арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэв журам сахиулах талаар зааварчилгаа өглөө. Үүнд үйл явдал болоод өнгөрсний дараа хийгдэх арга хэмжээ, мөн гүйцэтгэлээ үнэлж дүгнэхдээ ямар зохион байгуулалтаар ажиллах талаар авч үзэх бөгөөд энэ нь хэв журам сахиулах цааш цаашдын үйл ажиллагааг сайжруулах, сайн туршлагыг нэвтрүүлэх боломжийг олгосон. Гарын авлагад дурдсан олон арга барил нь зарим улс орны нөхцөлд танил, мэддэг арга тактикууд байж болох ч заримд нь тийм ч түгээмэл биш байх магадлалтай. Мөн энд тусгагдсан бүх арга тактик нь ЕАБХАБ-ын хэд хэдэн гишүүн улс орнуудын жагсаал, цуглааны хэв журам сахиулахдаа хэрэглэдэг цагдаагийн байгууллагын сайн туршлагуудыг тусгаснаас гадна ардчилсан зарчмаар хэв журам сахиулахад суурилсан учраас бүс нутгийн хэмжээнд цагдаагийн байгууллага авч ашиглахад хялбар байх ёстой. Энэхүү гарын авлагыг олон жилийн туршлагатай цагдаагийн дарга удирдлагууд боловсруулж, жагсаал, цуглаан хийх эрхийн чиглэлээр мэдлэг боловсролтой цагдаагийн удирдлагууд болон хүний эрхийн мэргэжилтнүүдийн хамтарсан үнэлгээний хэд хэдэн үе шатыг дамжин хянагдсан болно.

АИХЭГ нь жагсаал, цуглааныг олон улсын хүний эрхийн стандартын дагуу зохицуулж, хэв журам сахиулж буйг баталгаажуулах үүднээс ЕАБХАБ-ын гишүүн орнуудад хууль тогтоомжийн чиглэлээр болон бусад туслалцааг идэвхтэй үзүүлдэг. Энэхүү гарын авлага нь уг ажлын хүрээнд хийгдсэн ба гишүүн улс орнуудад тайван жагсаал, цуглаан хийх эрхийн талаар хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор боловсруулсан болно. Уг гарын авлагыг АИХЭГ-аас санал болгодог сургалт дагалддаг бөгөөд сургалт нь цагдаагийн алба хаагчдад зориулан ажлын байран дээр нь анхан шатны болон давтан сургалтуудыг зохион байгуулж, жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулахад бэлтгэх, үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

I Хэсэг

ТОДОРХОЙЛОЛТ, ЗАРЧИМ, БОДЛОГО

1-Р БҮЛЭГ. ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь хүний үндсэн эрх, тийм ч учраас ардчилсан нийгмийн тулгын чулууны нэг гэж үздэг. Энэ хэсэгт уг эрхийг үндэслэсэн зарим үндсэн зарчмуудыг тоймлон тайлбарлаж, олон нийтийн жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад оролцдог цагдаагийн байгууллагын зарим үүрэг хариуцлагыг онцлон авч үзлээ.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь нь олон улсын хүний эрхийн бүх гол баримт бичигт тусгагдсан байдаг. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйл (1948);
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйл (1966);
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенцийн 11 дүгээр зүйл (1950);
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 15 дугаар зүйл (1989).

ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичиг (1990)-т ЕАБХАБ-ын гишүүн орнууд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хүндэтгэх үүрэг хүлээсэн.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь бүх хувь хүн, нийгмийн бүлэг, бүртгэлгүй холбоод, хуулийн этгээд, аж ахуйн нэгжид хамаарна. «Үндэс угсаа», арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн болон бусад статус зэрэг дээр нь үндэслэн аливаа ялгаварлан гадуурхлыг хориглоно. Хүмүүсийн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлахад чиглэсэн эдгээр үндэслэлээр ялгаварлан гадуурхах нь олон улсын хүний эрхийг зөрчсөн гэж үздэг.

Олон улсын баримт бичигт жагсаал, цуглаан хийх эрхийн зарчмыг өргөн хүрээнд тодорхойлсон хэдий ч үүнийг ихэвчлэн улс орны үндсэн хуулиар дахин баталгаажуулж, дотоодын хууль тогтоомжоор илүү тодорхой зааж өгдөг бөгөөд эдгээр нь жагсаал цуглаан хийх эрхийг зохицуулахтай холбоотой журмуудад илүү дэлгэрэнгүй тусгагдсан байдаг.

ЕАБХАБ/АИХЭГ болон Венецийн комиссын *Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн тухай удирдамж*¹ (цаашид *Удирдамж* гэх)-ид жагсаал, цуглааныг

1 *Тайван жагсаал цуглаан хийх эрхийн тухай удирдамж*, 2 дахь хэвлэл, (Варшав: ЕАБХАБ/АИХЭГ/Венецийн Комисс, 2010), <<http://www.osce.org/odihr/73405>>.

тодорхойлохдоо жагсаал, цуглаан гэдэг нь хэн нэгэнд ямар нэг зүйлийн талаар хэлэх зүйлээ дамжуулах зорилготой арга хэмжээ гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр жагсаал, цуглаан нь ихэвчлэн түр зуурын шинж чанартай байдаг ч хагас-байнгын бүтэцтэйгээр хэдэн сарын турш ч үргэлжлэх боломжтой. Жагсаал, цуглааны тодорхой хэлбэрүүд нь эрх зүйн зохицуулалтын хувьд өөр өөр асуудлуудыг үүсгэж болох ч хөдөлгөөнгүй, хөдөлгөөнтэй бүх төрлийн тайван жагсаал, цуглааныг зохицуулах ёстой.

Жагсаал, цуглаан нь баяр тэмдэглэх, үйл явдлыг тэмдэглэн өнгөрүүлэх, эсэргүүцэх гэх зэрэг олон янзын зорилготой байж болно. Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэх нь хамтын үзэл бодлоо дамжуулах, саналаа илэрхийлэх хэрэгсэл юм. Үүнд олон янзын, шүүмжлэлт, радикал буюу эрс шинэчлэлт, нийтлэг бус болон цөөнхийн зэрэг олон үзэл бодлын илэрхийлэл ордог. Радикал болон цөөнхийн үзэл бодлыг илэрхийлэх нь нийгмийн бусад гишүүдэд тодорхой хэмжээгээр доромжлон халдаж байгаа мэт болов ч, үйл ажиллагаа нь тайван хэвээр байгаа цагт хамгаалж, зохицуулах ёстой.

Жагсаал, цуглааны нэлээдгүй нь өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой хэмжээний саад учруулдаг; зам, гудамж талбайг эзлэх, эсвэл замын хөдөлгөөн, явган зорчигч, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй. Үндсэн эрх чөлөөгөө хэрэгжүүлэхээс үүдэлтэй ийм саад тасалдалд ямар нэг хэмжээгээр хүлээцтэй хандах ёстой. Нийтийн эзэмшлийн талбай нь бусад төрлийн үйл ажиллагаа явуулахтай адил хүмүүсийн жагсаж, цуглах боломжтой газар гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд тийм ч учраас энэхүү жагсаж, цуглах эрхийг зохицуулж өгөх ёстой.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь соёл, нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлийг хадгалах, хөгжүүлэх, мөн түүнд сорилт авчрах чухал элемент юм. Энэ нь цөөнхийн өвөрмөц байдлыг хадгалах, илэрхийлэх, засгийн газарт хариуцлага тооцоход чухал ач холбогдолтой. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгаалах нь нийгмийн янз бүрийн бүлгүүд хамтдаа энх тайвнаар оршин тогтнох хүлээцтэй, олон ургальч нийгмийг бий болгоход маш чухал юм.

Олон улсын хүний эрхийн зарчмуудад төр, түүний төлөөлөгч нь хүний бүх эрхийг хүндэтгэж, хамгаалах үүрэг, хариуцлага хүлээдэг гэдгийг тодорхой заадаг. Үүнд:

- Хүмүүсийн эрхийг хязгаарлахад саад учруулахгүй байх үүрэг («сөрөг» үүрэг);

- Хүмүүсийн эрхийг хамгаалах, зохицуулахын тулд шаардлагатай арга хэмжээг авах үүрэг («эерэг» хариуцлага).

Жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэхэд уг эрхийг хамгаалах, зохицуулах үндсэн үүрэг нь нийтийн хэв журмыг сахиулах үндсэн эрх бүхий байгууллага болох цагдаагийн байгууллагад оногддог. Үүнд өдөр тутмын үйл ажиллагаа, ялангуяа жагсаал, цуглаанд оролцогч бус хүмүүсийн амьдралд тодорхой хэмжээгээр саад, тасалдал учруулж болзошгүй өдөөн хатгасан, доромжилсон өнгө аястай тайван жагсаал, цуглааныг хамгаалах үүрэг хариуцлага ч багтана. Хэрэв тайван жагсаал, цуглаан нь бусдын эрх, эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцож байгаа тохиолдолд эдгээр эрхийг хүндэтгэх явдлыг жагсаж, цуглаж буй иргэдийн эрхтэй тэнцвэржүүлэн зохицуулах нь цагдаагийн байгууллагын үүрэг байх болно.

Жагсаал, цуглаан хийх эрх нь тайван замаар жагсаж, цуглах эрх юм. Жагсаал, цуглаан хийх эрхээ эдлэхдээ хүчирхийлэл үйлдэх эрх байхгүй. Хэрэв хэн нэгэн хүн жагсаал, цуглаанд оролцож байхдаа хүчирхийлэл үйлдэж байгаа бол тэр хүний эдлэж байгаа эрх нь хуулиар хамгаалагдсан хүний эрх биш юм. Гэсэн хэдий ч, ийм хүмүүсийн үйлдэж буй хүчирхийлэл нь тайван хэвээр байгаа хүмүүсийн жагсаж цугларах эрхийг хөндөх ёсгүй.

Тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх нь доромжилсон үг хэллэгийг агуулж болох ч бусдыг айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэхэд чиглэсэн жагсаал, цуглаан, үйл хөдлөлд төрөөс хууль ёсны дагуу шаардлагатай, тохирсон хязгаарлалт, хоригийг тавьж болно.

Жагсаал, цуглаан зохион байгуулагч, эсвэл оролцогч хувь хүмүүс нь жагсаал, цуглаанд тавигдах хууль ёсны шаардлагыг дагаж мөрдөөгүй байж болох ч энэ нь дангаараа цагдаагийн байгууллагын тайван амгалан үргэлжилж байгаа жагсаал, цуглааныг хамгаалах, зохицуулах үүргээс нь чөлөөлөхгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Жагсаал, цуглаанд тавигдах хуулийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан хувь хүмүүст тохирох арга хэмжээ, шийтгэлийг ногдуулах замаар шийдвэрлэж болно.

Жагсаал, цуглааны төрлүүд

Тайван жагсаал, цуглаан хийх эрхэд хамаарах олон нийтийн цугларалтын олон янзын хэлбэр байдаг. Эдгээр нь хурал, цуглаан, хаалт, жагсаал, явган жагсаал, ёслол, парад, гэнэтийн цугларалт буюу флаш моб зэрэг болно.

Тайван жагсаал, цуглаан: Зохион байгуулагчдын санаа зорилго тайван, оролцогчдын зан байдал тайван амгалан байвал уг жагсаал, цуглааныг тайван гэж үзэх ёстой. Тухайн арга хэмжээг зохион байгуулж байгаа, эсвэл оролцож байгаа хүмүүс өөрсдөө хүчирхийллийг ашиглах, сурталчлах, өдөөх санаатай байгааг нотлох, нотлохуйц нотлох баримт байхгүй л бол уг жагсаал цуглааныг тайван санаа зорилго, төлөв байдалтай байна гэж үзэх ёстой. «Тайван» гэсэн нэр томъёог ойлгохдоо бусдыг доромжилж гомдоох, тэр ч байтугай гуравдагч этгээдийн үйл ажиллагааг түр зуур тасалдуулж, саад учруулахуйц зан үйлийг илэрхийлсэн хандлагуудыг ч багтаан тайлбарлах ёстой². Жагсаал, цуглаан зохион байгуулагчид нь хуульд заасан бүх шаардлагыг биелүүлээгүй байсан ч тухайн жагсаал, цуглааныг тайван гэж үзэж, эрх баригчдын зүгээс зохицуулж өгөх ёстой. Хуульд заасан шаардлагыг дагаж мөрдөөгүй байх нь жагсаал, цуглааныг саатуулах, тасалдуулах, зогсоохыг оролдох шалтаг болох ёсгүй.

Үзэн ядалт, хүчирхийлэл, дайн тулааныг өдөөн хатгасан, мөн бусдын эрхийг зориудаар хязгаарлах, үгүйсгэх зорилготой, холбогдох хууль тогтоомжийг зөрчин бусдыг айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх зорилготой жагсаал, цуглааныг хамгаалалт авах жагсаал, цуглаанд тооцохгүй. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлд «Дайныг сурталчлах аливаа үйл ажиллагааг хуулиар хориглох бөгөөд ялгаварлан гадуурхах, дайсагналцах, хүчирхийлэлд турхирсан үндэстэн, арьс өнгө, шашны сэдэлтэй үзэн ядалтыг сурталчлах аливаа үйл ажиллагааг хуулиар хориглоно» гэж заасан байдаг³.

Эрх баригчид болон цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан хийх эрх нь хувь хүний эрх бөгөөд хэн нэгэн хувь хүн, цөөн тооны хүмүүсийн хэл амаар болон бие махбодиор үзүүлж буй түрэмгийлэл, хүчирхийлэл нь тайван замаар жагсаж, цуглаж байгаа бусад хүмүүсийн эрхийг тасалдуулах

2 Өмнөх зүүлт тайлбарт дурдсан.

3 *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ICCPR), (Нью-Йорк хот: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, 1966), 2200А (XXI) тогтоол, <<http://www.ohchr.org/en/professionalinterest/pages/ccpr.aspx>>.*

ёсгүй гэдгийг санах хэрэгтэй. Тайван жагсаал, цуглааны үйл ажиллагаа нь бусдын эрх, эрх чөлөөнд нөлөөлж байгаа тохиолдолд эрх баригчид холбогдох бүх эрх, эрх чөлөөг тэнцвэртэй хангах байдлаар асуудлыг шийдвэрлэх ёстой. ЕАБХАБ-ын зарим гишүүн орнуудад ийм эрх мэдэл нь цагдаад байдаг бол, зарим улсад эдгээр асуудлыг тэнцвэртэй хангах үүрэг нь орон нутгийн эрх бүхий байгууллага, эсвэл шүүхэд байдаг.

Аяндаа бий болдог жагсаал, цуглаан: Энэ нь аливаа зөрчил, үйл явдалд хариу үйлдэл үзүүлэх байдлаар зохион байгуулагддаг жагсаал, цуглаан бөгөөд хуульд заасан урьдчилан мэдэгдэх ёстой гэсэн шаардлагыг биелүүлэх боломжгүй, эсвэл албан ёсоор хариуцсан зохион байгуулагч байдаггүй. Ийм жагсаал, цуглаан нь ихэвчлэн тухайн үйл явдал болсон даруйд болдог бөгөөд мэдэгдэл ав гэж шаардаж саатуулах нь хүмүүсийн хэлж дамжуулах гэсэн зүйлээ үр дүнтэй илэрхийлэх эрчийг сулруулж, эсвэл зогсоодог тул ийм жагсаал, цуглааныг барьж тогтоох чадвар их чухал байдаг.

«Аяндаа» гэсэн нэр томъёо нь жагсаал, цуглааныг зохион байгуулагчтай байхыг үгүйсгэхгүй ч, өөрөө аяндаа зохион байгуулагдах жагсаал, цуглаан нь тодорхой зохион байгуулагчгүй жагсаал, цуглаан ч байж болно. Ийм жагсаал, цуглаан нь урьдчилан зарласан мэдээлэл, урилгагүйгээр хэсэг бүлэг хүмүүс тодорхой газар цугларсан жагсаал, цуглаан ч байж болно. Ийм жагсаал, цуглаан нь ихэвчлэн чухал үйл явдал (гадаадын төрийн тэргүүний айлчлал г.м.)-ын талаар мэдээллийн хэрэгслээр, эсвэл нийгмийн сүлжээгээр гарсан мэдээллийн дагуу бий болсон байдаг. Жагсаал, цуглаанд оролцогчдын тоо хажуугаар нь өнгөрч яваад нэгдэх хүмүүсээс шалтгаалан олширч магадгүй ч, хүмүүс цугларч эхэлмэгц харилцаа холбооны янз бүрийн хэлбэр (утас, мессеж, амнаас ам дамжих, интернет, нийгмийн сүлжээ г.м.)-ээр дамжуулан мэдээлэл түгэн, жагсаал, цуглаан цааш өрнөж болно. Харилцаа холбооны ийм хэлбэрээр мэдээлэл түгээснийг урьдчилан зохион байгуулсны нотолгоо гэж ойлгож болохгүй. Ганцаараа жагсаж буй хүн дээр өөр нэг хүн, эсвэл хэсэг бүлэг хүмүүс нэгдэн нэмэгдэх тохиолдолд тухайн цугларалтыг аяндаа бий болсон жагсаал, цуглаантай адилтгаж үзэх ёстой. Аяндаа бий болсон жагсаал, цуглааныг «тайван жагсаал, цуглаан» гэсэн тодорхойлолтод багтаасан тохиолдолд үүнийг урьдчилж мэдэгдсний дагуу хийж байгаа жагсаал, цуглаантай ижил түвшний хамгаалалтаар хангах ёстой.

Нэгэн зэрэг болдог жагсаал, цуглаан: Нэг газар, нэг цагт харилцан хамааралгүй хоёр буюу түүнээс дээш жагсаал, цуглаан болох тухай мэдэгдэл өгөх тохиолдолд аль болох хоёуланг нь зохицуулах ёстой. Аль алиныг нь боломжийн байдлаар зохион байгуулахаар байвал аль нэг жагсаал,

цуглааныг өөр жагсаал, цуглаантай ижил цаг, ижил байршилд хийх гэж байна гэсэн үндэслэлээр хориглох нь тохиромжгүй юм. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын дагуу бол харьцуулж болохуйц нөхцөл байдалд байгаа жагсаал, цуглаанд ялгаатай хориг хязгаарлалт тулгахгүй байхыг шаарддаг. Энэ бол цагдаа болон зохион байгуулагчдын хоорондын харилцан ойлголцол, яриа хэлэлцээнээс хамаарч эрсдэлийг бууруулах, төлөвлөлтийн эхний шатанд нь асуудлыг шийдвэрлэж болохын нэг жишээ юм.

Хэрэв хоёр жагсаал, цуглааныг нэгэн зэрэг зохицуулах боломжгүй бол эхлээд мэдэгдэл өгсөн жагсаал, цуглааныг зорилгынх нь дагуу явуулахыг зөвшөөрөөд, нөгөө жагсаал цуглааныг нь ойролцоох байршилд, эсвэл зохион байгуулагч нарт нь тохиромжтой өөр цагт зохион байгуулахаар зохицуулах ёстой. Жагсаал, цуглааныг өөр газарт шилжүүлэх, эсвэл хойшлуулах шийдвэр гаргахдаа олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай: жагсаал, цуглааны хэмжээ, дуу өсгөгч, тээврийн хэрэгсэл ашиглах эсэх гэх мэт. Эдгээрээс гадна нэгэн зэрэг жагсаал, цуглаан хийх гэж байгаа бүлгүүдийг өмнө нь хүчирхийлэл гаргаж байсан түүхтэй эсэх талаар судалгаа хийх ёстой бөгөөд энэ нь тэдний жагсаж, цуглах эрхийг нь эдлүүлэхийн зэрэгцээ бүх талуудын аюулгүй байдлыг баталгаажуулах зорилготой.

Эсрэг жагсаал: Энэ нь өөр жагсаал, цуглаан дээр илэрхийлсэн үзэл бодлыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлэхээр гарч ирсэн, нэгэн зэрэг болдог жагсаал, цуглааны тодорхой нэг хэлбэр юм. Эсрэг жагсаал гарах тохиолдолд жагсаал, цуглаан бүрийг хамгаалж, дэмжих төрийн үүргийг онцлон анхаарах хэрэгтэй. Нэгэн зэрэг болдог ийм жагсаал, цуглаануудыг аль болох нөгөө талын нүдэнд нь харагдаж, чихэнд нь сонсогдох байдлаар зохицуулахын тулд хэв журам сахиулах цагдаагийн байгууллагын нөөцийг төрөөс хангалттай бүрдүүлэх ёстой.

Гэхдээ эсрэг жагсаал хийх эрх нь бусдын жагсаал, цуглаан хийх эрхийг боогдуулах ёсгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Засаг захиргааны байгууллагын зүгээс нөгөө жагсаал, цуглааныг нь хамгаалах үүднээс тэдний эсрэг жагсаал хийж байгаа жагсагчдын нөгөө талын нүдэнд нь харагдаж, чихэнд нь сонсогдох эрхийг хууль ёсны дагуу хязгаарлах нөхцөл байдал үүсэж болно.

Хүчирхийлэл ба жагсаал, цуглаан

Жагсаал, цуглаан хийх эрх нь тайван жагсаал, цуглаан хийх эрх юм. Гэвч цөөн тооны хүмүүсийн хүч хэрэглэж буй үйлдлийг бусдын тайван замаар

илэрхийлж буй зан үйлээс ялгаж салгах хэрэгтэй бөгөөд тайван хэвээр жагсаал, цуглаанаа үргэлжлүүлж буй хүмүүсийн эрхийг хасч болохгүй гэдгийг дахин тэмдэглэх нь зүйтэй.

Жагсаал, цуглааны үеэр хувь хүмүүс, эсвэл цөөн тооны бүлэг хүмүүс хүчирхийлэл үйлдэж байгаа бол цагдаагийн байгууллагын авч буй хариу арга хэмжээ нь уг үйлдэлд нь тохирсон байх ёстой гэдгийг заавал баталгаажуулах ёстой бөгөөд жагсаал, цуглаанд оролцогчдод ерөнхий анхаарал хандуулахаас илүүтэй хүчирхийлэл үйлдэж буй хүмүүст анхаарлаа хандуулах ёстой. Ялангуяа цагдаагийн алба хаагчид, хувь хүмүүс, өмч хөрөнгө, жагсаал цуглаанд оролцогчид болон сөрөг хүчин гэж тооцогдож буй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл үйлдэж байгаа тохиолдолд илүү хүчинтэй.

Жагсаал, цуглаанд оролцогчдын эсрэг хүч хэрэглэсэн аливаа үйлдэл нь оролцогчдын зүгээс уурлаж бухимдах, хариу түрэмгий үйлдэл үзүүлэхэд хүргэх бөгөөд энэ нь зөвхөн нөхцөл байдлыг улам хурцатгана гэдгийг цагдаа үргэлж санаж байх ёстой. Иймд цагдаагийн байгууллага авах гэж байгаа арга хэмжээнийхээ зорилго, төлөвлөгөөг ил тод, нээлттэй мэдээлэх хэрэгтэй. Хүч хэрэглэхийн өмнө аль болох урьдчилан сануулж, сэрэмжлүүлэх шаардлагатай.

Оролцож буй бүх хүнд тайван жагсаал, цуглаан хийх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангуулахын тулд жагсаал, цуглаанд оролцож буй тодорхой бүлэгт хамаарах хүмүүсийн хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, гарал үүсэл, шашин шүтлэг, үндэс угсаа, бэлгийн чиг баримжаа зэргээс нь шалтгаалан тэдний эсрэг дайралт гарч болзошгүй гэдэгт цагдаагийн байгууллага үргэлж сонор сэрэмжтэй хандах ёстой.

Жагсаал, цуглааныг хязгаарлах

Тайван жагсаж, цуглах эрх чөлөөг хамгаалах, дэмжих төрийн үүрэг нь үндэсний аюулгүй байдал, нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд болон бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс тайван жагсаал, цуглааныг хязгаарлаж, хууль ёсны үндэслэлээр зохицуулах боломжгүй гэсэн үг биш юм. Гэсэн хэдий ч ийм хязгаарлалт нь зайлшгүй шаардлагын улмаас, мөн тохирсон байх ёстой. Өөрөөр хэлбэл, хязгаарлалтыг нийгмийн тулгамдсан хэрэгцээг хангахын тулд маш нарийн тохируулсан байх ёстой. Иргэний болон улс төрийн эрхийн тухай

олон улсын пактын 21-р зүйл (ICCPR)-д жагсаал, цуглааныг хязгаарлах үндэслэлийг дараах байдлаар заасан байдаг. Үүнд:

«Энэ эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний аюулгүй байдал, нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам (*ordre public*), нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зэргээр хуульд нийцүүлэн заасан, мөн нийтийн эрх ашгийг хамгаалах ашиг сонирхолд нийцүүлэн аливаа ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай хязгаарлалтаас өөр хязгаарлалт тавьж болохгүй.»⁴

Хязгаарлалтыг жагсаал, цуглаан болохоос өмнө, жагсаал, цуглааны үеэр, эсвэл аль алинд нь тавьж болно. Зарим улсад жагсаал, цуглаан болохоос өмнө цагдаагийн байгууллага хязгаарлалт тогтоох үүрэг хүлээдэг бол, зарим улс оронд энэ эрх мэдэл нь орон нутгийн засаг захиргаа, шүүх гэх мэт эрх мэдэл бүхий өөр байгууллагад байдаг. ЕАБХАБ-ын бүс нутаг дахь бүх улс оронд цагдаагийн байгууллага жагсаал, цуглааны үеэр зохих хязгаарлалт тавих эрхтэй байгаа боловч аливаа ардчилсан нийгэмд ийм хязгаарлалт нь үргэлж хууль ёсны, зайлшгүй шаардлагын улмаас, мөн тохирсон байх ёстой.

Жагсаал, цуглаанд хязгаарлалт тавих эсэхийг авч үзэхдээ цагдаагийн байгууллагын анхаарах ёстой дараах үндсэн зарчмуудыг *Удирдамжид* тусгасан болно.⁵

Жагсаал, цуглааныг дэмжих үзэл хандлага: Хүний суурь, үндсэн эрх болохын хувьд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь аль болох зохицуулалтгүйгээр хэрэгжих ёстой. Хуулиар илэрхий хориглоогүй аливаа зүйлийг зөвшөөрнө гэж үзэх ёстой бөгөөд жагсаж, цугларахыг хүссэн хүмүүсээс зөвшөөрөл авахыг шаардах ёсгүй. Энэхүү эрх чөлөөг дэмжсэн үзэл хандлагыг хуульд тодорхой бөгөөд илэрхий зааж өгөх ёстой.

Тайван жагсаал, цуглааныг зохицуулах, хамгаалах эерэг үүрэг хариуцлага: Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг бодитоор эдлүүлэх, хүнд суртлын шаардлагагүй зохицуулалтуудаар дарахгүйн тулд төрийн зүгээс зохих механизм, процедуруудыг бий болгож өгөх ёстой. Ялангуяа зохион байгуулагчдын хүссэн цаг, газар, арга хэлбэрээр нийтийн

4 Өмнөх зүүлт тайлбарт дурдсан.

5 *Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай удирдамж, иш татсан бүтээлд*, тэмдэглэл 1.

жагсаал, цуглааныг зохион байгуулахад төрөөс зохицуулж, хамгаалахыг байнга эрмэлзэхийн зэрэгцээ төлөвлөж буй жагсаал, цуглааныг нийтэд сурталчилан, мэдээлэл түгээх хүчин чармайлтад саад учруулахгүй байх ёстой.

Хууль ёсны байдал: Аливаа хязгаарлалт нь хууль ёсны үндэслэл бүхий байх ёстой бөгөөд олон улсын хүний эрхийн баримт бичигт нийцсэн байх ёстой. Сайн боловсруулсан хууль тогтоомж нь эрх баригчдад олгох эрх мэдлийн хүрээг тодорхойлоход амин чухал юм. Аливаа хууль нь олон улсын хүний эрхийн стандартуудад нийцсэн байх ёстойгоос гадна тухайн хүнийг өөрийн үйлдлээ хууль зөрчсөн эсэх, хэрэв зөрчсөн бол зөрчлийн үр дагаврыг үнэлж дүгнэх боломжийг олгохуйц хангалттай нарийн тодорхой зааж өгсөн байх ёстой. Цаашилбал, холбогдох эрх бүхий байгууллагууд тухайн үйл явдлын үеэр тавьсан аливаа хязгаарлалт нь хуульд бүрэн нийцэж, эрх зүйн тогтсон зарчимтай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой. Эцэст нь, хуульд заагаагүй шийтгэлийг жагсаал, цуглааны дараа ногдуулахыг зөвшөөрөх ёсгүй.

Пропорциональ буюу тохирсон хэм хэмжээнд байх: Аливаа жагсаал, цуглаан хийх цаг, газар, арга хэлбэрт тавигдах аливаа хязгаарлалт нь пропорциональ буюу тохирсон хэм хэмжээнд байх ёстой. Эрх баригчдын зорьж буй хууль ёсны зорилгодоо хүрэх хамгийн бага хөндлөнгийн арга хэрэгсэлд ямагт давуу эрх олгох ёстой. Тохирсон хэм хэмжээнд байх зарчим нь аливаа үйл явдлын мөн чанарыг үндсээр нь өөрчлөх, тухайлбал, жагсаал, цуглааныг хотын төвлөрөл багатай хэсэгт шилжүүлэх, дуу хоолойгоо хүргэхийг зорьж буй хүмүүсийнх нь нүдэнд харагдах газраас холдуулах зэрэг хязгаарлалт тавихгүй байхыг эрх баригчдаас шаарддаг.

Зайлшгүй байдал: Ардчилсан нийгэмд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах нь үндэсний аюулгүй байдал, нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхолд зайлшгүй шаардлагатай байх ёстой. Зайлшгүй шаардлагатай эсэхийг нягтлахад тодорхой нөхцөл байдалд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах «нийгмийн хойшлуулшгүй хэрэгцээ» үүссэн эсэх нотолгоо байхыг шаарддаг.

Мэдэгдэл: Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу дотоодын хууль тогтоомжид жагсаал, цуглаан хийх талаар урьдчилан мэдэгдэх шаардлагагүй байдаг. Тэр ч байтугай, аливаа нээлттэй нийгэмд олон янзын жагсаал, цуглаан дээр ямар ч хэлбэрийн албан ёсны зохицуулалт шаарддаггүй. Иймд зөвхөн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зохицуулах,

мөн үндэсний аюулгүй байдал, нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахад шаардлагатай зохицуулалтыг төрөөс хэрэгжүүлэх зорилгоор л урьдчилан мэдэгдэх шаардлагыг тавьдаг. Эдгээр хууль, тогтоомжид жагсаал, цуглаан зохион байгуулагчдыг зөвшөөрөл авахыг шаардах биш, харин зорилгынхоо талаар мэдэгдэл ирүүлэхийг л шаардах ёстой.

Мэдэгдэл өгөх үйл явц нь чирэгдэл ихтэй, хүнд сурталтай байх ёсгүй бөгөөд мэдэгдлийн хугацаа нь шаардлагагүйгээр сунжирч болохгүй. Мэдэгдэл өгөх хугацаа тавих нь дараах зүйлийг хангуулах зорилгоор тогтоосон байна. Үүнд:

- a. холбогдох эрх бүхий байгууллагуудад эерэг үүрэг хариуцлагаа биелүүлэхэд шаардлагатай төлөвлөгөө, бэлтгэл ажлыг хангах хангалттай хугацаа;
- b. шүүхэд давж заалдах, тогтоосон хязгаарлалтыг эсэргүүцэх хугацаа.

Хэрэв эрх баригчид мэдэгдэлд ямар нэгэн эсэргүүцэл гаргаагүй бол жагсаал, цуглаан зохион байгуулагчид мэдэгдэлдээ заасан нөхцлийн дагуу зорьж буй үйл ажиллагаагаа ямар ч хязгаарлалтгүйгээр хийж болно гэж үзэх боломжтой байх ёстой.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулахын тулд жагсаал, цуглааны дамжуулах гэж буй агуулгад хязгаарлалт тавьж болохгүй.⁶ Ялгаварлан гадуурхаж, дайсагнасан, хүчирхийллийг өдөөн турхирсан үг яриа хийж буй тохиолдлуудад цагдаа хариу үзүүлэх шаардлага гарч болно. Гэсэн хэдий ч цагдаагийн алба хаагчид ийм үг яриа хэрэглэж буй хүмүүс болон тайван жагсаал, цуглаан хийх эрхээ үндэслэлгүйгээр хязгаарлуулж болохгүй бусад оролцогчдыг хооронд нь ялгах ёстой. Үүний зэрэгцээ, ялангуяа томоохон хэмжээний ажиллагаа, эсвэл эсрэг тэсрэг байр суурь бүхий үйл явдлын үед шийдвэр гаргахдаа цагдаагийн алба хаагч бүр тус тусдаа ажиллахаас илүүтэйгээр командын бүтцээр ажиллаж, холбогдох төлөвлөгөөг ч урьдчилан гаргасан байх ёстой. Цагдаагийн байгууллага ийм нөхцөл байдлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулж, ялангуяа хөндлөнгөөс оролцох бол шийдвэр гаргах эрх мэдэл хэнд байх, ямар бичвэр, уриа лоозон байвал арга хэмжээ авах шаардлагатай зэргийг мэдэж байх ёстой. Зарим улс оронд прокурор энэ талаар хязгаарлалт тогтооход оролцдог.

6 АИССР-ын 19 дэх зүйл, иш татсан бүтээлд, тэмдэглэл 3.

Харин нийтийн жагсаал, цуглаан хийх цаг, газар, арга хэлбэрийг бусад хүмүүсийн эрх, эрх чөлөөнд үндэслэлгүйгээр халдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохицуулж болно. Энэ нь жагсаал, цуглаан хийх замаар үзэл бодлоо илэрхийлэх хүмүүсийн эрх, нөгөө талаас түүнд оролцоогүй хүмүүсийн эрхэд шаардлагагүй дарамт учруулахгүй байх эрх ашгийн хооронд зохистой тэнцвэр байх шаардлагатайг харуулж байна.

Жагсаал, цуглаанд хязгаарлалт тавих хууль ёсны үндэслэл байгаа тохиолдолд эрх баригчид эдгээр хязгаарлалтыг хамгийн бага хэмжээнд байлгаж, зохион байгуулагчдын хүлээн зөвшөөрч болох өөр цаг, газрыг бэлэн байлгахыг баталгаажуулах ёстой. Аль ч хувилбар нь тухайн жагсаал, цуглааны дамжуулахыг зорьж буй мессежийг зорьсон хүмүүстээ үр дүнтэй хүргэх боломжтой байх ёстой, өөрөөр хэлбэл, хүргэхийг зорьж буй хүмүүс нь нүдээр харж, чихээр сонсохуйц байх ёстой.

Хүмүүсийн тайван замаар жагсаж, цугларах эрхийг хязгаарлахыг оролдсон эсэргүүцлийн жагсаал тулгарвал тухайн эсэргүүцлийн жагсаал нь олон улсын хүний эрхийн хуулийн хамгаалалтад хамрагдахгүй.

Жагсаал, цуглааныг хориглох

Зөвхөн онцгой тохиолдолд жагсаал, цуглаан хийхийг хориглоно. Үүнд гэмт хэрэг, олон нийтийн эмх замбараагүй байдал үүсэх, үндэсний аюулгүй байдалд шууд заналхийлэх, эсвэл жагсаал, цуглааны зорилго нь үзэн ядалт, хүчирхийллийг өдөөн турхирах, бусдыг айлган сүрдүүлэх, заналхийлэх, эсвэл бусдын хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх эрхийг нь санаатайгаар үгүйсгэх зэрэг ноцтой бөгөөд бодитой заналхийлсэн нөхцөл байдлыг багтааж болно.

Аливаа жагсаал, цуглаан нь хүчирхийллийн шинжтэй эсрэг жагсаалтай тулгарах, эсхүл эсрэг байр суурьтай хүмүүсийн шууд халдлагад өртөх магадлалтай байсан ч зарчмын хувьд тухайн тайван жагсаал, цуглааныг хориглоход хүргэх ёсгүй. Энэ тохиолдолд цагдаагийн байгууллага нь тухайн тайван жагсаал, цуглаан эсэргүүцэгчдийн халдлага, хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй.

Бүх жагсаал, цуглааныг тодорхой газар, эсвэл тодорхой хугацаанд хориглох нь тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зохимжгүй хязгаарласан гэж үзэхэд хүргэх магадлалтай. Хэрэв жагсаал, цуглаан хийхийг хориглосон, хязгаарласан бол тухайн шийдвэрийг давж заалдах, эсэргүүцэх эрх байх ёстой.

Зардал

Аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангахад шаардагдах зардал (хэв журам сахиулах, замын хөдөлгөөний зохицуулалт зэрэг)-ыг төрийн байгууллага бүрэн хариуцах ёстой. Цагдаагийн хэв журам зохих ёсоор сахиулсны төлөө төр санхүүгийн ямар нэгэн төлбөр авах ёсгүй. Арилжааны бус, олон нийтийн жагсаал, цуглаан зохион байгуулагчдаас зохион байгуулсан арга хэмжээнийхээ хариуцлагын даатгалд хамрагдахыг шаардах ёсгүй.

2-Р БҮЛЭГ. ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕЭР ХЭВ ЖУРАМ САХИУЛАХАД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Хүний эрхэд суурилсан хандлага нь нийтийн жагсаал, цуглаанд хэв журам сахиулах зэрэг орчин үеийн хэв журам сахиулах бүх үйл ажиллагааны үндэс суурь байх ёстой. Энэ нь цагдаагийн байгууллага ард иргэдэд эрхээ эдлэх боломжийг олгохын тулд үндэслэлтэй, зохих арга хэмжээ авах үүрэгтэй гэдгийг ухамсарлан, ард иргэд ийнхүү эрхээ эдлэх үед нь хууль бусаар хөндлөнгөөс оролцохгүй байх, үргэлж шударга ёсыг баримтлан алагчлалгүй ажиллах үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал юм.

Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах

*ЕАБХАБ-ын Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах тухай удирдамжид*⁷ хэв журам сахиулах бүх хэлбэрийн суурь үндэс болсон хэд хэдэн чухал зарчмуудыг онцолж өгснөөс гадна жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах арга барилын үндсэн суурь хэм хэмжээг зааж өгсөн. Үүнд:

Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах зорилтыг тууштай баримтлах:

Цагдаагийн байгууллага бол хууль, хэв журмыг сахиулах, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, олон нийтэд тусламж, үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэг бүхий төрийн эрх мэдлийн хамгийн тод илрэл юм.

7 *Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах тухай удирдамж*, (Вена: ЕАБХАБ-ын Цагдаагийн ахлах зөвлөх, 2008), SPMU Хэвлэлийн цуврал 1, 2 дахь хэвлэлт, <<http://www.osce.org/spmu/23804>>.

Хууль дээдлэх ёс: Цагдаагийн байгууллага нь дотоодын хууль тогтоомж, ЕАБХАБ-ын гишүүн орнуудын хүлээн зөвшөөрсөн олон улсын хууль сахиулах стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, хууль дээдлэхийн төлөө тууштай байдлаа бодитоор харуулах ёстой.

Цагдаагийн байгууллагын ёс зүй ба хүний эрх: Ард иргэдийн итгэлийг хүлээж ажиллахын тулд цагдаа нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөж, мэргэжлийн ур чадвар, шударга ёсыг харуулах ёстой. Хүний амь насыг хамгаалах нь тэдний нэн тэргүүний зорилт байх ёстой.

Цагдаагийн байгууллагын хариуцлага, ил тод байдал: Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах явдал нь цагдаагийн байгууллага ард иргэд, тэдний төлөөлөгчид, төр, хуулийн өмнө хариуцлага хүлээж, өөрсдийгөө хариуцлагатай гэж үздэг байхыг шаарддаг. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, ялангуяа цагдаагийн алба хаагчдын зан байдал, цагдаагийн үйл ажиллагааны стратеги, томилгооны журам, төсвийн зарцуулалт зэрэг нь хяналтын байгууллагуудын хяналт шалгалтад нээлттэй байх ёстой.

Цаашилбал ардчилсан зарчмаар хэв журам сахиулах гол онцлог шинж нь ард түмний зөвшөөрөл шаардлагатай гэдгийг ойлгох явдал юм. Нийтийн дэмжлэгийг авах урьдчилсан нөхцөл бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод болгох, мөн цагдаагийн байгууллагын үйлчилж, хамгаалж буй ард иргэдтэй харилцах, харилцан ойлголцлыг бий болгох явдал юм.

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, менежментийн асуудал: Улс орнууд цагдаагийн байгууллагад хууль дээдлэх ёс, дотоодын болон олон улсын хууль тогтоомж, хүний эрхийн хүлээн зөвшөөрөгдсөн стандартын заалтуудыг үр дүнтэй бөгөөд үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх бүтэц, удирдлагын орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд командын удирдлагын шаталсан тогтолцоо, хяналт удирдлагын зохицуулалт, цагдаагийн бүрэлдэхүүн, цагдаагийн алба хаагчдын эрх, зохих нөөц, сургалтаар хангах зэрэг багтана.

Эдгээр үндсэн зарчмууд нь ардчилсан зарчмаар цагдаагийн хэв журам сахиулах бүх хэлбэр, тэр дундаа нарийн төвөгтэй бөгөөд хүч чадал шавхсан ажил болох нийтийн жагсаал, цуглааны үеэр дэг журам сахиулах ажиллагаанд бүр илүү хамаатай. Жагсаал, цуглаан нь цар хүрээ, арга барил, оролцогчдын тоо, дэвшүүлэн тавьж буй санал бодлын түвшнээсээ хамаарч олон янз байж болно. Жагсаал, цуглаан нь өдөр тутмын үйл ажиллагаанд саад учруулж болох учраас бусад хүмүүсийн эрхээ хэрэгжүүлэх боломжид

сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Тиймээс цагдаагийн байгууллага нь янз бүрийн бүлэг, хувь хүмүүсийн өөр хоорондоо өрсөлдөж буй гомдол, саналд тэнцвэртэй хандах шаардлагатай байж магадгүй юм.

Жагсаал, цуглаанд оролцогчийн зан байдлыг ойлгох

Оролцогчдын зан байдлын талаар анхан шатны мэдлэгтэй байх нь жагсаал, цуглаан дээр ямар арга барилаар хэв журам сахиулж, зохицуулахаа шийдэх чухал үндэслэл болдог. Улмаар төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэн тайлагнах зэрэг цаашдын бүх арга хэмжээ, ажиллагаа нь энэ ойлголт дээр үндэслэж явна.

Цагдаа бүлгийн зан үйлийн янз бүрийн хэлбэрийг мэддэг, нийтийн жагсаал, цуглааны дотроос эдгээр бүлгийг таньж тодорхойлж чаддаг, янз бүрийн бүлэг хүмүүс, тэдний зан авирыг ялгаж салгаж чаддаг, жагсаал, цуглааныг бүхэлд нь нэг янзаар ойлгож харахаас илүүтэй зан үйл тус бүртэй зохистой харьцах нь чухал юм. Жагсаал, цуглааны үеэр бүлэг дотор буй хувь хүний зан байдал сайнаар ч, муугаар ч хувирч өөрчлөгдөж болно. Үүнд нөлөөлж болох олон хүчин зүйлс байдаг бөгөөд эдгээрт:

- Тухайн хувь хүний эргэн тойрон дахь хүмүүсийн зан байдал;
- Хувь хүний өөрийн итгэл үнэмшил, стандарт;
- Өөрийн хийсэн үйлдэлд хариуцлага хүлээх тухай ойлголт;
- Хувь хүний итгэж үнэмшиж буй зүйл нь хүлээн зөвшөөрөгдөх зан төлөв гэж ойлгох ойлголт;
- Тухайн хүний сэтгэл санааны байдал (ууртай, баярласан, бухимдсан, айдас түгшүүртэй байх);
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ.

Хүмүүсийн зан төлөвт маш олон янзын хүчин зүйл нөлөөлж байдаг тул жагсаал, цуглаанд оролцогчид үргэлж нэг ижил зан авир гаргадаггүй нь гайхаад байх зүйл биш. Зарим хүмүүс оролцогчдыг тайван байлгаж, хуулийг дагаж мөрдүүлэхийг оролдож болно; зарим нь иргэдийг дуулгаваргүй байдалд уруу татаж байхад, зарим нь сөргөлдөөн, бүр хүчирхийлэлд уриалж болно. Энд тэнд бага зэргийн эмх замбараагүй байдал үүсэж болох ч жагсаал, цуглаанд оролцож буй ихэнхи хүмүүс тайван, эмх журамтай жагсаалаа үргэлжлүүлж болно.

Хэв журам сахиулах анхны алхам бол эмх замбараагүй байдал үүсэхэд түүнд реактив буюу цочмог, гал унтраах байдлаар хандахын оронд проактив буюу идэвхтэй, урьдчилан төлөвлөсний дагуу хариу үйлдэл

үзүүлдэг байх ёстой. Цагдаагийн холбогдох командлагч нөхцөл байдлыг тасралтгүй хянаж, жагсаал, цуглааны динамик буюу хувьсан өөрчлөлт, хажуунаас ирж сонирхож буй хүмүүс, шаардлагатай бол эсрэг жагсаал хийж буй хүмүүсийн нөхцөл байдалд ч үнэлэлт, дүгнэлт өгөх байдлаар ажиллах юм бол амгалан тайван байдлыг хангасан нөхцөл байдлыг хамгийн сайнаар зохицуулж чадна. Энэ нь цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан хийхтэй холбоотой хууль, эрх зүйн хязгаарлалтууд, зарим нэг бага зэргийн зөрчил зэрэг дээр уян хатан хандах шаардлагатай болно гэсэн үг юм. Аль алинд нь хэтэрхий хатуу хандах нь хурцадмал байдлыг дэвэргэж, оролцогчдыг илүү дайсагнасан, түрэмгий үйлдэл хийхэд өдөөх талтай. Сөргөлдөөн, хүчирхийллийг дэмжсэн зарим нэг дуу хоолой сонсогдсон нөхцөл байдалд ч гэсэн цагдаагийн зүгээс оролцогчдын ялгаатай байдлыг ялгаж салгаж, тэнд байгаа янз бүрийн бүлгүүд, хувь хүмүүсийн талаарх мэдлэг мэдээлэл дээрээ тулгуурлан, хүмүүстэй зөв боловсон харилцаж, тэдэнд хүлээцтэй хандах юм бол цагдаа ийм нөлөөллийг эсэргүүцэж чадна.

Жагсаал, цуглаан дээр хэв журам сахиулахад баримтлах зарчмууд

Мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал – энэхүү дөрвөн үндсэн зарчим нь цагдаагийн байгууллагыг тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхэд нь чиглүүлж, аливаа жагсаал, цуглаанд хандах арга барилынх нь үндэс суурийг тавьж өгнө⁸. Энэ дөрвөн зарчмыг цагдаагийн байгууллагын удирдах ажилтнууд жагсаал, цуглааныг тайван замаар явуулах нөхцлийг хангахын тулд үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, дүгнэх бүхий л үе шатандаа ашиглаж, хэрэгжүүлэх ёстой. Түүнчлэн энэ зарчмуудыг бүх шатны цагдаагийн алба хаагчид жагсаал, цуглаан дээр хэв журам сахиулахдаа баримталж, хэрэгжүүлэх ёстой.

Мэдлэг

Жагсаал, цуглаанд оролцож буй янз бүрийн бүлгүүдийн талаар мэдлэгтэй байх нь зайлшгүй тавигдах урьдчилсан шаардлага юм. Тэдгээр бүлгүүдийн хэм хэмжээ, үнэт зүйл, санаа зорилго, тэдний хувьд юу зөв, юу зүйтэй болох,

8 Reicher, S., C. Stott, J. Drury, O. Adang, P. Cronin & A. Livingstone, «Мэдлэгт суурилсан нийтийн хэв журам сахиулах: Зарчим ба практик» *Хэв журам сахиулах*, боть. 1, №4, 2007, хуудас 403-415.

нийгмийн бусад бүлгүүдтэй харьцдаг тэдний хэвшмэл ойлголт, хүлээлт, тэдний үүх түүх (тэдний зохион байгуулсан өмнөх жагсаал, цуглааныг оролцуулан) болон тэдний хувьд онцгой, бэлэгдэл болж өгдөг өөр бусад чухал элементүүдийн талаар мэдлэгтэй байх нь чухал.

Ийм мэдлэг, мэдээлэлтэй байх нь цагдаад тэр бүлгүүдийн ашиг сонирхол, зорилгыг ойлгож, тэднийг хууль ёсны зорилгодоо хүрэхэд нь чиглүүлж, дэмжлэг үзүүлж чадна. Энэхүү мэдлэг нь тухайн бүлэг цагдаагийн ямар үйлдэл өөрсдийг нь доромжилсон, эсвэл өдөөн хатгасан хэмээн ойлгож, улмаар зөрчилдөөн үүсгэж болзошгүй вэ гэдгийг ойлгох боломжийг олгодог.

Ямарваа ажиллагаа явуулахын өмнө цагдаагийн байгууллага мэдээлэл цуглуулахдаа тухайн жагсаал, цуглаанд оролцох магадлалтай бүлгүүд, тэдний санаа сэдлийн талаарх мэдээллийг цуглуулахад анхаарахын сацуу эрсдэл үүсгэж болзошгүй гэж үзсэн хувь хүмүүсийн талаарх мэдээлэл (эрүүгийн тагнуулын ажил) дээр анхаарлаа хандуулж, мэдлэг мэдээллээ дээшлүүлэхэд чиглэгдэх ёстой.

Дэмжлэг үзүүлэх

Цагдаагийн арга стратеги нь юуны түрүүнд тайван жагсаал, цуглаан зохион байгуулагчид болон түүнд оролцогчдын хууль ёсны зорилгодоо хүрэх хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхийг эрэлхийлэх ёстой. Энд яригдах гол урьдач нөхцөл бол жагсаал, цуглаанд оролцож буй ихэнх хүмүүс тайван санаа зорилготой байдаг гэсэн үзэл ойлголт юм. Цагдаагийн байгууллага оролцогчдыг санаа зорилгодоо хүрэхэд нь эхлээд оролцогчдын санаа зорилгыг олж тодорхойлох хэрэгтэй. Зорилгодоо хүрэхэд нь хялбар дөхөм болгосноор цагдаа нь хүчирхийллээс зайлсхийх төдийгүй эмх замбараагүй байдал үүсэх магадлалыг бууруулж, гарч болзошгүй аливаа эмх замбараагүй байдалд үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд оролцогчдоос дэмжлэг ч авах боломжтой.

Энэ нь бүлгүүдийн чухалчилж буй чиглэл, зорилгыг ойлгоход нь туслах мэдээлэл цагдаагийн байгууллагад хэрэгтэй гэдгийг харуулж байгаа төдийгүй, бүлгүүдийг хууль ёсны зорилгодоо хүрэх боломжийг олгохдоо цагдаагийн арга барил, тактикийг ашиглах боломжийг олгодог. Хориг хязгаарлалт, хяналтын арга хэмжээ нь дэг журам сахиулахад тэр бүр хангалттай байдаггүй гэдгийг туршлагаар ч, судалгаагаар ч харуулж байна.

Хэрэв эмх замбараагүй байдал, хүчирхийлэл гарах эрсдэлтэй бол зохион байгуулагчид болон оролцогчдод яагаад хязгаарлалт хийх шаардлагатайг хэлж ойлгуулах, мэдээлэх, оролцогчдод зорилгодоо хүрэх өөр арга замыг санал болгох нь нэн чухал юм.

Харилцаа холбоо

Аливаа жагсаал, цуглааны бүхий л үе шатанд итгэлцлийг бий болгож, хадгалахын тулд «гэнэтийн бэлэг байхгүй» гэх бодлогыг баримтлан, цагдаа, зохион байгуулагчид болон бусад оролцогч талуудын хоорондын харилцааг чиглүүлж байх ёстой бөгөөд тийм ч учраас энэ нь урьдчилан сэргийлэх, хурцадмал байдлыг намжаах гол тактик болдог.

Цагдаа нар аливаа арга хэмжээнд оролцогчидтой харилцаа тогтоож, цаашдын зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх үндэс суурийг бүрдүүлэхийн тулд тэдэнтэй маш идэвхтэй харилцаж байх хэрэгтэй. Зөрчил мөргөлдөөн үүсгэх, хурцатгахаас зайлсхийхийн тулд жагсаал, цуглаанд оролцогчидтой цагдаа нар хүндэтгэлтэй, тайван харилцах нь чухал болохыг туршлага харуулж байна. Харилцаа тогтоох явц нь ажиллагааны бүх үе шатанд явагдаж байх ёстой бөгөөд ялангуяа хурцадмал байдал үүсэж эхлэхэд энэ нь онцгой ач холбогдолтой юм. Хэрэв хязгаарлалт тавих шаардлагатай бол үл ойлголцол гарахаас зайлсхийхийн тулд шалтгааныг нь мэдээлэх, өөр хувилбаруудыг санал болгох нь чухал. Энэ нь цагдаагийн бүх алба хаагч арга хэмжээнд оролцогчид болон иргэдэд хэв журам сахиулж байгаа зорилгынхоо талаар мэдээлэл өгч, хэлж ярилцах нь чухал гэсэн үг юм.

Хэв журам сахиулж буй зорилгоо хэлж ойлгуулахын тулд цагдаа нар янз бүрийн арга зармуудыг эрэлхийлж хэрэглэх ёстой, тухайлбал, жагсаал, цуглаанд оролцогчид болон зохион байгуулагчидтай шууд ярилцах, зөөврийн чанга яригч, тусгай машины чанга яригч ашиглах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа олон нийтийн сүлжээ зэргийг ашиглаж болно. Аман бус харилцаа, тухайлбал, цагдаа нарын биеэ авч яваа байдал, харагдах байдал, өмсөж буй дүрэмт хувцас, авч яваа, үзүүлж харуулж болох хэрэгсэл зэрэг нь чухал ач холбогдолтой бөгөөд оролцогчдод болон хүмүүст илүү өргөн хүрээнд мессежийг хүргэдэг.

Олон үндэстэн, ястан бүхий улс оронд цагдаа хэлж ойлгуулах гэж буй зүйлсээ өөр өөр хэлээр дамжуулах чадвартай байх нь бас чухал.

Ялгаатай байдал

Жагсаал, цуглааны үеэр эрсдэл үүсгэх нэг чухал хүчин зүйл бол аливаа бүлэгт хамаарч буй бүх хүнийг бүгдийг нь адилхан гэж, бас бүгдээрээ аюултай гэж үзэж, тэдэнтэй тийнхүү харьцах аюул юм. Хүмүүсийг хооронд нь ялгаж салгаж ойлгох нэг арга бол тухайн хүнийг аль нэг ангилалд хамаардаг гэж харахаас илүүтэй хувь хүн бүрийн юу хийж байгааг сайтар ажиглах явдал юм. Цагдаа нар ингэж ялгаатай байдлаар харж чадаагүйгээс болж зөрчилдөөн үүсч, хурцадмал байдал даамжирсан олон жишээ бий.

Аливаа бүлэгт буй хүмүүс анхнаасаа л нэг янзын зан авиртай байдаггүй, харин бүгдээрээ адилхан гэдэг байдлаар тэдэнд хандах юм бол тийм зан авир гаргаж эхэлдэг. Тиймээс жагсаал, цуглаан дотор ямар ямар бүлгүүд байдгийг, тэдний гаргаж болох янз бүрийн зан авир, хариу үйлдлүүдийг мэдэх нь чухал. Хэрэв хэн нэг хүн зөрчилдөөн үүсгэсэн бол цагдаагийн хариу үйлдэл нь бусдыг уг зөрчилдөөнд татан оруулахгүй байх нь чухал юм.

Аливаа бүлэгт байгаа хүмүүсийг ялгаж тодорхойлж, олон нийтийн дэг журмыг алдагдуулж буй хүмүүсийг тайван амгалан байгаа хүмүүсээс хурдан салгаж чадсанаар цагдаа нар бусад олон оролцогчдоос хүндэтгэл хүлээж, хэв журам сахиулж буй ажилдаа өргөн дэмжлэг авч чадна. Жагсаал, цуглаан нь өөр өөр мөрийн хөтөлбөр, зорилготой, цагдаагийн байгууллагын талаар өөр өөр үзэл бодолтой олон янзын бүлгүүдээс бүрдэж болно гэдгийг ойлгох нь чухал.

Үр дүн

Өөрсдөө хэв журам сахиулах: Дээрх зарчмуудыг хэрэгжүүлбэл жагсаал, цуглаанд оролцогчдод цагдаагийн талаар илүү эерэг үзэл бодлыг бий болгоход тусалдаг болохыг судалгаагаар харуулсан. Энэ нь оролцогчид өөрсдийн эрхээ эдлэхэд нь цагдаагийн байгууллага шударга ханддаг гэж ойлгосонтой холбоотой юм. Ингэснээр жагсаал, цуглаанд оролцогчид тайван байдлыг эвдэж болзошгүй хүмүүст өөрсдөө шаардлага тавьж, хөндлөнгөөс оролцож эхлэх ба үр дүнд нь жагсаал, цуглаан тайван байдлаар явагдахад хувь нэмэр оруулдаг. Оролцогчид өөрсдөө энэ үүрэг хариуцлагыг хүлээх үед цагдаа болон тухайн жагсаал, цуглааны хооронд «бид тэдний эсрэг» гэсэн харилцаа үүсэхгүй, харин итгэлцэл бүхий хамтын ажиллагаа бий болох магадлалтай.

Зарчмуудыг ерөнхийд нь хэрэгжүүлэх

Энэхүү гарын авлагад цагдаагийн удирдлагууд тайван жагсаал, цуглааныг зохицуулахдаа эдгээр үндсэн зарчмуудыг хэрхэн ашиглаж болох талаар ерөнхийд нь тоймлон оруулсан. Энэхүү гарын авлагын үлдсэн хэсэгт жагсаал, цуглааныг төлөвлөх, бэлтгэх, чиглүүлэхтэй холбоотой зарим аргачлалуудыг алхам алхмаар харуулах хэдий ч ерөнхийд нь анхаарч үзэх шаардлагатай хэд хэдэн асуудлыг илүү нарийвчлан тодруулах нь зүйтэй юм. Эдгээр нь жагсаал, цуглаанд оролцож болох тодорхой ангиллын хүмүүс, цагдаагийн алба хаагчид хүч хэрэглэх тохиолдол, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандах явдал зэрэг болно.

Олон янз ба тэгш байдал

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь хүн бүрт олгогдсон бөгөөд цагдаагийн байгууллага нийгмийн бүх бүлгийн жагсаал, цуглаан хийх эрхээ эдлэхэд дэмжих үүрэгтэй, ингэснээр олон нийтийн газар иргэд үзэл бодлоо илэрхийлэх олон төрлийн үйл ажиллагаанд оролцох боломжтой болно. Гэсэн хэдий ч жагсаал, цуглааны мөн чанар, оролцогчдын байдлаас үндэслэн тайван замаар жагсаж, цугларах үндсэн эрхээ хэрэгжүүлэх явцад онцгой анхаарал хандуулах шаардлагатай зарим хүмүүс байдаг.

Жагсаал, цуглааныг аюулгүй, тайван орчинд явуулахыг баталгаажуулна гэдэг нь цагдаагийн байгууллага оролцогчдын талаар мэдлэгтэй байх, янз бүрийн бүлгүүдийн үзэл бодлоо илэрхийлэх үйл ажиллагааг хэрхэн дэмжих талаар онцгой анхаарч, улмаар энэ нь жагсаал, цуглааны өмнө, дундуур нь, мөн дараа нь харилцах зөв зүйтэй харилцааны арга хэрэгсэл шаардагддаг, мөн жагсаал, цуглааны хэв журам сахиулахад оролцож буй бүх алба хаагчид янз бүрийн бүлгүүд, хувь хүмүүсийг хооронд нь ялгаж салгаж ойлгох чадвартай байх ёстой гэсэн үг юм.

Эмэгтэйчүүд: Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц (CEDAW)-ийн 3-р зүйлд зааснаар гишүүн улсууд «эмэгтэйчүүдийн бүрэн хөгжил, дэвшлийг хангах, тэдэнд эрэгтэйчүүдтэй эрх тэгш байх үндсэн дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө эдлэх зорилгыг баталгаажуулахын тулд хууль тогтоомж батлах зэргээр

зохих бүх арга хэмжээг авах үүрэгтэй»⁹. Эмэгтэйчүүдийг дангаар нь эмзэг бүлэг гэж үзэх ёсгүй ч жагсаал, цуглааны үеэр эмэгтэйчүүд тусгаарлагдах, гэмт хэрэгтнүүдийн халдлага, бэлгийн хүчирхийлэлд өртөх тохиолдол гарч байсан. Цагдаа энэ тал дээр сонор сэрэмжтэй байж, тэднийг хамгаалахад бэлэн байх ёстой. Эмэгтэйчүүд ихэвчлэн цөөнх биш, харин тооны хувьд олонх байдаг. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн хэрэгцээг тусгайлан авч үзэхгүй бол цагдаагийн байгууллагын ойлголт, үйл ажиллагааны зохион байгуулалт нь жагсаал, цуглааны оролцогчдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа гэсэн таамаглал дээр үндэслэх магадлал өндөр байдаг. Тиймээс цагдаагийн байгууллага эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг ханган ажиллах нь чухал.

Лесби, гей, бисексуал, трансжендер, интерсекс (ЛГБТИ): ЛГБТИ хүмүүс нь бусадтай адил хүний эрх, үндсэн эрх чөлөө, тэр дундаа жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдэлдэг. ЛГБТИ хүмүүс олон улс оронд олон нийтийн дунд өөрсдийн байр суурийг илэрхийлэхийн тулд хүчтэй эсэргүүцлийг, ихэвчлэн хүчирхийллийг даван туулах, тэсвэрлэх шаардлагатай хэвээр байна. Цагдаа нийгмийн бусад бүлгийн нэгэн адил тэдний жагсаал, цуглаанд дэмжлэг үзүүлэх, оролцогчдын аюулгүй байдлыг хангахын тулд хангалттай нөөцийг гаргах шаардлагатай.

Хүүхэд: НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 15-р зүйлд «Гишүүн улсууд хүүхдийн тайван жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой» гэж заасан байдаг¹⁰. Гэхдээ нас, биеийн хөгжлийн хувьд хүүхдүүд бага балчир учраас зарим жагсаал, цуглааны хувьд хүүхдүүд илүү эмзэг өртөмтгий байдаг, тиймээс цагдаа нар үйл ажиллагааныхаа хувилбарыг сонгохдоо энэ нөхцөл байдлыг анхаарч үзэх хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид «Хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бүрэн, тэгш эдлэхийг хөхиүлэн дэмжих,

9 *Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)*, (Нью-Йорк хот: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, 1979), 34/180 тогтоол. <<http://www.un.org/womenwatch/daw/cedaw/text/econvention.htm>>.

10 *Хүүхдийн эрхийн тухай конвенц*, (Нью-Йорк хот, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, 1989), 44/25 тогтоол, <<http://www.ohchr.org/en/professionalinterest/pages/crc.aspx>>.

хамгаалж, хангах...»¹¹, мөн бусадтай адил тэгш эрхтэйгээр нийгэмд бүрэн, үр дүнтэй оролцох, ялангуяа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, улс төр, олон нийт, соёлын амьдралд оролцох эрхийг хангах талаар онцлон тэмдэглэсэн байдаг. Жагсаал, цуглааны хэв журам сахиулах, дэмжлэг үзүүлэхдээ жагсаал, цуглаанд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай.

Угсаатан, шашин шүтлэг, хэлний цөөнх: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 27-р зүйлд зааснаар «Угсаатан, шашин шүтлэг, хэлний цөөнхөд харьяалагддаг хүмүүсийн өөрийн соёлыг эдлэх, өөрийн шашныг шүтэх, эх хэлээрээ ярих эрхийг хамгаална.»¹² Үүний зэрэгцээ, 2-р зүйлд Пактаар хамгаалагдсан эрх нь ямар нэгэн ялгаагүйгээр бүх хүмүүст хамаарна гэдгийг баталгаажуулдаг. Цөөнхийн бүлгүүдийг эсэргүүцэж буй хүчирхийлэл, халдлага, түрэмгийллээс тэднийг хамгаалахын тулд энэ асуудлыг цаашид анхаарч үзэх шаардлагатай байж магадгүй. Цагдаа тэдний жагсаал, цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангахдаа энэ бүлгийн эмзэг байдлыг харгалзан үзэх ёстой.

Хүчийг эцсийн арга болгон ашиглах

Жагсаал, цуглаан нь үймээн самууны хэлбэрт орж, олон нийтийн газар эмх замбараагүй байдал, хүчирхийлэл гарахад хүргэж болзошгүй байдал нь байнгын асуудал дагуулж, санаа зовоодог нэг зүйл юм. Ерөнхийдөө олон нийтийн жагсаал, цуглааны дийлэнх нь өдөр тутмын ажил амьдралын дэг журмыг тасалдуулалгүйгээр тайван болж өнгөрдөг бөгөөд цагдаа нар дөрвөн зарчимд анхаарч ажиллавал энэ магадлал нэмэгдэх боломжтой. Цагдаа нь зохион байгуулагчдын хүсэл зорилгын талаар зөв зүйтэй мэдлэг ойлголттой, жагсаал, цуглааныг чиглүүлэх арга барилыг баримталдаг, энэ санаагаа зохион байгуулагчид, оролцогчид болон бусад хүмүүст зөв илэрхийлэн харилцдаг, оролцогчдыг дотор нь ялгаж салгахыг тууштай эрэлхийлдэг бол эмх замбараагүй байдал үүсэх эрсдэл, боломжууд буурна.

Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад цагдаагийн хийх ажлын эхлэл нь ямагт дэмжлэг үзүүлэх явдал байх бөгөөд үүнийг харилцан

11 *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц*, (Нью-Йорк хот, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей, 2006), 61/106 тогтоол. 1-р зүйл, <<http://www.un.org/disabilities/convention/conventionfull.shtml>>.

12 Иргэний ба Улс төрийн эрхийн олон улсын пакт, *иш татсан бүтээлд*, тэмдэглэл 3.

ярилцах, хэлэлцээ хийх болон харилцааны бусад хэлбэрээр хэрэгжүүлж болно. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд цагдаа хүч хэрэглэх шаардлагатай болдог. Цагдаа ямарваа хүч хэрэглэх тохиолдол нь жирийн бус, гагцхүү онцгой тохиолдол байх ёстой. Хүч хэрэглэхийн оронд харилцан ярилцах, хэлэлцэх, ятгах, хэлэлцээ хийх замаар хурцадмал байдлыг энхийн замаар намжаахыг эрэлхийлэхийг ямагт эрмэлзэх ёстой.

Зарим тохиолдолд цагдаа хүчирхийлэлтэй тулгарахдаа хүч хэрэглэх шаардлага гарч болно. Хүч хэрэглэх нь үргэлж тохирсон хэм хэмжээнд байх ёстой бөгөөд дэг журмыг тогтооход тавигдах хамгийн бага шаардлага байх ёстой. Аливаа хүч хэрэглэх, эсвэл хүч нэмэгдүүлэх тохиолдол нь нөхцөл байдал шийдэгдмэгц нэн даруй хурцадмал байдлыг намжаахад чиглэх хэрэгтэй. Цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг зохицуулахдаа ашиглах олон янзын сонголт хувилбартай байх ёстой.

Хэрэв цагдаа хүч хэрэглэх шаардлагатай гэж үзвэл оролцогчдын олон янз байдлыг ямагт санаж, жагсаал, цуглаанд оролцож буй янз бүрийн бүлгүүдийг ялгаж салгах ёстой. Тайван жагсаал, цуглаанд оролцогчдын эсрэг хүч хэрэглэж болохгүй, түүнчлэн тухайн жагсаал, цуглаан нь хууль бус, үндэслэлгүй, бусдын ажил, амьдралд аюул занал учруулаагүй бол тайван жагсаал, цуглааныг тараахад хүч хэрэглэж болохгүй. Цагдаа хүч хэрэглэхээр сонгохдоо хурцадмал үр дагаварт хүргэж болзошгүй эрсдэлийг үргэлж анхаарч байх хэрэгтэй. Арга хэмжээ авахаасаа өмнө хүч хэрэглэх тухайгаа үргэлж сануулж, тайлбарлах ёстой бөгөөд ингэснээр ил тод байдлыг бий болгож, итгэлцлийг хадгална.

Хүний эсрэг аливаа хүч хэрэглэх нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй. Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг аль болох хүч хэрэглэхгүй байх ёстой, гэхдээ зайлшгүй шаардлагатай бол тухайн нөхцөл байдалд тохируулан хүч хэрэглэх ёстой.

Зарим нөхцөлд жагсаал, цуглаанд оролцож буй хүмүүсийн эсрэг дайсагнасан, түрэмгийлсэн эсрэг жагсаалтай тулгарвал цагдаа тэднийг хамгаалахын тулд хүч хэрэглэх шаардлагатай болдог. Ийм нөхцөлд цагдаагийн байгууллага түрэмгийлэгчид болон түрэмгийллийн бай болж байгаа талуудыг ялгаж, тайван жагсаал, цуглаан хийх эрхээ эдэлж буй хүмүүсийн эрхийг хамгаалах үүрэгтэй гэдгээ санах хэрэгтэй.

1990 онд батлагдсан НҮБ-ын *Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмуудад* хүч хэрэглэх явдлыг зохицуулах ерөнхий зарчмуудыг тодорхойлсон ба энэ нь

цагдаагийн бүх алба хаагчдад адилхан үйлчилнэ. *Үндсэн зарчмуудад* хүч хэрэглэх нь хэвийн хэм хэмжээ биш, харин үргэлж эцсийн арга болгон авч үзэх ёстой бөгөөд хүч хэрэглэх болгондоо тохирсон хэм хэмжээнд байлгаж, хүний амь насыг хүндэтгэх ёстой гэдгийг онцлон тэмдэглэсэн¹³.

Жагсаал, цуглаантай холбогдуулан ямар нэг байдлаар хүч хэрэглэх талаар авч үзэхээсээ өмнө цагдаа юуны түрүүнд зайлшгүй шаардлагатай юу гэдгийг эхлээд анхаарч үзэх хэрэгтэй. Хэрэв ижил зорилгод тайван замаар хүрч болохоор бол хүч хэрэглэх ёсгүй. Хоёрдугаарт, хүч хэрэглэж байгаа тохиолдолд хэв журам сахиулах хууль ёсны зорилгод хүрэхийн тулд түүний тохирсон хэм хэмжээнд байх ёстойг анхаарч үзэх ёстой. Жагсаал, цуглаантай холбогдуулан хүч хэрэглэж байгаа тохиолдолд цагдаагийн командлалын баг (стратегийн, ажиллагааны болон тактикийн түвшинд) хэв журам сахиулах ямар зорилгод хүрэхийг хичээж байгаагаа, тухайлбал, зохицуулах, хязгаарлах, саатуулах, тараах зорилгоор хийж байгаа эсэхээ, мөн энэ нь яагаад энэ нөхцөл байдалд хамгийн тохиромжтой сонголт гэдгийг олон нийтэд тайлбарлаж чадаж байх ёстой. Ялангуяа хүч хэрэглэх талаар авч үзэж байгаа бол жагсаал, цуглаан дээр хэв журам сахиулахаар төлөвлөх болон жагсаал, цуглааныг зохицуулах бүхий л явцад командлалын түвшний хооронд харилцаа холбоо, яриа хэлэлцээ хийж байх нь зайлшгүй чухал юм. Хууль бус тушаалыг эсэргүүцэх ёстой¹⁴.

Галт зэвсгийг ерөнхийдөө жагсаал, цуглааны үеэр өөрийгөө болон бусдыг хамгаалах, амь насаа алдах, хүнд гэмтэл учруулах аюулаас урьдчилан сэргийлэх, хүний амь насанд онц хүнд аюул учруулах онц хүнд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, ийм аюул занал учруулж, тушаалыг эсэргүүцэж буй хүнийг баривчлах, түүнийг оргон зугтахаас урьдчилан сэргийлэх зорилгоор, эдгээр зорилгод хүрэхэд хамгийн ноцтой бус арга хэрэглээд хангалтгүй тохиолдолд л хэрэглэх бөгөөд үүнээс бусад тохиолдолд ашиглах ёсгүй. Ямар ч тохиолдолд зөвхөн хүний амь насыг зайлшгүй хамгаалахын тулд галт зэвсгийг санаатайгаар ашиглана¹⁵. Галт зэвсэг хэрэглэхээс зайлсхийх боломжгүй тохиолдолд дүрэм журмын дагуу анхааруулга өгөх ёстой¹⁶. Хүчирхийлэл үйлдэж буй олныг ялгалгүй

13 НҮБ-ын *Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд*. (Гавана, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнтэй харьцах 8-р Конгресс, 1990), <<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/UseOfForceAndFirearms.aspx>>.

14 *Үндсэн зарчмуудын 27-р зүйл, мөн өмнөх зүүлт тайлбарт дурдсан.*

15 *Үндсэн зарчмын 9 дүгээр зүйл, мөн өмнөх зүүлт тайлбарт дурдсан.*

16 *Үндсэн зарчмын 10 дугаар зүйл, мөн өмнөх зүүлт тайлбарт дурдсан.*

хавтгайруулан буудах нь тэднийг тараах хууль ёсны бөгөөд хүлээн зөвшөөрөгдөх арга хэзээ ч болдоггүй¹⁷.

Үүний зэрэгцээ цагдаагийн алба хаагчдын хэрэглэдэг олон ажиллагаа, арга барилыг буруу хэрэглэсэн, эсвэл хэмжээ хязгааргүйгээр ашиглах тохиолдолд галт зэвсэгтэй адил үхлийн аюулд хүргэж болзошгүй. Иймд зөвхөн зохих сургалтад хамрагдсан алба хаагчдыг жагсаал, цуглаанд оролцуулах нь маш чухал юм. Эдгээр бэлтгэл сургалтууд нь үр дүнтэй бөгөөд хүний эрхэд нийцэж байгаа эсэхийг заавал баталгаажуулж байх ёстой. Цагдаагийн алба хаагчдыг хэт цочмог хариу үйлдэл үзүүлэх, хүчийг буруугаар ашиглах зэргээс урьдчилан сэргийлэхийн тулд командлалын бүтэц нь үргэлж үр дүнтэй байх ёстой. Ноцтой гэмтэл учруулах, амь насаа алдах эрсдэл өндөртэй ажиллагааны хувилбаруудыг хатуу хяналтад байлгахын тулд эрх мэдлийн түвшин маш тодорхой байх ёстой бөгөөд цагдаа хүч хэрэглэсэн гэж сэжиглэгдсэн аливаа хэргийг бүрэн, шударга мөрдөн шалгахын тулд мөрдөн шалгах арга хэмжээг явуулахад бэлэн байх ёстой.

Хүч хэрэглэсэн аливаа үйлдлийг холбогдох офицер нь бүртгэх ёстой бөгөөд хүч хэрэглэсэн тухайгаа ахлах тушаалын ажилтанд аль болох хурдан мэдээлэхийг баталгаажуулсан журамтай байх ёстой. Ажиллагааны сонголт болгон хүч хэрэглэх шийдвэр гарсан тохиолдолд командлагч өөрийн шийдвэр, гарах үр дүнгийн үндэслэлээ бичиж баримтжуулах ёстой. Хэрэв хүч хэрэглэх нь хууль бус гэж үзэж байгаа, эсвэл сэжиглэж байгаа бол нөхцөл байдлын талаар бүрэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах ёстой.

Цагдаа ба хэвлэл мэдээлэл

Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах үйл ажиллагааны нэг зарчим нь хариуцлагатай, ил тод байх явдал бөгөөд цагдаа нь иргэд, тэдний төлөөлөгчдийн өмнө, түүнчлэн төр, хуулийн өмнө хариуцлага хүлээх шаардлагатайг онцолж байна. Олон нийтийг хамарсан жагсаал, цуглааны хэв журам сахиулахад нь цагдаагийн байгууллагад хариуцлага тооцох нэг арга бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, сэдэл зорилгыг мэдээлэх, бичиж авах, дүн шинжилгээ хийх, нягтлан шалгах чадвар бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм.

17 Үндсэн зарчмын 14 дүгээр зүйл, мөн өмнөх зүүлт тайлбарт дурдсан.

Хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах нь олон нийттэй өргөн хүрээнд харилцах чухал хэрэгсэл бөгөөд цагдаагийн байгууллага олон нийт болон оролцогчдод жагсаал, цуглааныг зохицуулах зорилгынхоо талаар болон жагсаал, цуглааныг тайван замаар зохицуулахыг баталгаажуулахын тулд ямар арга замууд ашиглахаар зорьж буй зэрэг мэдээллээ хуваалцах хэрэгсэл болж чадна.

Цагдаагийн байгууллага сэтгүүлчдийн олон нийтийн жагсаал, цуглаанд оролцох, сурвалжлах эрхийг ямагт хүлээн зөвшөөрөх ёстой. Цагдаагийн байгууллага ийм арга хэмжээнүүд дээр сэтгүүлчдийн эрхийг хангах зэрэг үүрэгтэй байдаг бол, харин хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх сөрөг үүрэг хүлээдэг. Жагсаал, цуглаан дээр сэтгүүлчдийг ажлаа хийхэд зохицуулалт хийж өгөх нь цагдаагийн байгууллагын ашиг сонирхол юм: сэтгүүлчид тухайн арга хэмжээнд оролцоход хялбар, саадгүй байх үед тухайн үйл явдлыг цагдаа хэрхэн зохицуулж байгаа талаарх мэдээллүүд илүү зэрэг өнгө аястай байх магадлал өндөр байна. Мөн сэтгүүлчид болон цагдаа нарын хооронд итгэлцлийг бий болгодог.

ЕАБХАБ-ын «Улс төрийн жагсаал, цуглааны үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах нь»¹⁸ тайланд олон нийтийн цуглаан дээр цагдаа, сэтгүүлчдийн харилцаа ямар байх тухай хүлээлтийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд олон нийтийг хамарсан жагсаал, цуглааны үеэр сэтгүүлчдийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх үндсэн хуулиар хүлээсэн үүрэгтэй. Сэтгүүлчид цагдаагийн байгууллагыг шударга бөгөөд хязгаарлагдмал байдлаар харьцаж хандана гэж хүлээх эрхтэй;
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хариуцаж буй ахлах албан тушаалтнууд нь сэтгүүлчдийн үүрэг, ялангуяа жагсаалын үеэр гүйцэтгэх үүргийнх нь талаар алба хаагчдадаа зохих ёсоор сургаж бэлтгэх үүрэгтэй. Цагдаагийн алба хаагчдаас сэтгүүлчидтэй хэт түрэмгий харьцсан тохиолдолд тухайн жагсаалд хариуцлага тооцсон эсэхээс үл хамааран харьцсан цагдаагийн алба хаагчдын асуудлыг тусад нь авч үзэх ёстой. Цаашид ийм үйлдэл давтагдахгүйн тулд цагдаагийн

18 Улс төрийн жагсаалын үеэр хэвлэл мэдээлэлтэй харьцах нь, Тусгай тайлан (Венна: ЕАБХАБ, 2007), <<http://www.osce.org/fom/25744>>.

ахлах албан тушаалтнуудын зүгээс шуурхай болон зохих хариу арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд ийм зан үйлийг тэвчихгүй гэдэг хүчтэй дохио өгөх ёстой.

Олон улсын хүний эрхийн стандартад олон улсын хэвлэл мэдээллийн байгууллага болон хараат бус сэтгүүлчдийг ялгаатай гэж үздэггүй. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хагас мэргэжлийн тоног төхөөрөмж, тэр ч байтугай гар утас ашиглан материал цуглуулдаг сонирхогч буюу мэргэжлийн бус-сурвалжлагчдад илүү их найдаж байгаа бөгөөд олон хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтээс мэдээний зураг, бичлэгээ өөрийн сайтдаа байршуулахыг идэвхтэй дэмждэг. Тиймээс жагсаал, цуглаанд ажиллаж буй хэвлэл мэдээллийн бүх ажилтанд цагдаагийн байгууллага адилхан хүндэтгэлтэй хандах ёстой бөгөөд хэвлэл мэдээллийн ажилтнууд албан ёсны итгэмжлэл биедээ авч явах, харуулах тусгай шаардлага, хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага байх ёсгүй. Цагдаагийн үйл ажиллагаанд зүй бусаар саад учруулахгүй л бол жагсаал, цуглааныг тараах тушаал өгсний дараа тухайн газраас гарч чадаагүйн улмаас сэтгүүлчдийг саатуулж болохгүй.

Жагсаал, цуглаан бол олон нийтийн ил задгай талбайд болж буй олон нийтийн арга хэмжээ учраас иргэд болж буй үйл ажиллагааны зургийг авах, бичлэг хийх эрхтэй. Үүнд цагдаагийн байгууллагын ажил үүргээ гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа ч орно. Зарим улс орон үүнийг хуулиар хориглодог, үүний хууль ёсны байх зарчмуудыг баримталж байгаа эсэхийг ажиглах хэрэгтэй. Тиймээс цагдаагийн алба хаагчид жагсаал, цуглаан дээр өөрсдийнх нь зургийг авч, бичлэг хийж байх боломжтой гэдгийг үргэлж анхаарч байх ёстой. Цагдаагийн нийт алба хаагчид өөрсдийн үйлдлийг шууд дамжуулж байгаа мэт биеэ авч явж, хэвлэл мэдээллийн анхааралд орсон тохиолдолд хэт цочмог үйлдэл үзүүлэхгүй байхад тэднийг сургаж, бэлтгэх ёстой. ЕАБХАБ-ын мөн тайланд дурдахдаа:

3. Сэтгүүлчдийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хураан авах, гэмтээж, эвдэхийг санаатайгаар оролдсон нь гэмт хэргийн шинжтэй бөгөөд буруутай этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх ёстой. Хэвлэмэл материал, дүрс бичлэг, дууны клип болон бусад сурвалжлагыг эрх баригчид хураан авах нь шууд цензур тогтоох гэсэн үйлдэл бөгөөд олон улсын стандартаар хориглодог. Хэвлэл мэдээллийн үүрэг, чиг үүрэг, хариуцлага, эрх нь олон нийтийг зохицуулан удирдах үүрэгтэй хууль сахиулагчдыг бэлтгэх сургалтын хөтөлбөртэй салшгүй холбоотой байх ёстой.

Хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрхийг хязгаарлах, хориглох, хөндлөнгөөс оролцох, гэмтээх, тоног төхөөрөмжийг хураах гэсэн аливаа оролдлогыг тухайн хүний хүний эрх, ардчилсан зарчмаар хэв журам сахиулах үндсэн зарчмуудыг зөрчсөн үйлдэл гэж ойлгож болно.

3-Р БҮЛЭГ. ШИЙДВЭР ГАРГАХ БА ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

Шийдвэр гаргах нь тайван жагсаал, цуглаан дээр хэв журам сахиулах ажиллагааг төлөвлөх, дэмжлэг үзүүлэх үйл явцын гол цөм нь болдог төдийгүй цагдаагийн байгууллагын авч буй арга хэм хэмжээ нь тохирсон хэм хэмжээнд, мөн шаардлагатай гэдгийг баталгаажуулах гол үндэслэл болдог. Шийдвэр гаргахдаа өмнөх бүлэгт дурдсан дөрвөн үндсэн зарчим (мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал) дээр суурилсан байх ёстой. Доор дурдсан шийдвэр гаргах үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж, ашигласнаар цагдаагийн байгууллагын авч буй арга хэмжээг аливаа яаралтай нөхцөлд, эсвэл тухайн цаг хугацаанд өрнөж буй нөхцөл байдалд хариу арга хэмжээ авч байгаа эсэх, эсвэл аливаа ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийн үе шатанд хийгдэж буй эсэхээс үл хамааран мэдээлэх, удирдан чиглүүлэхэд ашиглах боломжтой юм.

Шийдвэр гаргалт нь бодит болж буй, эсвэл хүлээгдэж буй нөхцөл байдлын талаар яаран шийдвэр гаргахгүйгээр, харин аль болох бүрэн дүр зургийг гаргаж авахын тулд одоо байгаа мэдлэг мэдээлэл дээрээ тулгуурлахаас эхэлдэг. Үүний тулд эрсдэлд дүн шинжилгээ хийж, аливаа зүйл хэрхэн өөрчлөгдөж болох талаар олон янзын хувилбар гаргах хэрэг болно. Нөхцөл байдлыг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргасны дараа зорилгоо тодорхойлох хэрэгтэй. Тодорхойлсон зорилгодоо хүрэхийн тулд бүгд өөр өөрийн гэсэн үүрэг, эрх мэдэл, үүрэг хариуцлагатай болох бусад хууль сахиулах байгууллагын ажилтнуудтай зайлшгүй хамтран ажиллах ёстой болно. Тиймээс энэ бүх ажлыг бие биетэй нь хэрхэн холбож, мэдээллийг хамгийн сайнаар хэрхэн дамжуулахыг харуулсан мэдээлэл харилцааны сүлжээний дүн шинжилгээг хийх нь нэн чухал. Энэ ажлыг тодорхой болгосны дараа баг тухайн үйл явдлыг зохицуулж чиглүүлэх зорилгоор ашиглах хөндлөнгөөс оролцох хувилбаруудыг боловсруулна. Дахин хэлэхэд, тодорхой арга хэмжээ авсны хариуд үйл явдал хэрхэн өрнөх, янз бүрийн оролцогчид ямар хариу үйлдэл үзүүлж болох, мөн ямар эрсдэл байж болох зэргийг харгалзан үзэхийн тулд хэд хэдэн хувилбаруудыг боловсруулах шаардлагатай.

Энэ бүх үйл явцын туршид бодит байдал дээр юу болж байгааг хянах, оролцогчдыг өөр хооронд нь ялгаж салгах, авч хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээ нь зорьсон үр дүндээ хүрсэн эсэх зэргийг үнэлж дүгнэх нь чухал юм. Хүмүүсийн хийж буй үйлдлийг бүхэлд нь бүрэн хянаж чадна гэж бодох нь буруу, харин хүний зан авир, харилцааны талаар сайн ойлголттой байвал үйл явдлыг эерэгээр зохицуулах боломжтой. Ингэхдээ гаргаж буй үйлдлээ ухамсартайгаар ч, бас бүрэн ухамсарлахгүйгээр ч хийж байгаа хүмүүстэй харьцаж байгаа гэдгээ хэзээ ч мартаж болохгүй. Мэргэжлийн түвшинд хэв журам сахиулна гэдэг нь хүмүүстэй харилцаа тогтоож, харилцан яриа өрнүүлж, албадлагын хэлбэрийг ашиглах гэхээсээ илүүтэйгээр хүмүүсийг хууль ёсны сонголт хийж, хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулахыг ятгах зорилготой. Энэ нь хүмүүст эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн тулд аюулгүй бөгөөд хариуцлагатай байдлаар ажлаа хийж гүйцэтгэхийг хэлнэ. Аюулгүй гэдэг нь цагдаагийн алба хаагчдад ч, олон нийтэд ч адилхан хамаарах бол, хариуцлагатай гэдэг нь та хууль, эрх зүйн үндсэн зарчмуудыг баримтлан ажиллана гэсэн үг юм.

Шийдвэр гаргах загвар

Энэ гарын авлагад ашигласан шийдвэр гаргах загварыг олон улс орны цагдаагийн байгууллага бүх төрлийн нөхцөл байдалд ашиглахаар өргөнөөр нэвтрүүлсэн байдаг бөгөөд доорх Зураг 1-д бүдүүвч байдлаар үзүүлэв. Уг загвар нь мөчлөг бүхий загвар бөгөөд долоон элементээс бүрдэнэ. Энэхүү загварын дагуу мэдлэг, үйл ажиллагааг тасралтгүй хянаж явах шаардлагатай гэж үздэг. Зургаан үе шат нь бүгд хүний эрхэд нийцсэн байх ёстой. Загварыг бүх түвшний командлагчид (түвшин бүрт хүлээх үүрэг хариуцлагатай нийцдэг) шийдвэр гаргах бүхий явцдаа хэрэглэж болох бөгөөд хэрэглэх нь зүйтэй гэж үздэг.

Шийдвэр гаргах загварын долоон элемент. Үүнд:

1. **Мэдээлэл:** Эхний үе шат нь хариуцлагатай албан тушаалтнуудад ирсэн холбогдох бүх мэдээлэл болон тагнуулын мэдээллийг шалгаж, нягтлах явдал юм (байршил, оролцогчид, нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүс, тухайн бүлэг нь өмнө нь өөр жагсаал, цуглаан зохион байгуулсан эсэх г.м.). Энэ нь өмнөх бүлэгт дурдсан мэдлэгийн зарчмын нэг элемент боловч үүнийг харилцаа холбоо тогтоох замаар тулгуурлан гаргаж авна, учир нь мэдлэг мэдээллийг жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон бусад оролцогч талуудтай яриа хэлэлцээ хийх, харилцах зэргээр тасралтгүй үйл явцын үр дүнд цуглуулна.

2. **Эрсдэл ба аюул занал:** Хоёр дахь үе шат нь харилцааны янз бүрийн арга хэлбэрүүдээр дамжуулан олж авсан мэдлэг мэдээлэл дээрээ үндэслэн аливаа эрсдэл, аюул занал (жагсаал, цуглаанд оролцогчдод болон жагсаал, цуглаан нөлөөлсөн бүх хүмүүст, түүнчлэн цагдаа, онцгой байдлын алба гэх мэт жагсаал, цуглаанд хэв журам сахиулж, хамгаалах үүргээр оролцож буй хүмүүст)-ыг нягталж шалгах явдал юм. Үүний тулд янз бүрийн боломжит хувилбаруудыг гарган ирж, болзошгүй эрсдэл, аюул заналыг төлөвлөх шаардлагатай болно.
3. **Стратегийн зорилго:** Эрсдэл, аюул заналыг нягталж хянасны дараа командлалын офицер нь хэв журам сахиулах ажиллагааны стратегийн зорилгыг тодорхойлж, хяналтдаа байлгана;
4. **Хэв журам хамгаалах зорилт, болзошгүй нөхцөл байдал:** Дараа нь командлалын офицер хэв журам хамгаалах ажиллагааны зорилтуудын аль нь тухайн жагсаал, цуглааныг хамгаалж, хэв журам сахиулах стратегийн зорилгод хамгийн сайн хүрэх вэ гэдгийг авч үзэж шийднэ;
5. **Ажиллагааны хувилбарууд:** Дараа нь командлалын ажилтан хэв журам сахиулах ямар тактик стратегийн зорилгод хамгийн сайн хүрэх вэ гэдгийг авч үзэж шийднэ.
6. **Арга хэмжээ авах, эргэн хянах:** Мөчлөгийн зургаа дахь үе шат бол зохих тактикийг хэрэгжүүлэх явдал юм. Үүнд стратегийн, эсвэл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эсвэл ажиллагааны явцад газар дээр нь арга хэмжээ авах ч орж болно. Цаашилбал, командлалын офицер байгаа нотлох баримтыг хянаж, шийдвэр гаргах мөчлөгийн шинэ үе шатыг эхлүүлэх боломжтой болно.
7. **Шаардлагатай байдал ба тохирсон хэм хэмжээнд байх:** Бүх үе шатанд цагдаагийн байгууллагын арга барил нь олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн байх ёстой бөгөөд иймээс тохирсон хэм хэмжээнд, мөн шаардлагатай байх ёстойгоос гадна хүссэн зорилгодоо хүрэхэд шаардагдах нийтийн хэв журам хамгаалах ажиллагааны хамгийн бага хэлбэрийг оруулсан байх ёстой. Шийдвэр гаргах бүхий л үйл явцад эдгээр зарчмуудыг баримтлах ёстой.

Шийдвэр гаргах үйл явцын янз бүрийн үе шатанд цагдаагийн командлагч нар хамгийн сүүлийн буюу шинэлэг мэдлэг мэдээлэлтэй ажиллаж байгаа эсэх, шийдвэр гаргалт нь жагсаал, цуглаанд оролцогчид болон бусад оролцогчдын ялгаатай байдлыг тусгаж, болж буй үйл ажиллагааг хамгаалахад чиглэсэн байх зэргийг баталгаажуулахыг зорихоос гадна гаргасан шийдвэрийг цагдаагийн алба хаагчид, жагсаал, цуглааныг зохион байгуулагчид, үйл ажиллагаан дээр байгаа бусад хүмүүс болон олон нийтэд үр дүнтэй хүргэхийг эрмэлзэх ёстой.

Хэдийгээр энэхүү гарын авлагад ашигласан шийдвэр гаргах загвар нь командлагчдын шийдвэр гаргахад хамаарч байгаа хэдий ч уг загварыг командлалын бүтэц дэх янз бүрийн түвшинд ажиллаж буй алба хаагчид төдийгүй гудамж талбайд болж буй жагсаал, цуглаан дээр бие даан ажилладаг цагдаа нарын ажил дээр ч ашиглах нь зүйтэй.

Зураг 1: Шийдвэр гаргах загварын мөчлөг



Шийдвэр гаргах загварыг жагсаал, цуглааны бэлтгэл, төлөвлөлтийн үе шатанд ашиглахаас гадна урьдчилан мэдэгдсэн, эсвэл аяндаа гарсан зэргээс үл хамааран бүх төрлийн жагсаал, цуглаантай холбоотой тактикийн үйл ажиллагааны янз бүрийн үе шатанд, мөн бүх төрлийн хэмжээтэй жагсаал, цуглаанд хэрэглэх ёстой. Дээр дурдсанчлан шийдвэр гаргахдаа мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал гэсэн дөрвөн үндсэн зарчмыг харгалзан үзэх ёстой.

Арга хэмжээний үеэр хэв журам хамгаалах төлөвлөгөөг өөрчлөх, тухайлбал, жагсаал, цуглаанд шаардлагатай хязгаарлалт хийх, шинэ мэдээлэлд хариу

өгөх зэрэг шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрээ зохион байгуулагчдад мэдэгдэж, боломжтой бол, хориг хязгаарлалтыг харилцан ярилцах замаар зөвшөөрөл авсны үндсэн дээр тавих нь чухал юм.

Жагсаал, цуглаанд оролцож буй хүмүүсийн эрхийг хязгаарлах, хүч хэрэглэх, бусад эрх, эрх чөлөөнд халдах (тухайлбал, нууц ажилтан ашиглах, энэ нь хувийн нууцад нөлөөлнө) шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэрийг бичгээр тодорхой ойлгогдохоор ил тод гаргах ёстой бөгөөд тухайн шийдвэрийг гаргасан албан тушаалтантай нь холбож өгсөн байх ёстой. Ийм шийдвэрийг мэдээлэл өгөх хурал дээр хянан үзэх ёстой бөгөөд цагдаагийн практикт ямар нэгэн лавлагаа материал болгож болно.

Шийдвэр гаргах үйл явц, шийдвэрийн цаана болж буй үйл явц, ялангуяа хүний эрхэд нөлөөлж буй үйл явцыг хожим нь шалгаж хянахын тулд бүртгэлжүүлэх ёстой. Бүх шатны цагдаагийн алба хаагчид ямар мэдээлэлд нийцүүлэн ажиллаж байсан, юуг хууль ёсны дагуу хэрэгжүүлэхийг зорьж байсан, хувилбаруудыг авч үзэх хугацаа гарахад ямар хувилбаруудыг авч үзсэн, авсан арга хэмжээ, эцэст нь тухайн арга хэмжээний үр дүн зэргийг харуулах нь чухал.

Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн үнэлгээ нь нийтийн жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой төлөвлөлт, бэлтгэл, хэв журмын хамгаалалтын бүх үе шатанд шийдвэр гаргах үйл явцын салшгүй нэг хэсэг юм.

Мэдлэг нь энэхүү үнэлгээний үйл явцын түлхүүр бөгөөд тагнуулын мэдээллээр дамжуулан бий болдог. Санал болгож буй үйл явдал, уг үйл явдлыг төлөвлөж байгаа болон дэмжин оролцож буй хүмүүс (магадгүй эсэргүүцэж ч болзошгүй), өмнөх ижил төстэй үйл явдлын түүхүүд зэрэг тагнуулын нэгжийн нарийн судалгаа, үнэлгээ нь командлагчдад аливаа жагсаал, цуглаантай холбоотой учирч болзошгүй эрсдэлийг зөв үнэлэх байр суурьтай болгодог.

Тодорхой нэг үйл явдал, түүнд оролцогчид, мөн тухайн үйл явдлын нөлөөнд өртөж болзошгүй хүмүүс болон түүнийг дэмжин ажиллаж буй хүмүүс (жишээ нь, цагдаа, онцгой байдлын албаны хамтрагчид)-тэй холбоотой эрсдлийг үнэлэх хэд хэдэн арга байдаг. Практик ач холбогдолтой бөгөөд үр дүнтэй нэг арга бол тодорхой хязгаарлагдмал тооны хувилбар сценариудыг болон жагсаал, цуглаанд оролцогчид, түүний нөлөөнд өртөх болон дэмжин

ажиллаж буй хүмүүст тохиолдож болох холбоотой эрсдэлийг тодорхойлох явдал юм.

Командлагчид тодорхой эрсдэл (жишээ нь, төсөөлж байснаас хамаагүй олон тооны оролцогч байвал ямар эрсдэл гарах, эсвэл эсрэг жагсаал болбол ямар эрсдэл гарах г.м.)-ийг болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар бодолцох ёстой. Гэнэтийн нөхцөл байдал үүсэх, эсвэл нөхцөл байдал хамгийн муугаар эргэх (жишээ нь, цаг агаарын гэнэтийн таагүй нөхцөл байдал) болбол болзошгүй нөхцөл байдлын нөөц төлөвлөгөөг гаргах ёстой.

Шийдвэр гаргах загварын дагуу стратегийн зорилго, хэв журам сахиулах ажиллагааны зорилтууд, болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлох зэрэг ажлуудын өмнө эрсдэл, аюулыг тодорхойлох ёстой. Ажиллагааны янз бүрийн хувилбаруудыг сонгохдоо эрсдэл, аюулыг харгалзан үзэхийн зэрэгцээ эдгээр хувилбараа хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэл, аюулыг бас харгалзан үзэх шаардлагатай. Жагсаал, цуглааны явцад эрсдэл ба аюулууд өөрчлөгддөг тул үйл явдал явагдаж байх явцад эрсдэлийн динамик буюу хувьсан өөрчлөгдөж буй байдлын үнэлгээг хийх шаардлагатай болдог¹⁹.

19 Stott, C. & O. Adang, Европын Холбоонд хөлбөмбөгийн тэмцээний үеэр хэв журам хамгаалахад олон улсын хэмжүүрийг баримтлах нь: Эрсдэлийг ойлгож, удирдах: (Ливерпүүл, 2009), <http://www.academia.edu/3012119/Policing_Football_Matches_with_an_International_Dimension_in_the_European_Union_understanding_and_managing_risk>.

II Хэсэг

ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ӨМНӨ:

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ТӨЛӨВЛӨЛТ

4-Р БҮЛЭГ. КОМАНДЛАЛЫН БҮТЭЦ

Цагдаагийн байгууллага тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хамгаалж, жагсаал, цуглааныг эмх цэгцтэй явуулахад гол үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ цагдаагийн байгууллагын оролцооны мөн чанар, цар хүрээ, цаг хугацаа нь улс орон тус бүрт мөрдөгдөж буй хууль тогтоомж, холбогдох журмаас хамаардаг. Зарим улс оронд бүх жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллагад мэдэгдэх ёстой бөгөөд цагдаагийн байгууллага хязгаарлалт тогтоох эрхтэй байдаг бол, зарим улсад ийм эрх мэдэл, үүрэг хариуцлагыг орон нутгийн засаг захиргаа, эсвэл бусад эрх бүхий байгууллага хариуцдаг бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн гүйцэтгэх үүрэг нь нийтийн хэв журмыг хамгаалахын зэрэгцээ тухайн эрх бүхий байгууллагын шийдвэрийг мөрдүүлэхэд оршдог.

Ихэнх жагсаал, цуглаан нь ердийн өдөр тутмын хэв журам сахиулах ажиллагаанаас давсан албан ёсны командлалын бүтэц, айхтар нарийн үйл ажиллагаа шаардахгүйгээр явагддаг бөгөөд цөөн тооны цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тухайн жагсаал, цуглаан нь жижиг байх тусам замын хөдөлгөөнд нөлөөлөх нь бага, бусдын эрхийг хязгаарлаж саатуулах нь ч бага, маргаан эсэргүүцэл татахааргүй бол цагдаагийн байгууллага доор дурдсан командлалын бүтцийн зөвхөн тодорхой хэсгийг л хэрэгжүүлэхээр шийдвэрлэж болно. Гэсэн хэдий ч, энэ бүлэгт заасан үндсэн зарчмуудыг бүх жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалахад баримтлах нь зүйтэй.

Жагсаал, цуглаан дээр хэв журам сахиулахаар ажиллаж буй цагдаагийн байгууллага нь цагдаагийн алба хаагчдын үйлдэл, эс үйлдлийг эцсийн дүндээ ямар ахлах тушаалын офицер хариуцаж байгааг тодорхойлох боломжтой байхын тулд нэгдсэн тодорхой командлалын бүтэцтэй байх ёстой. Ялангуяа хэв журам сахиулах өөр өөр байгууллага, эсвэл өөр өөр газарзүйн байрлалаас ирсэн цагдаагийн алба хаагчид болон бусад агентлагууд нэг үйл ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд энэ нь зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр гаргасан стратеги төлөвлөгөөг дагаж мөрдөх, хоорондын уялдаа холбоог хангах, үүрэг хариуцлага болон хариуцлага тооцох нөхцөлийг тодорхой болгож өгнө. Жагсаал, цуглаан нь товлосон байх, эсвэл өөрөө аяндаа болсон ч бай, тодорхой командлалын бүтцийг тогтоож өгөх нь маш чухал. Нэгдмэл удирдлагын зарчим нь командлалын эсвэл удирдлагын чиг үүрэг бүхий хүн бүр дараах зүйлийг мэддэг байх ёстой гэж үздэг. Үүнд:

- Тухайн хүн хэнд илтгэж тайлагнах;
- Тухайн хүний үүрэг, хүлээх хариуцлага, зорилтууд;

- Ямар нөөц хуваарилагдсан, мөн ашиглах боломжтой;
- Тухайн хүний хариуцах газар зүйн эсвэл чиг үүрэгт хамаарах нутаг дэвсгэр.

Гурван өөр түвшний командлалыг тогтоож болох бөгөөд ахлах тушаалын буюу «стратегийн» (ерөнхий удирдлагаар хангах), дунд тушаалын буюу «үйл ажиллагааны» (ерөнхий стратегийн төлөвлөгөөний хүрээнд хэв журам хамгаалах үйл ажиллагааны тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх зорилготой), доод тушаалын буюу «тактикийн» (хэв журам сахиулах үйл ажиллагааны хувьд бодит «үр дүн» гарч ирдэг) түвшин гэж үзэж болно²⁰. Үүнийг заримдаа «алт, мөнгө, хүрэл» командлалын бүтэц гэж нэрлэдэг. Ихэнхдээ стратегийн командлагч нэг байх ёстой гэж үздэг бол, үйл ажиллагааны командлагч нь нэгээс дээш байхыг шаарддаг, харин тактикийн түвшинд хэд хэдэн командлагч байх нь элбэг. Жагсаал, цуглааны хэв журам сахиулах үед командлалын үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчид нь тухайн үүргийг гүйцэтгэхэд зохих ёсоор сургаж бэлтгэгдэж, эрх олгогдсон байх ёстой.

Зураг 2: Командлалын бүтэц

Командлалын түвшин	Хариуцлага
Ахлах	Стратегийн
Дунд	Үйл ажиллагааны
Доод	Тактикийн

Цагдаагийн байгууллагад цол зэргийн янз бүрийн бүтэц, үүрэг хариуцлагын шатлал байдаг боловч энэхүү баримт бичигт командлалын бүтэц шатлалыг цол хэргэм гэхээсээ илүү хүлээх үүрэг, хариуцлага дээр нь үндэслэн тодорхойлсон. Шийдвэр гаргах ажлыг аль болох алба хаагч бүрийн хүлээх үүрэг хариуцлагын хүрээнд хамгийн доод түвшинд гаргах ёстой.

²⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд ажиллах цагдаагийн байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагааны газар, 2013, Ref.2009. 32, <http://www.un.org/en/peacekeeping/sites/police/documents/formed_police_unit_policy_032010.pdf>.

ЕАБХАБ-ын бүс нутагт хамаарах зарим хэсэгт хэв журам сахиулах үйл ажиллагааны арга хэлбэр нь олон нийтэд илүү чиглэсэн, янз бүрийн цол зэрэг бүхий албан тушаалтнууд тодорхой нөхцөл байдалд нийцүүлэн бие даан шийдвэр гаргах тодорхой хэмжээний бие даасан, өөрийн үзэмжээр шийдвэр гаргах эрхтэй байдаг. Энэ аргыг ихэвчлэн «олон нийттэй хамтран эмх журам хамгаалах» гэж нэрлэдэг. Харин ЕАБХАБ-ын зарим бүс нутагт хэв журам сахиулах үйл ажиллагааг төв засгийн газраас илүү хатуу хянадаг бөгөөд «нийтийн хэв журмыг сахиулах» хэв маягтай байдаг. Сүүлийн энэ хэв маягт командлалын бүтэц нь цэргийн байгууллагын удирдлагатай илүү төстэй байж болох бөгөөд шийдвэр гаргах үйл явцыг ихэвчлэн албан тушаалын цолны шатлалын дагуу хийгддэг.

Стратегийн командлал

Стратегийн командлагч нь стратеги төлөвлөгөө, хэв журам сахиулах үйл ажиллагааны хэв маяг, хэвлэл мэдээлэлтэй ажиллах стратегийг боловсруулах, арга хэмжээнд шаардлагатай нөөцийн зөвшөөрөл олгох, хуваарилах үүрэгтэй цагдаагийн ахлах албан тушаалтан юм. Нарийн төвөгтэй жагсаал, цуглааны хувьд стратегийн командлагч нь цагдаагийн байгууллагын гүйцэтгэх түвшинд ажиллах, цагдаагийн байгууллагын эд хөрөнгийн нэлээд хэсгийг хянаж удирдах ёстой.

Гурван түвшний командлалын хоорондох энэхүү ялгаа нь НҮБ-ын бодлоготой нийцэж байгаа боловч зарим гишүүн улсуудад тактикийн болон үйл ажиллагааны түвшний нэр томъёог сольж хэрэглэсэн байдаг. Нэгдсэн ойлголттой байх үүднээс энэхүү гарын авлагад НҮБ-аас санал болгосон нэр томъёог ашиглах болно.

Стратегийн командлагч нь тухайн жагсаал, цуглаантай холбогдуулан цагдаагийн байгууллагын гүйцэтгэх стратегийн зорилгыг тодорхойлсон стратегийн төлөвлөгөөг бичгээр боловсруулах үүрэгтэй (жишээ нь, тайван жагсаал, цуглааныг зохицуулах, замын хөдөлгөөнийг хязгаарлах, ноцтой гэмт хэргийн сэжигтнийг баривчлах гэх мэт).

Стратегийн командлагч нь жагсаал, цуглааны хэв журам сахиулахад хангалттай нөөцөөр хангах үүрэгтэй. Нөөцийг олон зүйлд ашиглах шаардлага байгаа тохиолдолд хэв журам сахиулах ерөнхий үүргийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхин тулд хаана хуваарилах нь зүйтэй гэдгийг командлагч шийднэ. Стратегийн командлагч нь зарим хувилбаруудыг ашиглахыг хүсэхгүй, эсвэл тодорхой арга хэмжээ авах эрх нь стратегийн

түвшинд байна гэж үзвэл үйл ажиллагааны тодорхой хувилбаруудад хязгаарлалт тавьж болно. Жишээлбэл, жагсаал, цуглааныг албадан тараах аливаа шийдвэр нь стратегийн командлагчийн зөвшөөрлийн дагуу хийгдэх шаардлагатай.

Жагсаал, цуглаан эхэлмэгц стратегийн командлагч тухайн жагсаал, цуглаан болж буй газраас зайдуу газраас үйл ажиллагааны ерөнхий тоймтой танилцана. Стратегийн командлагч нь тодорхой асуудалд анхаарлаа төвлөрүүлэхээс илүүтэйгээр үйл явдлыг бүхэлд нь ерөнхийд нь тоймлон харж хянах чадвартай байх ёстой бөгөөд стратегийн командлагч жагсаал, цуглаан болж буй газар дээр өөрийн биеэр байлцах нь тодорхой чиг үүргийг хэн хариуцаж байгаа талаар төөрөгдөл үүсгэж болзошгүй.

Стратегийн командлагч нь үйл ажиллагааны командлагчдын ажлын ачааллын тэнцвэрийг хангах үүрэгтэй бөгөөд ингэснээр үйл явц сунжирч удаан үргэлжлэх үед командлагчдыг амраах, тайвшруулах боломжийг олгодог. Стратегийн командлагч нь мөн үйл ажиллагааны командлагчийн гаргасан төлөвлөгөөнд гарын үсэг зурах ёстой.

Стратегийн командлал (эсвэл зарим тохиолдолд зарим онцгой жагсаал, цуглаанаас хамааран үйл ажиллагааны удирдлага нь), эсвэл тэдгээрийн төлөөлөгчид үйл явдлын эхний үе шатанд жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон бусад холбогдох талуудтай холбогдож, хэрхэн холбоо харилцаа барьж ажиллах, тухайн өдрийн буюу үйл явдлын үр дүн ямар байх зэргийг тодорхойлох шаардлагатай.

Стратегийн командлал нь:

- Стратегийн төлөвлөгөө, хэв журам сахиулах арга барил, хэвлэл мэдээлэлтэй ажиллах стратегийг боловсруулж, эдгээрийгээ үйл ажиллагааны командлагч(ид)-ад дамжуулж мэдээлэх;
- Нөөц ашиглах зөвшөөрөл олгож, хуваарилах;
- Тагнуул, мөрдөн шалгах, дэмжих зэрэг шаардлагатай чиг үүргүүдийг багтаасан удирдлагын нэгдсэн командлалын бүтцийг бий болгох;
- Гаргасан шийдвэр бүрийг бүртгэж баримтжуулж байгаа эсэхийг шалгах;
- Жагсаал, цуглааны зохион байгуулагчид болон бусад оролцогч талуудтай харилцах;
- Үйл ажиллагааны командлагч(ид)-ын ажиллах төлөвлөгөөг батлах;
- Хүний эрхэд суурилсан арга барилд тулгуурлан, тагнуулын мэдээлэл, эрсдэл, боломжит хувилбаруудыг харгалзан үздэг процессыг ашиглан шийдвэр гаргах, эдгээр шийдвэрүүдээ бичиж бүртгэх;

- Командлалын төвд байж, үйл ажиллагааг ерөнхийд нь тоймлон удирдах (үйл явдал өрнөх бүхий л явцад стратегийн зорилго нь хамааралтай хэвээр байхын тулд).

Стратегийн командлалын дэмжлэг: Стратегийн командлагч жагсаал, цуглаан (томоохон хэмжээний жагсаал, цуглааныг зохицуулах ажилд бэлтгэхдээ) болон шаардлагатай нөөц хөрөнгийг хянахын тулд, зайдуу газар тохиромжтой байгууламж барилгад байршин, үйл ажиллагааны командлагч болон бусад холбогдох талуудтай харилцах холбоо харилцааны шугамтай байх ёстой. Стратегийн командлал нь командлалын байранд радио холбооны операторууд, утасны дуудлага хүлээн авч хариулах ажилтнууд, мэргэжлийн зөвлөхүүд (шаардлагатай бол), тагнуулын ажилтнууд, бүртгэл хөтлөгчид, хэвлэл мэдээллийн ажилтан, магадгүй өөр байгууллагын ижил төстэй албан тушаал дээр ажилладаг бусад гол оролцогч талуудын төлөөлөл (жишээ нь, гал түймэр, түргэн тусламж, орон нутгийн засаг захиргаа г.м.)-ийг багтаасан багийг бүрдүүлсэн байх ёстой.

Түүнчлэн командлалын байранд дараах зүйлс байх ёстой. Үүнд:

- Холбоо барих хангалттай тооны утас;
- Хэд хэдэн радио холбоо (эвдэрч ажиллахгүй болсон тохиолдолд);
- Гарсан тушаал шийдвэрийн бүртгэл, үйл явдлын бүртгэл;
- CCTV/камерын хяналт;
- Газрын зураг, эсвэл байршил харуулах систем;
- Үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөө;
- Мэдээлэл хийх тусдаа өрөө (эсвэл хурлын өрөө);
- Аудио-видео хяналт хийх боломжтой бүх эх сурвалж (жишээ нь, нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх хэрэгсэл [UAV]);
- Гар утасны сүлжээний дохиолол;
- Холбогдох утасны дугаар болон дуудлага хийх тэмдэглээний жагсаалт.

Ихэнх жагсаал, цуглаанд нарийн тоноглогдсон хяналтын өрөө, нөөц хөрөнгө бүрдүүлэх шаардлагагүй байж болно. Гэсэн хэдий ч дээр дурдсан зүйлсийг томоохон арга хэмжээнүүд дээр, эсвэл цагдаагийн нөөц хөрөнгө шаардлагатай үед сайн туршлага болгон ашиглахыг зөвлөж байна.

Үйл ажиллагааны командлал

Үйл ажиллагааны командлагч нар дээд шатны командлагчийн стратегийн зорилгыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд жагсаал, цуглааны зохицуулах

практик төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, алба хаагчдад мэдээлэл танилцуулах, алба хаагчдыг байршуулах, арга хэмжээний үеэр нөөц хөрөнгийг удирдах зэрэг багтана. Жижиг арга хэмжээнээс бусад тохиолдолд үйл ажиллагааны командлагч нар жагсаал, цуглаан болж буй газраас хол байх ёстой. Хэрэв томоохон хэмжээний арга хэмжээнүүд дээр үйл ажиллагааны командлагч тухайн газар дээр нь байх юм бол тэд жижиг сажиг асуудлуудад оролцоод, үйл явдлыг бүхэлд нь харж хянах хараа хяналтаа алдах эрсдэлтэй. Үүнээс гадна энэ нь тактикийн командлагчдад төөрөгдөл төрүүлж, тэднийг тухайн чиг үүрэг, газар дээр хэн нь удирдлагаар хангаж байгаад эргэлзэхэд хүргэж болзошгүй.

Томоохон, нарийн төвөгтэй, эсвэл удаан үргэлжлэх үйл явдлууд, эсвэл том хэмжээний газар талбай хамран болж буй үйл явдлын хувьд нэгээс дээш үйл ажиллагааны командлагч ажиллуулах шаардлагатай байж болно. Хэрэв хэд хэдэн ажиллагааны командлагч ажиллуулах шийдвэр гаргасан бол стратегийн командлагч дараах нөхцөлийг хангасан байх ёстой. Үүнд:

- Тушаал шийдвэр, үүрэг хариуцлагын зааг ялгааг харуулсан тодорхой бөгөөд нэгдсэн ойлголттой тушаал шийдвэрийн протоколуудтай байх;
- Стратегийн командлагчийг үйл ажиллагааны шинжтэй шийдвэр гаргах ажиллагаанд оруулж ирэх хийдэл, цоорхой командлалын бүтцэд нь байхгүй байх;
- Харилцаа холбооны шугам, холбогдох үүрэг хариуцлага нь тодорхой, ойлгомжтой байх;
- Үйл ажиллагааны командлагч бүр үүргээ гүйцэтгэхэд хангалттай бэлтгэгдсэн, чадвартай байх.

Үйл ажиллагааны командлагч нь:

- Жагсаал, цуглааны хэв журмыг хэрхэн сахиулах талаар үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хянаж, уялдуулан зохицуулах;
- Газар дээр ажиллах командлалын бүтцийг бий болгох;
- Төлөвлөгөө нь стратегийн зорилгын дагуу явагдаж буй эсэхийг хянаж байхын тулд стратегийн командлагчтай харилцах;
- Хүний эрхэд суурилсан арга барилд тулгуурлан тагнуулын мэдээлэл, эрсдэл, боломжит хувилбаруудыг харгалзан үзсэн процедур ашиглан шийдвэр гаргах, шийдвэрүүдээ бүртгэл хийх;
- Үйл ажиллагааны аль ч хэсгийг хариуцан ажиллах боломжтой байхын тулд командлалын гол цэгт байрлах;
- Төлөвлөгөөний талаар тактикийн командлагчдад танилцуулж, арга хэмжээний явцад төлөвлөгөө өөрчлөгдөхөд холбогдох мэдээллийг дамжуулах;

- Тактикийн командлагчдын үйл ажиллагаа нь стратегийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг хариуцах;
- Бүх алба хаагчдад стратегийн зорилго, өөрсдийнх хүлээх тодорхой үүргүүд, үүрэгт нь хамаарах аливаа хязгаарлалтын талаар мэдээлэл өгөх;
- Төрөл бүрийн үйл ажиллагааны нөөц төлөвлөгөө, хувилбаруудын хэрэгжилтийг хариуцах;
- Цагдаагийн алба хаагчдыг байршуулах, ажиллагааны хэмжээ нь аюулын зэргийн талаарх тагнуулын мэдээлэл дээр үндэслэн зохих хэмжээнд байгаа эсэхийг шалгах.

Үйл ажиллагааны командлалын дэмжлэг: Ерөнхий тойм ойлголттой байхын тулд үйл ажиллагааны командлагч нь болж буй үйл явдлаас зайдуу байрлаж, харин тухайн ажиллагаатай холбоотой бүх шийдвэрийг гаргаж, бүртгэж явахын тулд тухайн газар дээр ажиллаж буй цагдаагийн алба хаагч нартай шууд холбогдох боломжтой байх ёстой. Үйл ажиллагааны командлагч нь командлалын өрөөг радио холбоо, телефон утасны операторууд, мэргэжлийн зөвлөхүүд (шаардлагатай бол), тагнуулын ажилтнууд, бүртгэл хөтлөгч, хэвлэл мэдээллийн ажилтан болон бусад гол байгууллагуудын төлөөлөл (жишээ нь, гал түймэр, түргэн тусламж, орон нутгийн засаг захиргаа)-ийг байлцуулах зэрэг асуудлыг хариуцна.

Зарим улс оронд цагдаа нар шуурхай ажиллагааны командлагч, хэвлэл мэдээллийн ажилтан, радио оператор зэрэг 6 хүртэлх цагдаагийн алба хаагчийг нэг автобусанд байрлуулан ажиллуулдаг. Ийм автобус нь харилцаа холбооны төвийн үүрэг гүйцэтгэхээр тоноглогдсон байх ба нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагааны явцад тодорхой хэмжээний уян хатан байдлыг хангадаг.

Үйл ажиллагааны командлалын байранд дараах зүйлс бас байх ёстой. Үүнд:

- Холбоо барих хангалттай тооны утас;
- Хэд хэдэн радио холбоо (эвдэрч ажиллахгүй болсон тохиолдолд);
- Гарсан тушаал шийдвэрийн протокол, үйл явдлын бүртгэл;
- CCTV/камерын хяналт;
- Газрын зураг, эсвэл байршил харуулах систем;
- Үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөө;
- Мэдээлэл хийх тусдаа өрөө (эсвэл хурлын өрөө);
- Гар утасны сүлжээний дохиолол;
- Холбогдох утасны дугаар болон дуудлага хийх тэмдэглээний жагсаалт.

Тактикийн командлал

Тактикийн командлагчдын үүрэг бол хариуцаж буй тодорхой нутаг дэвсгэр дотор нь онцгой чиг үүрэг гүйцэтгүүлэхээр, эсвэл тодорхой хөрөнгийг хариуцуулахаар үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг хэсэг болгон байршуулсан нөөцийг хамгаалж хянах явдал юм. Тактикийн командлагчид нь үйл ажиллагааны командлагчид тайлагнадаг, тодорхой үүрэг даалгаварын дагуу хамгаалалт хийхээр байршуулсан, удирдлагадаа хэд хэдэн албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байдаг. Нутаг дэвсгэр хариуцсан болон чиг үүрэг хариуцсан гэсэн хоёр төрлийн тактикийн командлал байдаг.

- Нутаг дэвсгэр хариуцсан командлагч нь үйл ажиллагааны командлагчийн тодорхойлсон тодорхой байршил, бүсийг хариуцна. Тэрээр өөрийн удирдлаган дор хэд хэдэн офицертой байх ба үйл ажиллагааны хэд хэдэн сонголттой байж болно. Тэрээр тухайн албан тушаалтнуудад эдгээр сонголтыг ашиглах зөвшөөрөл олгохоос өмнө тухайн ажиллагааг гүйцэтгэхэд анхаарах зүйлс эхлээд хангагдсан эсэхийг баталгаажуулна. Газарзүйн командлагч нь цаашид шаардлагагүй бол өгсөн зөвшөөрлийг буцаан татах үүрэгтэй.
- Чиг үүрэг хариуцсан командлагч нь нутаг дэвсгэр хариуцсан командлагчтай адил үүрэг хүлээнэ. Гэхдээ тодорхой нэг байршил, нутаг дэвсгэрийг хариуцахын оронд тодорхой чиг үүрэг гүйцэтгэдэг. Зарим жишээ гэвэл:
 - *Олон нийтийн командлагчид*: Ийм командлагчид, тэдний туслах ажилтнууд нь жагсаал, цуглааныг зохион байгуулагчид, тэдгээрийн төлөөлөгчидтэй болон үйл ажиллагааны командлагчийн хооронд тухайн үйл явдлын өмнө, дундуур болон дараа нь харилцан ярилцах боломж нөхцлийг нээлттэй байлгах үүрэгтэй. Мөн тэд илүү өргөн хүрээнд олон нийтийн оролцоог бий болгохыг хариуцдаг;
 - *Замын хөдөлгөөн хариуцсан командлагчид*: Ийм командлагчид, тэдний туслах ажилтнууд нь жагсаал, цуглааны эргэн тойронд замын хөдөлгөөний хэвийн урсгалыг хангах үүрэгтэй. Тэд шаардлагатай бол урсгалыг өөрчлөх, эсвэл хөдөлгөөнийг зогсоож, тухайн газрыг аль болох хурдан хэвийн байдалд оруулахыг хариуцдаг;
 - *Харилцаа холбооны командлагчид*: Ийм командлагчид, тэдний туслах ажилтнууд нь цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх команд, удирдлагын байрыг боловсон хүчнээр хангах үүрэгтэй. Энэ үүргийг гүйцэтгэж буй командлагч нь цагдаагийн холбооны хэрэгсэл ашиглах, яаралтай тусламжийн үйлчилгээний байгууллагуудтай харилцах арга замууд, компьютерийн зураглалын программ хангамж, камерын хяналт, түүнчлэн нийгмийн сүлжээ

- (жишээ нь, твиттер)-г хэрхэн хянах, ашиглах талаар туршлагатай байх ёстой;
- *Гэмт хэрэг хариуцсан командлагч*: Ийм командлагчид, тэдний туслах ажилтнууд нь жагсаал, цуглааны үеэр мэдээлэгдсэн аливаа гэмт хэргийг мөрдөн шалгах, баривчлагдсан хүмүүсийг хянан шалгах ажиллагааг хянана. Үйл явдлын өмнө стратегийн командлагч нь жагсаал, цуглаантай холбоотой хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах ажиллагааны параметр буюу үзүүлэлт, цар хүрээ, баривчлагдсан хүмүүсийг яллах бодлогыг тодорхойлно;
 - Бусад төрлийн функциональ буюу чиг үүргийн тактикийн командлагчдын багт яриа хэлцэл хариуцсан хэсэг, тодорхой техник хэрэгсэл (жишээ нь, галт зэвсгийн баг, эсвэл нийтийн хэв журам хамгаалах нэгж г.м.)-ийг хариуцагч, эсвэл хэвлэл мэдээлэлтэй харилцах ажилтан багтаж болно.

Тактикийн командлагчдын үүрэг, хариуцлагад дараах зүйлс орно. Үүнд:

- Стратегийн зорилго, хэв журам сахиулах ажиллагааны зорилтын талаар тодорхой ойлголттой байх;
- Үйл ажиллагааны командлал (болон командлалын протоколоор тохиролцсон болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөө)-ын дагуу өөрийн хяналтан дор хэв журам сахиулах тактикийг хэрэгжүүлэх;
- Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэр гаргаж, үйл ажиллагааны явцад хариуцсан офицеруудад мэдээлэл өгөх, хяналт тавих;
- Ямар ч үед өөрийн үүргээ гүйцэтгэхэд ямагт бэлэн байх;
- Шаардлагатай тохиолдолд, холбогдох бүх мэдээлэл үйл ажиллагааны командлагчид дамжуулагдаж байгаа эсэхийг баталгаажуулах.

Тактикийн командлагчид нь өөрсдөө болон баг бүрэлдэхүүн нь стратегийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж буй эсэхийг хянан баталгаажуулдаг. Тэд үйл ажиллагааны эхний үе шат эхлэхээс өмнө бүх албан хаагчдадаа энэ мэдээллийг танилцуулж, үйл явдал болоод дууссаны дараа ажилтнууддаа мөн мэдээлэл өгөх үүрэгтэй.

Тактикийн командлагч нь холбогдох мэдээллийг үйл ажиллагааны командлагч руу дамжуулж, холбогдох шинэ мэдээллийг өөрийн хяналтад байгаа алба хаагчдад дамжуулсан эсэхийг баталгаажуулна. Мөн өөрийн командлал дор байгаа алба хаагчдын зан байдлыг үргэлж хариуцах болно.

Үүрэг, хариуцлагууд

Энэхүү гурван командлалын түвшин тус бүр нь жагсаал, цуглааныг төлөвлөх, бэлтгэх, хэв журмыг хамгаалж зохицуулах, үйл явдлын дараа мэдээлэл хийх зэрэгт өөр өөрийн гэсэн онцгой үүрэг, хариуцлагатай оролцдог. Гарын авлагын дараа дараачийн бүлгүүдэд үе шат болгон дээр, мөн командлалын түвшин бүрт хийгдэх тодорхой үүрэг даалгавар, үйл ажиллагааг тоймлон харуулав.

Гэхдээ зарим үйл ажиллагааг командлалын гурван түвшин бүрт, өөр өөр үе шатанд офицерууд гүйцэтгэдэг гэдгийг санах нь зүйтэй. Ялангуяа, бүх командлалын офицерууд арга хэмжээний зохион байгуулагчид, бусад гол оролцогч талуудтай харилцах, өмнөх бүлэгт дурдсан шийдвэр гаргах загвар, эрсдэлийн үнэлгээний үйл явц дээр тулгуурлан ажиллаж, ажил үүргээ төлөвлөх, хэрэгжүүлэхдээ дөрвөн үндсэн зарчим ашиглана.

5-Р БҮЛЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ

Жагсаал, цуглаанд бэлтгэхийн тулд стратегийн командлагч стратегийн бүх санаа зорилгоо бичгээр төлөвлөгөөнд нэгтгэн боловсруулах бөгөөд төлөвлөгөөнд мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал гэсэн дөрвөн үндсэн стратегийн зарчмыг тусган бичнэ. Стратегийн төлөвлөгөө нь үйл ажиллагааны болон тактикийн дараагийн практикийг хөгжүүлэх ерөнхий хүрээг агуулсан хураангуйлсан баримт бичиг юм. Энэ нь үйл ажиллагааны болон тактикийн командлагчдын ажилд гарын авлага болдог. Стратегийн төлөвлөгөө нь төлөвлөлт, бэлтгэлийн үйл явцууд, тайлан дүгнэлт хийхэд ашигласан бүх үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл өгөх баримт бичиг юм.

Зарим тохиолдолд, тухайлбал, аяндаа бий болсон жагсаал, цуглаан, флаш моб зэрэг тохиолдлуудад цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан хийх гэж байгаа талаар урьдчилж мэдээгүй байх, эсвэл мэдээлэл бага байх үе гардаг тул маш богино хугацаанд хариу арга хэмжээ авах шаардлагатай болдог. Ийм нөхцөлд цагдаагийн командлагчид жагсаал, цуглаанд хариу арга хэмжээ авах, хэв журам хамгаалахдаа дөрвөн үндсэн зарчим (2-р бүлэг)-ыг болон шийдвэр гаргах загвар (3-р бүлэг)-ыг ашиглахыг эрмэлзэх хэрэгтэй.

Мэдлэг

Жагсаал, цуглаан болох гэж байгааг цагдаагийн байгууллага анх олж мэдсэн даруйдаа тухайн мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах ёстой. Мэдээлэл нь албан ёсны мэдэгдэл, өргөдөл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ (онлайн нийгмийн сүлжээг оруулаад), эсвэл сурталчилгааны зурагт хуудас гэх мэт олон аргаар гарч болно. Тиймээс цагдаагийн байгууллага үнэхээр жагсаал, цуглаан хийх санаа зорилго байгаа эсэхийг нягтлан шалгах хэрэгтэй. Жагсаал, цуглаан зохион байгуулахад албан ёсоор мэдэгдэх шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллага ихэвчлэн мэдэгдэл өгөх үйл явцаар дамжуулан мэдээлэл авдаг. Үүний дараа стратегийн төлөвлөлтийн үйл явцыг эхлүүлэхийн тулд мэдээллийг стратегийн командлагчид дамжуулдаг.

Албан ёсны мэдэгдэл хийгээгүй тохиолдолд жагсаал, цуглаан зохион байгуулах санаа зорилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ, зурагт хуудас, зар сурталчилгаа, аман яриагаар дамжин мэдэгддэг. Энэ үе шатанд цагдаа тагнуулын мэдээлэл үүсгэхийн тулд эл мэдээллийг шалгах ёстой. Мэдээлэл бол түүхий мэдээлэл, харин тагнуулын мэдээлэл бол шалгаж, тогтоогдсон мэдээлэл юм.

Мэдээллийг хэд хэдэн аргаар үнэлж болно, үүнд нэг мэдээллийн эх сурвалжийг хоёр дахь эх сурвалжтай харьцуулан шалгах, эсвэл өмнөх ижил төстэй үйл явдлуудыг үзэх зэрэг болно. Энэ нь ижил төстэй арга хэмжээг зохион байгуулсан цагдаагийн бусад байгууллагатай хамтран ажиллаж, өмнөх туршлагаас суралцана гэсэн үг юм. Гэхдээ мэдээллийг шалгаж нягтлах гол арга хэрэгсэл нь цагдаагийн байгууллага, жагсаал, цуглаан зохион байгуулагчид, шаардлагатай бол орон нутгийн засаг захиргаа зэрэг бусад оролцогч талуудын хооронд нээлттэй яриа хэлэлцээ хийх явдал юм.

Цагдаагийн байгууллага өмнөх ижил төстэй үйл явдлын түүхийг судлан урьд нь ямар нэг аюул занал, эрсдэл гарсан эсэхийг тогтоох ёстой. Үүнтэй холбогдуулан өмнөх үйл явдлуудын хурлын хураангуй тэмдэглэл, өнгөрсөн хугацаанд сурсан сургамжтай холбоотой дасгал ажлууд онцгой үнэ цэнэтэй байж болно. Мөн зохион байгуулагчидтай нь холбогдож байсан өмнөх мэдээлэл, гол хүмүүсийг нь олж тогтоож, тэдний чадавх, давуу талуудыг тодорхойлж болно. Энэ ажлыг эрт үе шатанд нь судлахыг аль нэг цагдаагийн алба хаагчид даалгах нь стратегийн командлагчид шийдвэр гаргахад хэрэг болдог.

Дэмжлэг үзүүлэх

Цагдаагийн байгууллага бүх жагсаал, цуглааныг жагсаал, цуглаан зохион байгуулагчдын сонгосон цаг, газар, хэлбэрээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ жагсаал, цуглаанд оролцогчид, цагдаагийн алба хаагчид, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Энэхүү эхний шатанд цагдаагийн байгууллага жагсаал, цуглаанд хэдэн хүн оролцох боломжтой, жагсаал, цуглааны зорилго (хөдөлгөөнгүй, эсвэл хөдөлгөөнтэй эсэх), цаг хугацаа, байршил, жагсаал цуглаан нь маргаантай болох магадлалтай эсэхийг тодруулахыг эрмэлзэнэ. Ямарваа яриа хэлэлцээ нь уг жагсаал, цуглааныг яаж аль болох сайн зохицуулж дэмжлэг үзүүлэх боломжтойг судлахыг эрэлхийлэх ёстой. Цагдаагийн байгууллага зохион байгуулагчдыг жагсаал, цуглаан хийхийг нь болиулах гэж оролдох ёсгүй бөгөөд зохион байгуулагчдыг цагдаагийн байгууллагын эрх ашигт нийцүүлэн төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулахыг шаардах ёсгүй.

Зарим тохиолдолд жагсаал, цуглаан нь хүний амь насанд аюултай нөхцөл байдалд хүргэж болзошгүй ноцтой саад тотгорыг үүсгэж болзошгүй. Ийм саад тотгор нь эмнэлэг рүү явах гол зам, галын станцаас гарах гарц зэргийг хаасан байх гэсэн илэрхий нөхцөлүүд байдаг бол, өндөр настан, эмзэг бүлгийн хүмүүст яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй болгох гэх мэт илэрхий бус хэлбэрээр ч байж болно. Тиймээс асуудал өрнөсний дараа хязгаарлалт, хориглох арга хэмжээ авч байснаас цагдаагийн болон зохион байгуулагчдын хооронд эртнээс эдгээр нөхцөл байдлыг шийдвэрлэх яриа хэлэлцээг хийх хэрэгтэй. Хэв журам сахиулах проактив буюу идэвхтэй аргыг хэрэглэх нь үйл явдлын үеэр гарч болзошгүй хүнд нөхцөл байдал үүссэн тохиолдолд итгэж, найдаж болох хүмүүстэй холбоо тогтооход тус болдог.

Харилцаа холбоо

«Гэнэтийн бэлэг байхгүй» бодлого: Цагдаагийн байгууллага жагсаал, цуглааны хэв журам сахиулахдаа «гэнэтийн бэлэг байхгүй» гэх бодлогыг баримтлах ёстой. Энэ нь жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон оролцогчдод цагдаагийн зорилго, боломжит тактикийн талаар ойлгуулах ёстой гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, тэд цагдаа нарын хийж буй үйл ажиллагааны талаар мэдэж байх ёстой бөгөөд цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, хэрэгсэл зэрэгт гэнэтийн хөдөлгөөн, өөрчлөлт хийгдэхэд гайхаж балмагдахад хүрэх ёсгүй. Жагсаал, цуглаан зохион байгуулагчдын зүгээс ч гэсэн тухайн арга хэмжээгээ тохиролцсон төлөвлөгөө, зорилгынхоо

дагуу явуулж байвал цагдаад «гэнэтийн бэлэг» хүлээх зүйл гарах ёсгүй. Үүнийг хийхийн тулд талууд, ялангуяа цагдаа болон жагсаал, цуглаан зохион байгуулагчдын хооронд итгэлцэл байх ёстой. Энэхүү итгэлцлийг бий болгоход тодорхой хугацаа шаардагдах боловч эхлэл нь хоорондоо харилцан ярилцах явдал юм. Зохион байгуулагчид, цагдаа нарын аль аль нь хичээсэн ч гэнэтийн зүйл гарч ирэх магадлал байдаг. Гэхдээ үүсэж болох хамгийн их магадлалтай хувилбар, үр дагаврыг урьдчилан авч үзэж тооцоолсноор ийм гэнэтийн зүйл тохиолдох боломжийг бууруулж болно. Эмх замбараагүй байдал үүсэхэд пачмог реактив байдлаар хандахын оронд идэвхтэй проактив байдлаар хэв журам сахиулахыг хэзээд эрмэлзэх нь зүйтэй.

Жагсаал, цуглаан зохион байгуулах гэж байгаа тухай албан ёсоор мэдэгдээгүй байсан ч жагсаал, цуглаан болох гэж байгаа тухай мэдмэгцээ цагдаагийн байгууллага зохион байгуулагчидтай холбоо тогтоохыг оролдох хэрэгтэй. Харилцаа холбоо бол хоёр талаас харилцан ярилцдаг зүйл бөгөөд яриа хэлэлцээ хийх нь цагдаад төлөвлөсөн жагсаал, цуглаантай холбоотой санаа зовоож буй асуудлуудаа тодруулж, зохион байгуулагчийн хэрэгцээ шаардлага, санаа зовж буй асуудлуудыг ойлгох боломжийг олгоно. Нэг сайн туршлага бол стратегийн командлагч төлөвлөлтийн явцад зохион байгуулагчидтай эртнээс итгэлцлийг бий болгох нэг офицерыг томилон ажиллуулах, мөн шаардлагатай үед зохион байгуулагчид шуурхай ажиллагааны болон тактикийн командлагчтай холбоо тогтоох боломжийг гаргаж өгөх хэрэгтэй. Түүнчлэн жагсаал, цуглаан зохион байгуулагчийг командын багтаа урьж уулзуулах нь зүйтэй байж болох бөгөөд ингэснээр санаа зовоож буй аливаа асуудлаа ярилцаж, ирээдүйд жагсаал, цуглаан хийхэд хоорондын итгэлцлийг бий болгоно.

Арга хэмжээний үеэр цагдаагийн дарга нар зохион байгуулагчидтай холбоо тогтоон ярилцах, болж буй үйл явдлыг газар дээрээс, эсвэл камераар харах замаар мэдээлэл цуглуулна. Жагсаал, цуглааны талаар олон нийтийн мэдээллийн сүлжээ (жишээ нь, твиттер, фэйсбүүк)-гээр дамжуулан хяналт тавьж, харилцах нь цагдаагийн байгууллагад хэрэгтэй нэг арга хэрэгсэл байж болно. Нийгмийн сүлжээг зөвхөн нөхцөл байдлын талаар мэдээлэл авахаас гадна үйл явдлын өрнөл явцын талаар мэдээлэх, буруу ташаа мэдээллийг дахин нягтлах, няцаах зорилгоор ашиглаж болно.

Харилцан яриа: Зарим тохиолдолд зохион байгуулагчид цагдаа нартай ярилцах хүсэлгүй, эсвэл ярилцахад эвгүй санагдаж болно. Заавал ярилцах ч үүрэг байхгүй. Цагдаагийн зүгээс харилцахыг хүссэн хэнтэй ч ярилцахад бэлэн гэдгээ үргэлж онцолж байх ёстой ч, зохион байгуулагчид дургүйцэж

байвал цагдаа энэ байдлыг нь жагсаал, цуглааныг хориглох, хэт хязгаарлах шалтаг болгож болохгүй.

Хэрэв цуглааныг зохион байгуулагчид болон цагдаа нарын хооронд итгэлцэл бага байвал цагдаагийн командлагчид зохион байгуулагчидтай харилцан яриа үүсгэхийн тулд бусад харилцааны арга хэрэгслийг судлахыг эрмэлзэх ёстой. Тиймээс цагдаагийн байгууллага харилцаа холбооны өөр арга замуудыг авч үзэх шаардлага гарч болно, тухайлбал, утсаар, цахим холбоогоор, эсвэл хууль ёсны болон улс төрийн төлөөлөгч, төрийн бус байгууллага гэх мэт «дундын зууч»-аар дамжуулан ярилцаж болно. Энэ нь харилцааны хамгийн тохиромжтой арга биш байж болох ч огт харилцахгүй байснаас дээр.

Зохион байгуулагчидтай харилцах боломжгүй тохиолдолд цагдаа жагсаал, цуглаан болохоос өмнө хэвлэл мэдээллийнхэн, эсвэл олон нийтийн сүлжээгээр дамжуулан цагдаагийн байгууллагын зорилгын талаар тодорхой мэдээлэл цацаж болно. Энэхүү мэдээлэлдээ цагдаагийн байгууллага нийтийн хэв журмыг сахин хамгаалахын зэрэгцээ аливаа тайван жагсаал, цуглааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байгаа гэдгээ тодорхой илэрхийлж, үүнийгээ жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын итгэлийг төрүүлэхүйц байдлаар хүргэх нь зүйтэй. Мөн цагдаагийн командлагчид тайван цуглаан гэж юу болох, жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон оролцогчдын зүгээс үзэн ядалт, хүчирхийллийг өдөөн турхирах нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл гэдгийг онцолж болно.

Оролцогч талууд: Стратегийн командлагч нь жагсаал, цуглааны үйл ажиллагаанд өртөж болзошгүй бусад холбогдох талуудыг эхний үе шатанд тодорхойлж, тэдэнтэй харилцаа тогтоох хэрэгтэй. Бизнесийн болон оршин суугчидтай эртхэн харилцах нь тэдэнд саад бэрхшээлийг багасгахын тулд арга хэмжээ авах боломжийг олгодог, мөн тайван жагсаал, цуглаан хүртэл гуравдагч этгээдийн үйл ажиллагаанд түр зуур саад учруулж, бухимдал, гомдол төрүүлж болзошгүйг оролцогч талуудад ойлгуулах хэрэгтэй.

Мөн зарим нэг олон нийтийн жагсаал, цуглаан болохоос өмнө олон нийтийн хурцадмал байдлыг нэмэгдүүлэх, бууруулахад нөлөөтэй, чухал үүрэг гүйцэтгэдэг улс төрчид, улс төрийн намууд болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудтай цагдаагийн байгууллага яриа хэлэлцээ хийх хэрэгтэй болж болно. Гэхдээ цагдаагийн байгууллага улс төрийн нөлөөллөөс ангид байх, хараат бус гэдгээ хадгалж, харуулах нь бас чухал. Цагдаагийн

байгууллага улс төрийн намуудтай хийх аливаа яриа хэлэлцээ нь улс төрийн хүрээний бүх асуудлыг багтаасан байхыг баталгаажуулах хэрэгтэй.

Хэвлэл мэдээлэл: Цагдаагийн ямар ч байгууллага хэвлэл мэдээллийнхэнтэй мэргэжлийн түвшинд харилцаатай байх нь чухал. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд бие даасан байгууллага бөгөөд цагдааг дэмжсэн байр суурийг илэрхийлэх үүрэг хариуцлага хүлээдэггүй гэдгийг цагдаагийн байгууллага санаж байх ёстой. Гэвч, хэрэв хэвлэл мэдээлэл цагдаагийн байгууллагын хууль ёсны зорилгыг ойлгож байгаа бол тэдний мэдээ мэдээлэл нь үйл явдлыг тайван амгалан зохион байгуулахад тусална. Тохиромжтой тохиолдолд, жагсаал, цуглаан болохоос өмнө хэвлэлийн бага хурал хийж, стратегийн зорилгыг тоймлон гаргах нь тайван жагсаал, цуглааны хэв журмыг хамгаалахад дэмжлэг болно. Үйл ажиллагааны командлагчийг хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах үүрэг гүйцэтгүүлж хэвлэл мэдээлэлтэй холбоотой аливаа стратегийг бодит цаг хугацаанд нь шууд өөрчлөх, батлах боломжтой байлгах нь зүйтэй юм.

Томоохон болон нарийн төвөгтэй арга хэмжээний үеэр хэвлэл мэдээллийн зөвлөхийг томилон ажиллуулж, командлалын багт тухайн үйл явдлын талаарх хэвлэл мэдээллийн ашиг сонирхолд хамаарах цар хүрээний талаар зөвлөгөө өгөх, хэвлэл мэдээллийнхэнтэй холбогдон ажиллах, мөн хэвлэл мэдээлэлд өгөх мэдэгдлүүд дээр зөвлөгөө өгөх зэргээр ажиллуулах хэрэгтэй.

Тиймээс стратегийн командлагч нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн, хэзээ мэдээлэл дамжуулахыг тайлбарласан хэвлэл мэдээллийн стратеги боловсруулж, хэвлэл мэдээлэлтэй харилцах ажилтныг тодорхойлж томилох хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн бүх мэдээлэл бодитой, үнэн байх ёстой. Хэрэв хэвлэлд өгсөн ямар нэг мэдээлэл нь буруу болох нь нотлогдвол цагдаагийн байгууллагын хэлсэн бүх зүйл эргэлзээ төрүүлж магадгүй юм. Хэрэв цагдаагийн ажилтан ямар нэгэн асуултын хариултыг сайн мэдэхгүй байгаа бол буруу хариулт өгөхийн оронд мэдэхгүй байгаагаа хэлэх нь дээр.

Хэвлэл мэдээллийн стратеги нь жагсаал, цуглааны өмнө, дундуур, дараа нь гэсэн гурван хэсэгт хуваагдах бөгөөд дараах зүйлийг хийх боломжтой. Үүнд:

- Нийтийн аюулгүй байдлыг хангахад туслах;
- Олон нийтийг чухал мэдээллээр хангах;
- Цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах;
- Цагдаагийн үйл ажиллагааны талаарх ойлголтыг дэмжих.

Цагдаагийн байгууллага сайн туршлагын үүднээс хэвлэл мэдээлэлд дараах мэдээллийг өгөх нь зүйтэй. Үүнд:

- Холбоо барьж харилцах нэг ажилтан;
- Асуулт асуухыг хүлээхийн оронд тогтмол хугацаанд мэдээлэл өгдөг байх;
- Мэдээлэл өгөх зориулалттай хэвлэл мэдээллийн хэсэг, талбайг гаргах;
- Жагсаал, цуглаан болохоос өмнө жагсаал, цуглаантай холбогдох мэдээллийг өгөх.

Бүх түвшний командлалууд хэвлэл мэдээлэлтэй ажиллах стратегийн талаар мэдээлэлтэй байх нь чухал бөгөөд хэвлэлд ярилцлага өгөх тусгай ажиллагааны командлагч, эсвэл хэвлэлийн төлөөлөгч хэн бэ гэдгийг мэддэг байх ёстой.

Ялгаатай байдал

Цагдаа жагсаал, цуглаанд оролцох магадлалтай хүмүүс болон оролцогчдын хүрээ, олон янз байдлын талаарх мэдээллийг эхний шатанд цуглуулж чадах нь их чухал. Энэ нь тэднийг үр дүнтэй төлөвлөх, зохих нөөц хөрөнгөө хангах, гол бүлэг, байгууллагуудтай эхний шатанд харилцаа холбоо тогтооход чухал ач холбогдолтой.

Эрсдэлийн үнэлгээ

Болзошгүй эрсдэл, аюулыг үнэлэхдээ стратегийн командлагч нь жагсаал, цуглаан эхлэхээс өмнө болон дундуур нь гарч болох янз бүрийн хувилбар сценариудыг үргэлж санаж байх ёстой. Сценариуд нь жагсаал, цуглаанд оролцох боломжтой хүмүүсийн тоо; тэдний улс төрийн хамаарал; жагсаал, цуглааны зорилго, тэр дундаа нэгэн зэрэг болж буй бусад үйл явдалтай холбоотой эсэх (жишээ нь, төрийн тэргүүнүүдийн айлчлал, дээд хэмжээний уулзалт г.м.); эсрэг жагсаал болж байгаа эсэх; ойролцоо өөр үйл ажиллагаа болж байгаа эсэх; жагсаал цуглааны байршил, явган жагсаал бол явах маршрут; болж байгаа цаг, мөн цаг агаарын нөхцөл байдал болон бусад холбогдох хүчин зүйлс зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж болно.

Тагнуулын болон бусад мэдээлэл нь эрсдэлийн удирдлагын чухал зүйл юм. Стратегийн командлагчийн үүрэг бол тагнуулын зохих үйл ажиллагааг өөрийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байлгаж, мэдээллийн байгууллага болон командын багийн хоорондын харилцаа холбоог сайн

тогтоож, шаардлагатай мэдээллийг цуглуулан, шийдвэр гаргах үйл явцад ашиглаж байх явдал юм.

Стратегийн зорилго

Үйл явдалд бэлтгэхдээ стратегийн командлагч стратегийн дөрвөн зарчим болох мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдалд байнга анхаарч, стратеги төлөвлөгөөний стратегийн зорилгоо боловсруулах хэрэгтэй.

Стратеги төлөвлөгөө: Хэлэлцээрийн эхний үе шат явагдаж, болзошгүй эрсдэлийг тодорхойлсны дараа стратегийн командлагч ерөнхий стратегийг стратегийн төлөвлөгөө болгон боловсруулах үүрэгтэй. Стратеги гэдэг нь богино хэмжээний бичгээр үйлдсэн баримт бичиг бөгөөд өрнөж буй үйл явдлаас үүсэж болох аюул занал, эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн өөрчлөлт оруулах боломжтой уян хатан байх ёстой. Хэв журам хамгаалах үүрэг, тухайн үйл явдлыг хэрхэн хамгаалж, хэв журам сахиулах ажиллагааг командлагч хэрхэн явуулах хүсэлтэй байгааг зааж өгөх энэхүү стратегийн зорилго нь маш тодорхой байх ёстой бөгөөд ямар нэг үл ойлголцол гарах ёсгүй. Нөхцөл байдал ямар нэг байдлаар өөрчлөгдөхөд түүнтэй нийцэж буй эсэхийг шалгахын тулд стратегийн төлөвлөгөөг тогтмол эргэн хянаж байх ёстой. Стратегийн зорилгын жишээнд: оролцогчид, цагдаагийн алба хаагчид, олон нийтийн аюулгүй байдлыг хангах; тайван жагсаал, цуглааныг хамгаалах; жагсаал, цуглааны өмнө, дундуур болон дараа нь гарч болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх; хууль зөрчсөн байж болзошгүй этгээдүүдийг баривчлах²¹; бусдын эрх, эрх чөлөөнд халдах аливаа хөндлөнгийн оролцоог багасгах зэрэг бодлого байж болно.

Стратегийн зорилгоо тодорхойлохдоо командлагч дараах зүйлийг анхаарч үзэх нь зүйтэй. Үүнд:

- Жагсаал, цуглааны байршил, цар хүрээ, цаг хугацаа, хэмжээ;
- Ямар төрлийн жагсаал, цуглаан болж байгаа (жишээ нь, марш, жагсаал, парад);
- Жагсаал, цуглаанд оролцогчдын олон янз байдал (жишээ нь, эрэгтэй ба эмэгтэй хүмүүс, насанд хүрэгчид болон хүүхдүүд, бие бялдрын хувьд

21 Олон улс оронд энэ тохиолдолд прокурорын байгууллагатай урьдчилан зөвлөлдөх шаардлагатай байдаг.

энгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоорондын тэнцвэртэй байдал г.м);

- Цагдаагийн байгууллагын гүйцэтгэж буй үүрэг (жишээ нь, тайван жагсаал, цуглааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, эсвэл хүчирхийллийн шинжтэй жагсаал, цуглааныг эсэргүүцэх, барилга байгууламжийг хамгаалах г.м);
- Хэвлэл мэдээллийн анхаарлын түвшин (жишээ нь, энэ нь тухайн жагсаал, цуглаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх боломжтой);
- Хэв журам сахиулах үйл ажиллагааны хүрээ өргөжих бол үүний үр дагавар (жишээ нь, олон нийт, бусад үйл явдалд үзүүлэх нөлөө);
- Жагсаал, цуглаанаас болж хүн ам болон тодорхой цөөнхийн бүлэгт үзүүлж болох нөлөө;
- Ижил төстэй үйл явдлын түүх;
- Аливаа эрсдэлийн үнэлгээний үр дүн.

Хэрвээ хоёр зорилго хоорондоо зөрчилдөх, эсвэл командлагч нэг зорилгыг нь илүү эрсдэлтэй гэж үзвэл стратегийн төлөвлөгөөг боловсруулахдаа үүнийг тайлбарлах хэрэгтэй. Үйл явдал бүр өөр өөр байдаг тул тус тусад нь үнэлж дүгнэх ёстой. Стратегийн зорилгыг уг арга хэмжээг төлөвлөх, зохицуулахад оролцсон офицер бүр сайн ойлгох ёстой. Стратегийн зорилгоо тодорхойлохдоо гарах үр дүнг хүсэж буй сайн үр дүн, хүлээн зөвшөөрч болох зүйлс, хүлээн зөвшөөрөх боломжгүй зүйлс гэсэн байдлаар гаргах нь зүйтэй. Гарах үр дүнг ийнхүү тодорхойлсноор стратегийн командлагч нь гарч болзошгүй аливаа сөрөг буюу хүлээн зөвшөөрч болохгүй үр дагаврыг шийдвэрлэхийн тулд болзошгүй байдлын төлөвлөгөө гаргасан байх ёстой юм.

Зураг 3. Стратегийн зорилгын дагуу гарч болох үр дүнгүүд:

Хүсэж буй үр дүн	Хүлээн зөвшөөрч болох үр дүн	Хүлээн зөвшөөрч болохгүй үр дүн
Үйл явдал ямар нэг осол зөрчилгүй тайван болж өнгөрөх.	Бага зэргийн эмх замбараагүй байдал гарсан ч, түүнийг цааш хүчирхийлэл болгон даамжруулалгүй зохицуулах.	Эмх замбараагүй байдал тархаж, их хэмжээний эд хөрөнгийн хохирол, олон тооны цагдаагийн алба хаагч, энгийн иргэд хохирох.

Стратегийн командлагч нь үйл ажиллагааны командлагчийг эхний үе шатанд нь томилж, тодорхой мэдээлэл өгч танилцуулж болох бөгөөд стратегийн зорилгоо тодорхойлохдоо уг командлагчтай, холбогдох

зөвлөхүүд, жагсаал, цуглааны зохион байгуулагчид болон гол оролцогч талуудтай зөвлөлдөх бас боломжтой.

Хэв журам сахиулах ажиллагааны параметрууд: Стратегийн командлагч нь тодорхой асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар үйл ажиллагааны командлагчдад зааварчилгаа өгнө. Үүнд:

- Жагсаал, цуглаан нь төлөвлөсөн хугацаанаасаа хэтрэн үргэлжлэх бол үүнийг зохицуулна, учир нь энэ нь бусад жагсаал, цуглаан, олон нийтийн арга хэмжээ эсвэл бусдын эрхэд аливаа сөрөг үр нөлөө үзүүлж болзошгүй зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай болдог;
- Төрийн ордон, шашин мөргөлийн газар, түүх дурсгалын байгууламж зэрэг бэлгэдлийн болон стратегийн ач холбогдолтой газрууд;
- Тусгай хамгаалалт шаардлагатай байж болох чухал хүмүүс;
- Янз бүрийн шалтгааны улмаас хэрэглэж болохгүй тактикууд, тухайлбал, CS хий хэрэглэхийг хязгаарлах (нийлмэл 2-хлоробензалмалонитрилийн нэгдэл буюу нулимс асгаруулагч хий гэж нэрлэгддэг);
- Мөрдөн шалгах ажиллагааны параметруудийг тогтоох, мөрдөн шалгах тасгийг зохих нөөцөөр хангаж, тагнуулын үйл ажиллагаатай нягт уялдаатай ажиллаж буй эсэхийг баталгаажуулах;
- Жагсаал, цуглааны үеэр үйлдэгдсэн зөрчилд хариу арга хэмжээ авах.

Стратегийн командлагч мөн стратегийн төлөвлөгөөнд хэв журам хамгаалах үйл ажиллагааны арга барил (жагсаал, цуглаантай харилцах арга барил, өөрөөр хэлбэл сөргөлдөөнгүй, зохицуулж хамгаалах)-ийг тогтоож өгөх ёстой. Хэв журам сахиулж буй цагдаагийн байгууллагын арга барил нь жагсаал, цуглааны доторх үйл явдлын өрнөл, оролцогчид болон цагдаа нарын хоорондох динамик байдалд шууд нөлөөлж, улмаар харилцан ойлголцох яриа хэлэлцээ өрнүүлэх, эсвэл сэжиг төрүүлж, хурцадмал байдлыг нэмэгдүүлэх боломжтой. Ямар нэг хөдөлгөөн хийхийг хязгаарлах, хуяг дуулга бүхий цагдаа нарыг байрлуулах зэргээр сөргөлдсөн хэв маягтай хэв журам сахиулах нь тухайн жагсаал, цуглаан тайван замаар эхэлсэн байсан ч дарамт түгшүүр төрүүлж, хурцадмал байдлыг дэвэргэн, хүчирхийлэлд хүргэж болзошгүй юм.

Нөөц бүрдүүлэх: Стратегийн командлагч нь жагсаал, цуглааныг аюулгүй хамгаалахад шаардлагатай бие бүрэлдэхүүн (тэргүүн шугамын алба хаагчид болон мөрдөн шалгах, тагнуул зэрэг дэмжин туслах чиг үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг оролцуулан) болон тоног төхөөрөмжөөр хангах үүрэгтэй. Боломжит нөөц хөрөнгө, цагдаагийн байгууллагын хүлээх бусад үүрэг хариуцлагаас тавигдаж буй шаардлагууд, алба хаагчдын сургалт, ур

чадвар зэргийг харгалзан үзэх ёстой. Хамгаалалт дээр шаардлагатай үед усан хөөрөг, нулимс асгаруулагч зэрэг хүч хэрэглэх офицеруудыг зохих ёсоор сургаж, тэднийг команд, хяналтаар үр дүнтэй дэмжин ажиллаж, хэзээ ямар хүч хэрэглэх талаар нь тодорхой зааварчилгаа өгөх нь нэн чухал.

Эцэст нь стратегийн командлагч нь үйл ажиллагааны командлагчид стратегийн зорилго болон стратегийн төлөвлөгөөний бусад элементүүдийн талаар танилцуулах үүрэгтэй бөгөөд ингэснээр үйл ажиллагааны командлагч үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулах боломжтой болно. Стратегийн командлагчийн хүлээн авсан шинэ мэдээлэл нь стратегийн зорилгыг өөрчлөх шаардлагатай гэсэн үг бөгөөд энэ тохиолдолд шинэ мэдээллийг бусад бүх алба хаагчид аль болох шуурхай дамжуулах ёстой.

Хяналтын хуудас

Стратеги төлөвлөлтийн үе шатанд Командлалын багийн хүлээх үүрэг хариуцлагууд

Стратегийн командлал нь:

Аливаа жагсаал, цуглааны хамгаалалтад бэлтгэхдээ мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал гэсэн стратегийн дөрвөн зарчим, шийдвэр гаргах загварыг баримтлан ажиллах;

- ✓ Арга хэмжээ, зохион байгуулагчдын талаарх мэдээллийг шалгах;
- ✓ Зохион байгуулагчид болон оролцогч талуудтай нээлттэй яриа хэлэлцээ хийх;
- ✓ Хэвлэл мэдээлэлтэй ажиллах стратеги боловсруулах;
- ✓ Эрсдэл, аюулыг тодорхойлж эхлэх;
- ✓ Үйл ажиллагааны параметрууд болон хэв журам сахиулах арга хэлбэрийг тогтоох;
- ✓ Стратегийн зорилгыг тодорхойлох;
- ✓ Үйл ажиллагааны командлагчийг томилж, мэдээлэл өгөх;
- ✓ Хангалттай нөөцөөр хангах;
- ✓ Стратегийн төлөвлөгөөний төслөө боловсруулах.

6-Р БҮЛЭГ. АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ

Нэгэнт стратеги төлөвлөгөө боловсруулагдаад үйл ажиллагааны командлагчид өгсөн бол тэрээр бэлтгэл ажлын дараагийн шатны ажлыг хариуцах үүрэгтэй. Үйл ажиллагааны командлагч нь цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг хэрхэн тайван амгалан болгохыг зорьж байгаа тухай тайлбарласан үйл ажиллагааны төлөвлөгөөг бичгээр боловсруулна. Стратегийн төлөвлөгөөг боловсруулсантай нэгэн адил үйл ажиллагааны командлагч төлөвлөгөөг боловсруулахдаа мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал зэрэгт үндэслэн бэлтгэх ёстой. Төлөвлөгөөнд цагдаагийн албаны бие даасан нөөц бололцоо, ажилтнуудын чадавх, нөөц зэргийг тодорхойлж, тэдгээрийг цагдаагийн үйл ажиллагааны тодорхой хувилбаруудад хуваарилна. Үйл ажиллагааны хувилбарыг стратеги төлөвлөгөөтэй уялдуулан хэв журам сахиулах зорилтод нийцүүлэн ашиглана.

Зарим нөхцөлд нэгээс илүү үйл ажиллагааны командлагчийг томилох шаардлагатай байж болно. Хэрэв ингэсэн бол үйл ажиллагааны командлал, стратеги болон тактикийн командлал хоорондын үүрэг хариуцлага, хил хязгаарын шугамыг тодорхой болгон авч үзэх хэрэгтэй. Асуудалд хоёр албан тушаалтан оролцох тохиолдолд шийдвэр гаргах үйл явц удаашрах, цагдаагийн аливаа арга хэмжээг хэн нь хариуцах тал дээр төөрөгдөл үүсэх магадлалтай.

- **Үйл ажиллагааны төлөвлөгөөнд** цагдаагийн байгууллага стратегийн зорилгодоо хэрхэн хүрэх, тодруулбал цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг хэрхэн зохицуулах талаар тусгана.
- **Хэв журам сахиулах зорилтууд** нь стратегийн зорилгоос үүдэн гарах бөгөөд үүнд түүхэн дурсгалт онцгой объект, байршлууд болон онцгой чухал хүмүүсийг хамгаалах, нийтийн тээврийн хөдөлгөөнийг саатуулахаас урьдчилан сэргийлэх зэргийг тусгасан байна. Эхний зорилт нь хэзээд жагсаал, цуглааныг зохицуулахад тусалж дэмжих явдал боловч эмх замбараагүй байдал үүсэж, хүчирхийлэл үйлдэгдэхэд цагдаагийн байгууллага авах хариу арга хэмжээгээ хэрхэн тохирсон хэм хэмжээнд байлгах талаар бодолцсон байх ёстой.
- **Үйл ажиллагааны хувилбарууд** нь хэв журам сахиулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд ашиглах арга хэрэгсэл юм. Жишээлбэл, жагсаал, цуглааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилтдоо хүрэхийн тулд үйл ажиллагааны командлагч нь ажиллагааны нэг хувилбар болгож олон нийтийн цагдаа нарыг ашиглаж болно. Өөр нэг хувилбар бол хүчирхийлэл үйлдэгдэж буй жагсаал, цуглаантай тулгарах үед хэв журам сахиулах зорилт нь уг жагсаал, цуглааныг албадан тараах байж

болох бөгөөд бүр илүү ноцтой нөхцөл байдал үүссэн тохиолдолд нулимс асаруулагч хий, эсвэл усан хөөрөг ашиглах хувилбарыг гаргаж болно.

Стратегийн төлөвлөгөөг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж оруулахдаа үйл ажиллагааны командлагч нь шинэ мэдээлэл болон тагнуулын мэдээлэлд тулгуурлан аливаа эрсдэлийг эргэн хянаж, стратегийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Зайлшгүй шаардлагатай өөрчлөлтийг цагдаагийн байгууллага хэв журам сахиулах зорилтуудаа эргэн тодруулах, шинэчлэхээсээ өмнө төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй.

Мэдлэг

Хэв журам сахиулах зорилтуудаас аль нь тухайн нөхцөл байдалд хамгийн сайн тохирч байгааг шийдэхээс өмнө үйл ажиллагааны командлагч сүүлийн үеийн холбогдох мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Стратегийн командлагч ерөнхий мэдээллийг дамжуулах боловч одоо илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болж ирнэ. Үүнд жагсаал, цуглаан болж байгаа газрын нөхцөл байдал, жагсаал, цуглаан болох тодорхой цаг хугацаа, хэзээ тарах, жагсаал цуглаан хийх болсон шалтгаан, олон нийтийн ашиг сонирхол, оролцогчдын тоо, болзошгүй эсэргүүцэл, оролцох хувь хүмүүс, бүлгүүдийн санаа зорилго гэх мэт нарийн мэдээллүүд багтана.

Дараах чиглэлээр мэдээлэл цуглуулна. Үүнд:

- Жагсаал, цуглаан яагаад болж байгаа вэ? Жагсаал, цуглаанаар хэнийг дэмжиж, эсвэл хэнийг эсэргүүцэж байгаа вэ? Цагдаа нарын оролцоо жагсагчдыг болон зүгээр сонирхон харж байгаа хүмүүсийг өдөөн турхирч болох уу? Жагсаал, цуглаанаар дэвшүүлж буй гол санаа нь нийгмийн бусад хэсгээс үзүүлэх хариу үйлдэл (хүчирхийлэл?)-ийг өдөөж болох уу?
- Жагсаал, цуглаанд хэн оролцох вэ? Тэдний өмнөх түүх нь ямар байв? Нас, хүйс, намтар? Ирсэн мэдээллээр ямар санаа зорилготой нь мэдэгдсэн үү? Тухайн орон нутгийн ард иргэдийн талаарх мэдээлэл? Түр зуур оролцох (хажуугаас харж сонирхох) хүмүүс нь хэн байж болох? Тухайн жагсаал, цуглаанд оролцогчдыг эсэргүүцэх жагсагчид, эсвэл дайсагнах хүмүүс байх уу?
- Оролцогчдын санаа зорилго юу вэ (тухайн жагсаал, цуглаанд оролцогчдын болон бүлэг хүмүүсийн санаа зорилго өөр өөр байж болохыг анхаарч үзэх)? Давхар санаа зорилго агуулж байж болох талаар ямар нэг мэдээлэл байна уу? Жагсаал, цуглаанд оролцож буй зарим

бүлгүүд давхар жагсаал, цуглаан зохион байгуулах зорилгыг агуулсан байж болно.

- Жагсаал, цуглаан хаана болох гэж байгаа вэ? Тухайн үйл явдал, зарим оролцогчид, эсэргүүцэн жагсагчдын зүгээс онцгойлон авч үзэх ямар нэгэн чухал байршил, газар байгаа юу? Замын хөдөлгөөнд саад учруулах асуудал байна уу? Товлосон маршрут чиглэл байна уу?
- Жагсаал, цуглаан хэзээ болох вэ? Жагсаал, цуглаан болох он, сар, өдөр, цаг нь хэзээ вэ? Цаг агаарын нөхцөл ямар байх вэ? Зорчих байдал (жагсаал, цуглаан тарах үед нийтийн тээврийн хүрэлцээ хэр байх вэ)?
- Жагсаал, цуглаанд оролцох хүмүүс яаж очих вэ? Мөн жагсаал, цуглаанаас тараад явахдаа яаж явах вэ? Жагсаал, цуглаан болох газраас явах тохиромжтой гарц, нийтийн тээвэр байна уу? Тухайн арга хэмжээ нь бөөнөөрөө цуглараад зогсох уу, эсвэл жагсаалаар алхах байдлаар явагдах уу? Жагсаал, цуглаан дээр үг хэлж ярих хүмүүст зориулсан тайз, чанга яригч байршуулах гэх мэт ямар нэг байгууламж байх уу?

Эдгээр мэдээлэл нь стратегийн командлалын өгсөн мэдээллийг улам баяжуулж, дэлгэрүүлж өгнө. Шинэ мэдээлэл ирэх бүрт үйл ажиллагааны командлагч үүнийг зөвхөн тактикийн командлагчдад дамжуулаад зогсохгүй стратегийн командлалд өгөх ёстой гэдгийг санаж байх ёстой. Ингэснээр стратегийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, нэмэлт нөөцийг хуваарилах боломжтой болно.

Мэдээлэл цуглуулахын нэг ач холбогдол нь жагсаал, цуглаан болох гэж байгаа газрын газарзүйн байршил, онцлогийг сайтар судалж, орчин тойрныг нь ажиглах явдал юм. Ийм мэдээлэл байхгүй бол, зарим чухал хүчин зүйлс, тухайлбал, замын хөдөлгөөний хязгаарлалт, барилгын засвар үйлчилгээ, зам засварын ажил болон бусад саад тотгорыг олж харж чадахгүй, орхигдуулах талтай.

Эрсдэлийн үнэлгээ

Анхны эрсдэл, аюулыг тодорхойлох ажлыг стратегийн командлагч гүйцэтгэнэ. Гэхдээ үйл ажиллагааны төлөвлөлтийн явцад эрсдэлийн үнэлгээг бүрэн хэмжээгээр ашигладаг. Боломжит бүх мэдээллийг авч үзсэний дараа үйл ажиллагааны командлагч нь жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалахад гарч болзошгүй эрсдэл, аюул заналыг тодорхойлно. Учирч болзошгүй эрсдэл гэдэгт жагсаал, цуглааныг тасалдуулж, хүчирхийллийг өдөөх зорилготой хувь хүн, хэсэг бүлэг хүмүүс ирэхийг хэлж болох бол, аюул занал гэдэгт гэмтэл бэртэл, хохирол учруулах аливаа

зүйлийг, тухайлбал, авто замын хөдөлгөөн ихсэх, эсвэл хүмүүс шат гишгүүр, хашлага даван унаж бэртэх зэргийг хэлнэ.

Дээрх эрсдэлийг болон эдгээртэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлсны үндсэн дээр командлагч тухайн жагсаал, цуглааны үеэр гарч болзошгүй хамгийн чухал асуудлуудыг эрэмбэлж, тэдгээр эрсдэлийг бууруулах, арилгахад чиглэсэн хяналтын арга хэмжээг авна. Жишээлбэл, хүмүүсийн гэмтэж, бэртэх эрсдэлийг арилгах, зорчих эрсдэлийг бууруулахын тулд замын хөдөлгөөний урсгалыг хянах, саад хаалтыг байрлуулах, эсвэл хувь хүн, жижиг бүлгүүдийн үйлдэж болзошгүй хүчирхийллээс хамгаалж, дүрэмт хувцастай алба хаагчдыг тодорхой газруудад байрлуулна гэсэн үг юм.

Цугласан олон хүний дунд эмэгтэйчүүд бэлгийн дарамтад өртсөн тухай мэдээлэл нь эмэгтэйчүүдийг эсэргүүцлийн арга хэмжээнд оролцохоос болгоомжлоход хүргээд зогсохгүй жагсагчдын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг. Гэмт этгээдүүд эмх замбараагүй байдлыг ашиглан ийм гэмт хэргийг үйлдээд ял шийтгэлгүй өнгөрөх боломжтой гэж хардаг. Тиймээс цагдаагийн байгууллагын зүгээс бэлгийн хүчирхийлэл нь тэвчиж үл болох гэмт хэрэг бөгөөд заавал ял шийтгэгдэх болно гэдгийг ойлгуулах нь маш чухал. Боломжтой бол, цагдаагийн ажилтнууд эмэгтэйчүүдийн байгууллагууд болон бусад хүмүүстэй урьдчилан уулзаж, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлын талаар ярилцаж, жагсаал, цуглаанд оролцож буй эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах үүднээс эрэгтэй болон эмэгтэй алба хаагчид харж хянаж байх нь зүйтэй юм. Цагдаагийн байгууллага ийм эрсдэлийг нухацтай авч үзэн, анхаарал тавьж буйгаа харуулснаар энэ төрлийн эрсдэл гарах нь төдий чинээ бага байна.

Цагдаагийн байгууллага болон хамгаалалтын албаныхан бэлгийн хүчирхийллийг өдөөсөн тохиолдол байдаг, ялангуяа эцгийн эрхт ёс давамгайлсан нийгэмд гарах хандлагатай байдаг ба энэ нь эмэгтэйчүүд гудамжны жагсаал, цуглаанд оролцох ёсгүй гэж үздэгтэй холбоотой. Хэрэв ийм байдал нэмэгдэх хандлагатай асуудал гэж үзэж байгаа бол үүнийг төлөвлөлтийн үе шатанд авч үзэн, эмэгтэйчүүд тухайн үйл явдлын үеэр болон үйл явдлын дараа бэлгийн хүчирхийлэлд өртвөл хэрхэн мэдээлэх талаар тусгах хэрэгтэй.

Дэмжлэг үзүүлэх

Олж авсан мэдээлэл, эрсдэлийг тооцсоны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр цагдаагийн байгууллага стратегийн зорилгодоо хэрхэн хүрч болохыг харуулна. Үйл ажиллагааны командлагч үйл явдлыг бүхэлд нь харж, тухайн үйл явдлыг аюулгүй явуулахад дэмжлэг үзүүлэхдээ дараах зорилтуудыг хэзээ нь хэрэгжүүлэхээ шийднэ.

Цагдаагийн байгууллагын хувьд хамгийн чухал нь зохион байгуулагчдын хүсэл зорилгод нийцүүлэн тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тал дээр хэрхэн хамгийн сайнаар бодож, төлөвлөх вэ гэдэг явдал юм. Хэдийгээр жагсаал, цуглаанд оролцогчид дотоодын хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй байсан ч тайван жагсаал, цуглааныг дэмжин туслах нь цагдаагийн байгууллагын зорилт байх ёстой. Зохион байгуулагч нь хуулийг дагаж мөрдөхгүй байлаа ч уг жагсаал, цуглаанд оролцож буй хувь хүмүүс энэ тухай мэдэхгүй байж болно. Ямар ч тохиолдолд, хуульд заасан арга хэмжээг тухайн үйл явдал болж өнгөрсний дараа авч болох бөгөөд мэдэгдэл өгөх ёстой гэдэг хуульд заасан шаардлагыг биелүүлээгүйн төлөө тухайн жагсаал, цуглаанд хэзээ ч хүч хэрэглэж болохгүй.

Хязгаарлалт тогтоох: Жагсаал, цуглаан болохоос өмнө холбогдох эрх бүхий байгууллага, эсхүл жагсаал, цуглааны үеэр цагдаагийн байгууллагаас хязгаарлалт тогтоох шийдвэр гаргасан бол дээрх шийдвэрийг дээр дурдсан хүний эрхийн зарчмын дагуу хэлж мэдээлэх ёстой. Цагдаагийн байгууллага нь жагсаал, цуглааныг хязгаарлах санал, эсвэл шаардлага гарсан тохиолдолд энэ талаарх тодорхой үндэслэлийг зайлшгүй хэлж мэдэгдэх ёстой. Хязгаарлалт нь жагсаал, цуглаанд ихээхэн дарамт шахалт учруулж байгаа тохиолдолд зохион байгуулагчдад боломжит хувилбаруудыг санал болгох ёстой. Урьдчилан сануулга өгөхгүйгээр хязгаарлалт хийх гэхээсээ илүүтэй хязгаарлалт тавих ямар боломжууд байгаа талаар зохион байгуулагчидтай хэлэлцэж зөвшилцөх нь зүйтэй. Аюултай зам маршрутаас зайлсхийх, чухал байршлуудад бөглөрөл үүсгэхээс сэргийлэх, эсвэл жагсаал, цуглаан болох цагийг өөрчлөх гэх мэтээр зарим хязгаарлалтыг хялбархнаар шийдэж болно. Гэсэн хэдий ч зарим хязгаарлалтыг хууль ёсны дагуу эсэргүүцэж болох ба энэ нь зохион байгуулагчдад хүндрэл, бэрхшээл авчирч болно. Тиймээс үйл ажиллагааны төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон аливаа хязгаарлалтын талаар зохион байгуулагчдад аль болох хурдан мэдэгдэх нь чухал юм. Цагдаагийн байгууллага хязгаарлалт тогтоохоос өмнө дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- *Зохицуулах, хязгаарлах хууль ёсны үндэслэл:* Хязгаарлалт тогтоох хууль ёсны үндэслэлийг олон улсын хүний эрхийн баримт бичигт заасан байдаг. Эдгээрийг дотоодын хууль тогтоомжид нэмэлт үндэслэлээр нэмж оруулах шаардлагагүй. Гэсэн хэдий ч хууль ёсны үндэслэлийг дотоодын хууль тогтоомж болон холбогдох эрх бүхий байгууллага тухайн орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн тайлбарлаж болно;
- *Нийтийн эзэмшлийн зай талбай:* Жагсаал, цуглаан нь нийтийн эзэмшлийн зай талбайг аливаа арилжааны үйл ажиллагаа, тээврийн хэрэгсэл болон явган хүн зорчих хөдөлгөөнд хууль ёсны дагуу ашиглаж байгаатай адил юм. Энэ ойлголтыг аливаа хязгаарлалт зайлшгүй шаардлагатай гэж үзэхдээ анхаарах нь зүйтэй;
- *Агуулгад суурилсан хязгаарлалт:* Аливаа жагсаал, цуглааныг нийтлэг зорилгоо илэрхийлэх, түүнийгээ хүргэх үүднээс зохион байгуулдаг. Энэхүү хэлэх гэсэн зүйлээ илэрхийлэн бичсэн уриа лоозон, дуу хоолойгоороо илэрхийлсэн агуулга дээр нь хязгаарлалт тавих нь томоохон эсэргүүцэлтэй тулгардаг учраас зөвхөн хүчирхийллийн аюул заналхийлж байгаа тохиолдолд л цагдаагийн байгууллага хязгаарлалт тогтоох ёстой;
- *Нүдэнд харагдаж, чихэнд сонсогдох:* Олон нийтийн жагсаал, цуглааныг тодорхой хувь хүн, бүлэг, байгууллагад хандан хэлэх зүйлээ хүргэх зорилгоор зохион байгуулдаг. Тиймээс баримтлах ёстой ерөнхий дүрэм нь жагсаал, цуглааныг зорилтот хүмүүс рүүгээ чиглэсэн, тэдний «нүдэнд харагдаж, чихэнд сонсогдох» байдлаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ёстой;
- *Жагсаал, цуглаан болох цаг хугацаа, газар болон хязгаарлалтын хэлбэр:* Хэлж хүргэх гэсэн зүйлд нь хөндлөнгөөс оролцохгүйгээр хязгаарлалт тавих өргөн боломж эрх бүхий байгууллагад байдаг. Ийм боломжит хувилбаруудад жагсаал, цуглаан хийх цаг хугацаа, газар байршил, тухайн жагсаал цуглааны явагдах байдал зэрэг байж болно.

Стратегийн командлагч нь стратегийн зорилго, стратегийн төлөвлөгөө, үйл ажиллагааны параметруудийг тодорхойлон, үйл явдал болох үеийн бүх үүрэг хариуцлагыг хүлээн ажиллана. Үйл явдал болохоос өмнө тавигдах аливаа хязгаарлалтыг стратегийн командлагчийн бодож тооцоолж буй зүйл, холбогдох төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ёстой. Үйл явдлын үеэр тавих аливаа хязгаарлалт нь тухайлбал, хүчирхийлэл, хэрэг зөрчлийн улмаас тавигдах аливаа хязгаарлалтыг үйл ажиллагааны командлагчийн шийдвэр (үүнийг гарч болзошгүй нөхцөл байдал гэж командлалын баг урьдчилан тооцоолсон байх ёстой)-ээр хийх ёстой. Иймэрхүү гэнэтийн шийдвэр нь стратегийн ерөнхий төлөвлөгөө болон жагсаал, цуглааныг зохицуулахтай холбоотой нөөц бололцоонд нөлөөлж болзошгүй тул энэ

талаар урьдчилан (хүний амь нас эрсдэлд учраагүй бол) стратегийн командлагчтай ярилцаж, тохиролцох хэрэгтэй. Хэрэв нөхцөл байдал хүндэрч, өөрөөр хэлбэл, хүний амь насанд эрсдэл учирч болзошгүй нөхцөл бий болбол урьдчилан төлөвлөсөн төлөвлөгөөг тухайн нөхцөлд тохируулан өөрчилж болно.

Цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг аль болох зохион байгуулагчдын талд боломж олгож, ямар нэгэн хязгаарлалт тавихгүйгээр зохион байгуулах арга хэмжээ авах, төрийн эрх бүхий байгууллагын хууль ёсны зорилгыг биелүүлэхэд аливаа хязгаарлалтыг хамгийн багаар тогтооно гэсэн чиглэлийг барих ёстой гэдгийг ямагт санах ёстой.

Харилцаа холбоо

Стратегийн командлагчийн санаачилсан яриа хэлэлцээг үйл ажиллагааны командлалын түвшинд өргөжүүлэх ёстой. Цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглаан зохион байгуулагчидтай байнгын харилцаа холбоотой байх ажилтныг тусгайлан томилж, тусалцаа үзүүлж байхыг зорих хэрэгтэй. Энэ нь хүн хоорондын харилцааг хөгжүүлэхэд тус нэмэр болж, харилцан итгэлцлийг бий болгоход тусална. Түүнчлэн төөрөлдсөн, хоорондоо зөрчилдсөн мэдэгдлийг олон нийтэд тараахаас зайлсхийхийн тулд гадны байгууллагуудтай харилцах харилцааг нэг сувгаар болгох ажлыг ханган ажиллах ёстой.

Үйл ажиллагаа эхлэхээс өмнө зохион байгуулагчидтай байнгын холбоотой ажиллах тактикийн командлагчдыг томилж, тэдний үүрэг роль, хүлээх хариуцлагыг тодорхойлсон байна. Эдгээр ажилтнууд аливаа яриа хэлцлийг хөнгөвчлөх, зөвшилцөлд хүрэх, зуучийн үүргийг гүйцэтгэх ур чадвартай байх ёстой. Энэ үе шатанд хэлний болон нутгийн аялганы асуудлыг анхаарч авч үзэх хэрэгтэй бөгөөд ингэснээр орчуулагч нарыг үйл явдлын туршид татан оролцуулах шаардлагатай болно.

Цагдаагийн байгууллага нь харилцаа холбоо бол хоёр талын үйл явц гэдгийг баталгаажуулахыг зорин ажиллах ёстой: цагдаагийн байгууллага нь зөвхөн тайван жагсаал, цуглааныг зохион байгуулахад туслах зорилгоор мэдээлэл цуглуулах биш, бусад чухал оролцогч талуудад тухайн жагсаал, цуглааныг тайван замаар зохион байгуулахад хувь нэмрээ оруулах боломж өгөх үүднээс тэднийг зохих ёсны, хангалттай мэдээ мэдээллээр хангадаг.

Зохион байгуулагчидтай хамтран ажиллах нь тухайн арга хэмжээг зохион байгуулагчдын хүсэл, зорилгыг тодорхойлох, болзошгүй эрсдэл, аюулыг илрүүлэх, улмаар цагдаагийн байгууллага ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлоход тусалдаг гэдгийг цагдаагийн байгууллага үргэлж санаж байх ёстой. Нээлттэй, нүүр тулан ярилцах нь яриа хэлцлийг амжилттай болгох, харилцан хүлээн зөвшөөрсөн үнэлэлт дүгнэлтэд хүрэх боломжийг олгоно.

Дүрэмт хувцас: Тохиромжтой дүрэмт хувцас нь олон нийтэд зөв мэдээлэл хүргэхэд чухал үүрэгтэй. Гэлээ ч цагдаагийн ажилтнууд хүчирхийллийн халдлагаас хамгаалагдах эрхтэй. Зохих дүрэмт хувцсаа зохих цагт нь өмсөх тэнцвэртэй байдал нь болзошгүй аюул занал дээр үндэслэх ёстой бөгөөд хамгаалалтын тоноглол хэрэгслээр хэтэрхий эрт, эсвэл оройтож тоноглох эрсдэл нь хүчирхийлэл гарахад ч хүргэж болно. Хамгаалалтын хэрэглэлийг дүрэмт хувцасны дотор өмсөж болно. Бүх дүрэмт хувцас болон дуулга дээр цагдаагийн алба хаагчийн албаны дугаарыг тэмдэглэсэн байх ёстой бөгөөд энэ нь тухайн албан тушаалтны зүй бус үйлдэл гаргах, түүнчлэн халамж үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн туслалцаа, тушаал өгөх зэрэгт тухайн алба хаагчийг танихад амар хялбар болно.

Ялгаатай байдал

Цагдаагийн байгууллага жагсаал, цуглаанд янз бүрийн хувь хүн, бүлэг хүмүүс оролцож болно гэдгийг бодолцож, тэр ч байтугай зарим нь зохион байгуулагчдаас өөр зорилго, ашиг сонирхолтой байж болохыг санах ёстой. Ярилцах шаардлагатай бүлэг хүмүүсийг хайж байхдаа тухайн үйл явдалд оролцож болзошгүй эмзэг бүлгийн хүмүүсийг тодорхойлоход анхаарах хэрэгтэй. Түүнчлэн жагсаал, цуглааны үеэр янз бүрийн байдлаар өртөж болох, эсвэл өөр өөр хэлбэрээр нөлөөлж болох, мөн яриа хэлэлцээрт оролцож болох хувь хүмүүс, байгууллагууд ч байж болно.

Болзошгүй нөхцөл байдал

Яаралтай тусламжийн албатай урьдчилан холбогдож, нөхцөл байдалд бэлэн байх талаар тохиролцох нь цагдаагийн командлагчид болзошгүй нөхцөл байдалд зориулсан төлөвлөгөөнд анхаарлаа хандуулах боломжийг өгнө. Энэ нь жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулахад гарч болзошгүй томоохон хэрэг зөрчлийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад бэлэн байх нөхцлийг хангана гэсэн үг юм. Томоохон хэрэг зөрчил гэдэг нь нэг

болон түүнээс дээш яаралтай тусламжийн үйлчилгээний албад, тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагуудаас тусгайлан арга хэмжээ авах шаардлагатай гэнэтийн нөхцөл байдал юм. Үүнд:

- Бэртэж гэмтсэн олон хүнийг аврах, зөөвөрлөх;
- Яаралтай тусламжийн томоохон хэмжээний хүч, нөөц шаардагдах аливаа осол эндэгдэл;
- Олон хүн амь насаа алдах, хүнд бэртэх аюулд өртөхөөс сэргийлж, яаралтай тусламжийн болон туслах үйлчилгээг дайчлах, зохион байгуулах;
- Олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ихэвчлэн цагдаагийн байгууллагад хандсан маш их хэмжээний асуулт, лавлагаанд хариу өгөх.

Болзошгүй эрсдэл, аюул гэдэгт дараах зүйлийг авч үзнэ. Үүнд:

- Томоохон хэмжээний мөргөлдөөнөөс үүдсэн гэмтэл, бэртэл;
- Битүү орчинд гал алдах;
- Барилга байгууламж нурах, тухайлбал, түр зассан тайз нурах, үзэгчдэд зориулсан суудал эвдэрч нурах;
- Эмнэлгийн тусламж шаардлагатай маш ноцтой нөхцөл байдал үүсэх зэрэг багтана.

Цагдаагийн командлагчид жагсаал, цуглааныг зохицуулахтай холбоогүй боловч тухайн орон нутгийн нөхцөл байдалд урьдчилан таамаглаагүй өөрчлөлтүүд гарч болзошгүйг тооцоолж байх ёстой. Үүнд:

- Дэд бүтцийн догодол;
- Гэнэт зам хаагдах;
- Цаг агаарын хүнд нөхцөл зэрэг орно.

Үйл ажиллагааны хувилбарууд

Хэв журам хамгаалах зорилтуудыг тодорхойлсны дараа үйл ажиллагааны командлагч эдгээр зорилтод хүрэхэд ямар тактик ашиглахаа шийдэх ёстой. Стратегийн командлагчийн тавьж буй нөөцийн хязгаарлалтын улмаас үйл ажиллагааны тодорхой хувилбарууд өөр өөр байж болно. Үйл ажиллагааны командлагч нь «эмх замбараагүй байдалд цочмог реактив хариу үйлдэл үзүүлж, зохицуулах гэхээсээ илүүтэй эмх замбараатай байдлыг хөхиүлэн дэмжиж ажиллах идэвхтэй проактив арга барил нь хавьгүй дээр» гэсэн үзэл баримтлалын дагуу яриа хэлэлцээ, тайван жагсаал цуглааны менежментийг баримталсан хувилбарыг хэзээд сонгохыг чухалчлах хэрэгтэй. Цагдаагийн байгууллага нь хэв журам хамгаалах янз бүрийн

нөөц боломжтой байсан хэдий ч стратегийн зорилгодоо хүрэхийн тулд аль болох дэмжиж туслах, харилцаа холбоо тогтоох үндсэн зарчмуудыг эрхэмлэн ажиллах ёстой.

Үүнд анхаарах ёстой гол хүчин зүйлс:

- Хувцаслалт (жишээ нь, цагдаагийн алба хаагчид өдөр тутмын дүрэмт хувцас өмсөх, эсвэл үймээн цуглааны үеэр хамгаалах зориулалттай хувцас хэрэгсэлтэй байгаа эсэх);
- Дайчлан байршуулсан цагдаагийн алба хаагчдын тоо;
- Цагдаагийн алба хаагчдыг дайчлан байршуулах арга барил (жишээ нь, цөөн тооны алба хаагчийг явганаар эргүүл хийлгэх, эсвэл олон тооны алба хаагчдыг машин техникээр хуяглан онцгой барилга байгууламжууд дээр харагдах байдлыг хязгаарлан хэсэг хэсгээр нь байршуулах);
- Жагсаал цуглаанд оролцож буй хүмүүст харагдах тоног төхөөрөмж, машин техникийн төрлүүд;
- Тактикийн хувилбар, сонголтыг энгийн байдлаар байршуулах (жишээ нь, албаны ноход, усан хөөрөг, г.м);
- Мэдээлэл өгөх арга хэлбэр (тухайлбал, бүрэн ойлголт авахын тулд мэдээлэл хийхэд мэргэжлийн гэрэл зурагчин, эсвэл видео бичлэг хийх шаардлагатай эсэх);
- Тодорхой тактикийг ашиглахад жагсаал, цуглаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (тухайлбал, нисдэг тэрэг хэтэрхий доогуур нисэх, эсвэл цагдаагийн нохой ашиглах, г.м);
- Нотлох баримт цуглуулах;
- Гэмт хэргийн талаар мэдээлэх, мөрдөн шалгах;
- Баривчилгаа хийх арга стратеги.

Үйл ажиллагааны командлагч нь цагдаагийн алба хаагчдыг байлгаснаар байдлыг улам хурцатгах, эсвэл эсрэгээрээ хүмүүсийг тайвшруулах үйлдэл үзүүлэх боломжтой гэдгийг санаж байх нь зүйтэй бөгөөд цагдаа нар үг хэлээрээ харилцах гэхээсээ илүү аман бус байдлаар буюу үйлдлээр илэрхийлэх нь ач холбогдолтой гэдгийг командлагч санаж байх ёстой. Тухайлбал, олон тооны цагдаагийн алба хаагчийг дуулга, бамбай, усан хөөрөг зэрэг хамгаалалтын хэрэгсэлтэй дайчлан байршуулах нь энгийн дүрэмт хувцастай цагдаа нарыг байрлуулахаас ондоо сэтгэгдэл төрүүлэх болно. Хэрэв цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон оролцогчидтой хамтран ажиллахыг хүсч байгаа бол тухайн жагсаал, цуглааныг тайван зохион байгуулахад тэдэнтэй ярилцан зөвшилцөж, хамтарч ажиллахад бэлэн байгаа гэдгээ илэрхийлэхүйц тооны

цагдаагийн алба хаагчдыг зохих хэмжээний тоног хэрэгсэлтэй нь дайчлан байршуулах хэрэгтэй.

Түүнчлэн үйл ажиллагааны командлагч эмх замбараагүй байдал үүсч болзошгүй хэмээн харж байгаа бол цагдаа нарыг зохих тоогоор, зохих хэмжээний техник хэрэгслээр хангаж, жагсаал болох газрын ойр орчимд тараан байрлуулах нь зүйтэй бөгөөд аль болох жагсаал, цуглаанд оролцогчдод харагдахгүй байх нь зөв юм.

Үйл ажиллагааны командлагч нь олж авсан бүх мэдээлэл, тагнуулын мэдээлэлд үндэслэн дайчлан байрлуулах ажилтнуудынхаа хүйсийн тэнцвэрт байдлыг ч харгалзан үзэх ёстой. Энэ нь янз бүрийн болзошгүй нөхцөл байдал, асуудалд зохих ёсоор хандаж, шийдвэрлэх чадвартай эмэгтэй алба хаагчдын төлөөллийг бүрдүүлсэн байх ёстой.

Дараах хэсэгт хэв журам сахиулах онцгой зорилтууддаа хүрэхийн тулд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх тусгайлсан чиг үүрэг, хамгаалалтын тоног төхөөрөмж, зэвсгийн төрөл зэргийг тоймлон оруулав.

Цагдаагийн чиг үүрэг

Харилцаа холбоо хариуцсан ажилтан/Яриа хэлэлцээ хийх ажилтнууд Эдгээр алба хаагчид нь жагсаал, цуглааны оролцогчид болон тухайн орон нутгийн иргэдтэй шууд харилцах үүрэгтэй бөгөөд харилцаа холбоо болон зөвшилцөл хийхэд тусгайлан бэлтгэгдсэн байна. Үүрэг гүйцэтгэхдээ үйл ажиллагааны командлагчийн шууд удирдлаган дор байна. Цагдаагийн байгууллага болон жагсаал, цуглаан зохион байгуулагчдын хоорондох харилцааг сүүлд нь зохион байгуулагчдын эсрэг ашиглах мэдээлэл олж авах арга хэрэгсэл болгох ёсгүй.

Дээрх ажилтнуудын чиг үүрэг:

- Цагдаагийн байгууллагын зорилгыг олон нийтэд тайлбарлах;
- Олон нийтийн зуучлагч нартай шууд харилцах;
- Хүмүүс хоорондын итгэлцлийг бий болгох;
- Зохион байгуулагчид болон цагдаагийн удирдлага хоорондын харилцааны уялдааг сайжруулах;
- «Гэнэтийн бэлэг байхгүй» гэсэн зарчмыг дэмжиж ажиллах.

Дараах үйл ажиллагааг хийхгүй байхад анхаарах ёстой. Үүнд:

- Эдгээр ажилтныг олон хүний дунд аюултай байрлалд, эсвэл тусгаарлагдсан байрлалд байршуулах;
- Эдгээр ажилтныг үймээн самууныг хянах үүргээр дахин дайчлах.

Унадаг дугуй ашиглах

Унадаг дугуйтай алба хаагчдыг дайчлан байршуулснаар хүмүүсийг хүч хэрэглэхгүйгээр дагалдан явах, хамгаалахад үр дүнтэй болох нь батлагдсан. Эдгээр нь ялангуяа дугуйтай эсэргүүцлийн жагсаалд нэн чухал байдаг. Сайтар сургаж бэлтгэгдсэн тохиолдолд дугуйтай алба хаагчид нь түргэн хугацаанд жагсаал, цуглааны хөдөлгөөнийг удаашруулах, хаалт саад болж чадна.

Анхаарах зүйлс:

- Унадаг дугуй нь хурд сааруулагчтай байх;
- Алба хаагчид нь зохих хэмжээнд бэлтгэгдсэн байх;
- Наад зах нь дугуйтай хоёр албан хаагчаас бүрдсэн багаар ажиллах;
- Түрэмгийллийн шинжтэй болж болзошгүй жагсаал, цуглаан дээр дугуйтай алба хаагчдыг байрлуулах ёсгүй;
- Алба хаагчид нь хэт алсарч тусгаарлагдахаас болгоомжлох хэрэгтэй.

Олон хүнийг зохицуулах үүрэгтэй ажилтнууд

Эдгээр ажилтан нь хамгаалалтын хэрэгсэл бариагүй, жирийн цагдаагийн дүрэмт хувцастай байх ба дайчлан байрлуулсан ажилтнуудтай нэг баг болон хамтран ажиллахаар тусгайлан бэлтгэгдсэн байна. Ийнхүү хамтран ажиллахдаа тайван жагсаал, цуглааны тактикийг барьж ажиллана. (жишээ нь: нээлттэй хамгаалалт, давхар хамгаалалт, жижиг багаар хошуу байрлалд явах, г.м)

Ийм ажилтнуудыг жагсаал, цуглааны үеэр болох үйл ажиллагааг амгалан тайван явуулахад жагсаалд оролцогчдыг татан оролцуулах, тухайн орчинд эргүүл хийх зэргээр ерөнхийдөө жагсаал, цуглаантай холбоотой үйл ажиллагааг дэмжиж өгөх байдлаар ашиглаж болно.

Ийм алба хаагчид нь зөв сургаж бэлтгэгдсэн тохиолдолд олон давуу талтай. Үүнд:

- Жагсаал, цуглаантай хэл амаа амархан ололцон харилцдаг;
- Гүн хямрал цочролд орсон хүмүүст туслах (жишээ нь, осол гэмтэл болох, хүүхэд төөрөх);
- Түрэмгий дүр төрхийг харьцангуй бага харуулна;

- Жагсаал, цуглаанд оролцогчид тэдний хажуугаар тайван явж өнгөрөх ба онцгой асуудал хүндрэлийг шийдэхээр жагсаал, цуглааны дундуур түвэггүй явах боломжтой;
- Жагсаал, цуглаан болсон газар, талбайг хэвийн байдалд нь буцаан оруулахад тусална.

Мөн сул талууд ч байдаг. Үүнд:

- Тэд хамгаалалтын хувцас өмсөөгүй учир сум, хувь хүний халдлагад өртөх магадлал ихтэй;
- Үр дүнтэй ажиллахын тулд өөрсдийн алба нэгжийн эрх бүхий командлагчийн удирдлага дор хамтдаа байх ёстой.

Үймээн самууныг хянах алба хаагчид болон тасаг нэгж

Эдгээр алба хаагчид нь дуулга малгай, бамбай, хуяг, бороохой зэрэг хамгаалалтын хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд олон нийтийн ноцтой үймээн самууныг арилгахад тусгайлан бэлтгэгдсэн байна. Тэд жагсаал цуглааны үед аль болох олон нийтэд харагдахгүй, хол байж байх ба нөхцөл байдал хүндэрч, эсрэг жагсагчид болон бусад бүлгүүдийн зүгээс хүчирхийллийн ноцтой байдал үүсгэх нөхцөлд сая гарч ирнэ.

Үймээн самуун гарсан үед ажиллах алба хаагчдын давуу тал нь :

- Бууны сум болон хувь хүмүүсийн халдлагаас сайн хамгаалагдсан байдаг;
- Үймээн самууныг удирдан хянах чиглэлээр өндөр түвшний тусгай ур чадвар эзэмшсэн, тусгайлан бэлтгэгдсэн, сайн тоноглогдсон, хувийн сахилга баттай;
- Хурдан хөдөлж, жагсаал, цуглааны үеэрх эмх замбараагүй байдлыг зохицуулж чадна;
- Хэв журам хамгаалах нэгдсэн орчин нөхцөлд бие даан хүч хэрэглэх, гүйцэтгэх чадвартай.

Ийм тасаг нэгжийг дайчлан байршуулах сул тал нь:

- Тэдний дангаар нь байршуулбал оролцогчдод ихэнхдээ сөрөг мессежийг өгдөг;
- Хэт түрэмгий ааш авир гаргах магадлалтай;
- Хамгаалалтын дуулга малгай өмссөн үед бусад цагдаагийн алба хаагчид болон олон нийттэй харилцахад сайн ойлголцохгүй байдал гарч болзошгүй;
- Тэднийг дайчлах хүртэл нөхцөл байдал хэвийн байдалдаа орохгүй байж болно. Гэхдээ нөхцөл байдал хэвийн хэмжээнд буцаж ороход

дуулгаа тайлах, бамбайг буулгах зэрэг үйлдлүүд нь хурцадмал байдлыг бууруулахад туслах аман бус харилцааны нэг хэлбэр байж болно;

- Бүрэн хэмжээний хамгаалалтын хэрэгсэл бүхий хувцас өмссөн үед, ялангуяа халуун цаг ууртай нөхцөлд маш хурдан хугацаанд шингэний дутагдалд орох боломжтой тул алба хаагчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх эрсдэлтэй.

Баривчилгааны баг

Эмх замбараагүй байдал үүсэх, эсвэл үүсэж болзошгүй нөхцөлд баривчилгааны багийг ашиглах нь жагсаал, цуглааны үеэр эргэн тойрондоо байгаа хүмүүсийг хүчирхийлэл рүү турхирах үйлдлийг гаргаж болзошгүй хэн нэгнийг саатуулж, жагсаалаас гаргах арга зам юм.

Баривчилгааны багийг ажиллуулахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Баривчилгааны багийн гишүүд нь тусгайлан бэлтгэгдсэн, сайтар тоноглогдсон, хувийн сахилга бат өндөр байх ёстой;
- Тодорхой хүмүүстэй тулж харьцахын тулд үнэн зөв, найдвартай мэдээлэлд үндэслэсэн байх ёстой;
- Баривчлах ажиллагааг тэр даруйд нь хийх үү, эсвэл үйл явдлын дараа гүйцэтгэх үү гэдгээ шийдэх (CCTV, эсвэл нотлох баримт цуглуулах багийн нотлох баримтыг ашиглах боломжтой);
- Баривчлагдсан хүмүүстэй хурдан шуурхай ажиллахын тулд хамгийн түрүүнд очих ажилтнуудын тоог тодорхойлох;
- Баривчилгааны багийн гишүүдийн үйлдэл нь эв нэгдэлтэй байхыг сэдэлжүүлж болох ч эсэргээрээ оролцогчдын дунд цагдаа нарт дургүйцэх, дайсагнасан хандлагыг ч бий болгож болзошгүй.

Нотлох баримт цуглуулах баг

Жагсаал, цуглаан дээр суурин камер, эсвэл видео камер байрлуулах нь гэмт хэрэг зөрчлийн нотлох баримтыг цуглуулахаас гадна болзошгүй гэмт хэрэгтэн, зөрчил гаргагчдыг хууль зөрчихөөс сэргийлэх сэтгэл зүйн нэг арга хэрэгсэл болдог. Гэмт этгээдүүд жагсаал, цуглааныг далимдуулан хулгай, бэлгийн хүчирхийлэл зэрэг гэмт үйлдэл хийх боломжийг эрж хайж болно.

Ингэж нотлох баримт цуглуулах зорилгын талаар зохион байгуулагчид болон оролцогчдод тодорхой мэдэгдсэн байх ёстой.

Гэхдээ ажиглалт, тандалт хийх далд төхөөрөмж ашиглахаар бол ийм үйл ажиллагааг явуулахтай холбоотой хүний эрхийн заалтуудыг судалж үзсний дараа хэрэгжүүлэх ба шаардлагатай тохиолдолд шүүхийн байгууллагаас зөвшөөрөл авсан байх ёстой. Тиймээс нотлох баримт

цуглуулах багийг зөвхөн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах баримтыг цуглуулахад ашиглах ёстой бөгөөд дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Багийн гишүүд үргэлж цагдаагийн дүрэмт хувцастай байна;
- Нотлох баримтыг олон нийтийн нүдэн дээр ил цуглуулна;
- Зохих ёсоор бэлтгэгдсэн, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
- Зохих удирдлага дор байх (жишээ нь, чиг үүрэг хариуцсан командлагчийн шууд удирдлаган дор үүргээ гүйцэтгэх);
- Хууль тогтоомжид тавигдах шаардлагын дагуу ажиллах;
- Зарим тохиолдолд камерыг хүмүүс рүү хэтэрхий ойртуулж чиглүүлэх нь өдөөн хатгаж буй сэтгэгдэл төрүүлж, үймээн самуун дэгдээхэд хүргэж болзошгүйг анхаарах;
- Гэрэл зураг болон видеог зөвшөөрөлгүй хүмүүс ашиглаж болохооргүй найдвартай байдлаар хадгалах;
- Нотлох баримтыг шүүхэд зохих ёсоор танилцуулах чадвартай байх;
- Байнга дүрс бичлэг хийх биш, байдал хурцадмал болж эхлэх, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах аюул илэрмэгц дүрс бичлэг хийх;
- Видео хальс болон фото зургийг удаан хугацаанд биш, зөвхөн хууль сахиулах болон шүүх ажиллагаанд ашиглах зориулалтаар хадгалах.

Жагсаал, цуглааны үед байсан цагдаагийн бүх алба хаагчид ажиллагааны явцад явуулсан ажиглалтынхаа талаар бүрэн хэмжээний бүртгэл, тайланг бичгээр өгөх ба гэмт хэргийн эсрэг шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөхөд бэлэн байх ёстой.

Энгийн хувцастай алба хаагчид

Жагсаал, цуглааны үед энгийн хувцастай алба хаагчид (тандах үйл ажиллагаа эсвэл баривчлалааны багийн нэг хэсэг болгон)-ыг ажиллуулахад анхаарал болгоомжтой удирдах шаардлагатай. Нэгдүгээрт, нууц ажилтныг авч ажиллуулах нь хувийн болон гэр бүлийн амьдралд орох эрхтэй болох²² (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17-р зүйл)

22 Нэгдсэн Вант Улсын Цагдаагийн нууц ажилтан Марк Кеннедигийн илрүүлсэн хэрэг дээр цагдаа нар тэмцэгчидтэй удаан хугацааны, дотно харилцаа үүсгэж, хүүхэдтэй болж, тэдний гэр бүлийн нэгээхэн хэсэг болсон байсан нь илэрсэн. Бусад хэргүүдийн тухайд нас барсан хүүхдүүдийн хувийн мэдээллийг хууль сахиулах ажилтнуудыг халхавчлахад ашигласан байсан нь тогтоогджээ. Пол Ливайс, Роб Иванс-ийн «НҮБ-ын ажилтан Их Британийн засгийн газрыг цагдаа нарын дуулиант хэргийг шалгаж илрүүлэхийг уриаллаа» нийтлэлийг дараах холбоосоор үзнэ үү. Гарден вебсайт, 2013 оны 1-р сарын 23, <[http:// www.theguardian.com/uk/2013/jan/23/un-official-undercover-police-scandal](http://www.theguardian.com/uk/2013/jan/23/un-official-undercover-police-scandal)>.

учраас нууц ажилтны үйлдэл нь тохирсон хэм хэмжээнд байх зарчимтай нийцсэн эсэх, мөн зайлшгүй шаардлагатай эсэхийг шалгах хэрэгтэй.²³

Командлагч нар дараах зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдал, жагсаал цуглааны үеэр хийж буй үйлдлээ зөв ойлгуулж, зөвшилцөх чадвар;
- Ажиллагааны үеэр цагдаагийн тоног хэрэгслийн аливаа эд зүйл алдагдах, хулгайлагдахад гарах үр дагавар (тухайлбал, галт зэвсэг болон радио станц, г.м);
- Цагдаагийн алба хаагчид жагсаал, цуглааны үеэр хэзээ ч *сэжигтэнтэй хамсаатан болж* өдөөн хатгах, хууль бус зан авир гаргаж болохгүй.

Морьтой цагдаагийн алба хаагчид

Морьтой цагдаагийн алба хаагчдыг ЕАБХАБ-ын зарим улс орнуудад томоохон хэмжээний болон хурцадмал байдал үүсч болзошгүй жагсаал, цуглааныг дагалдан явах, зохицуулахад ашигладаг бөгөөд заримдаа явган алба хаагчдаас илүү үр дүнтэй байх талтай. Гэхдээ морь ашиглах нь цагдаагийн үйл ажиллагааны нийтлэг сонголт биш бөгөөд оролцогчдод заналхийлэл мэт харагдаж болно.

Морьтой цагдаагийн алба хаагчдыг ашиглахад анхаарах зүйлс:

- Морьтой алба хаагчид жагсаал, цуглааныг болон оролцогчдыг харж ажиглах боломж сайтай байж, оролцогчдын тоо, жагсаал цуглааны төлөв байдал, асуудлуудыг урьдчилан харах зэргээр мэдээлэл цуглуулж чадна;
- Морьтой алба хаагчид нь хүмүүст харагдах байдал, харилцах боломж зэргээсээ хамаараад жагсаал, цуглаанд оролцогчидтой харилцах сайн нөөц хүч байж болох юм;
- Зарим нөхцөлд морь нь явган хүмүүсийг санамсаргүйгээр гэмтээж болзошгүй тул жагсаал, цуглаанд тэднийг ашиглах талаар үйл ажиллагааны командлалын зөвшөөрөлтэйгээр хийгдэх ёстой;
- Цагдаагийн алба хаагчид морийг хэзээ ч зэвсэг, хүч хэрэглэх хэрэгсэл гэж үзэх ёсгүй;
- Жагсаал, цуглаанд морьтой алба хаагчдыг оруулахаас өмнө сануулга анхааруулга өгөх хэрэгтэй;

23 НҮБ-ын тусгай илтгэгч Нэгдсэн Вант Улсад очсноо дүгнэж, Тайван жагсаал цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эрхийн асуудлаарх мэдэгдэл гаргав. Дараах холбоосоор орж үзнэ үү. <<http://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=12945&LangID=E#sthash.gUJ3z9To.dpuf>>.

- Морь ашиглах олон янзын шаардлага байдаг тул багийг ахалж буй ахлах ажилтнаас байнгын зөвлөгөө авч байх хэрэгтэй;
- Моринд ойр орчимд байх хашаа хороо, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх шаардлага гарах бөгөөд хүн шиг ажиллуулах боломжгүй;
- Хувийн хамгаалалтын хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон морьт ажилтнууд явган цагдаагийн ажилтнуудын нэгэн адил шингэний дутагдалд ордог;
- Хүмүүсийг дээрээс нь сайн харах боломжтой байдаг тул морьтой алба хаагчдыг нотлох баримт цуглуулахад ашиглаж болно. Энэ тохиолдолд тэднийг дүрс бичлэгийн камертай дуулгаар тоноглох ёстой байдаг;

Цагдаагийн нохой

Нохойг цагдаагийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд янз бүрийн хэлбэрээр ашигладаг бөгөөд ганцаар нь, эсвэл том багийн нэг хэсэг болгон ажиллуулдаг. Гэлээ ч нохой нь айж сүрдмээр, өдөөн хатгаж буй мэт харагдаж магадгүй тул тэдгээрийг жагсаал, цуглааны үед байнга ашигладаггүй бөгөөд зөвхөн онцгой нөхцөлд байдалд ашиглаж болдог. Томоохон хэмжээний жагсаал, цуглаанд нохойг ашиглах тохиромжгүй.

Цагдаагийн нохойг ашиглахад дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Нохойг үймээн самуунтай тэмцэх, саатуулах, тараах зорилгоор ашиглаж болохгүй;
- Нохой болон нохой сургагчийг өндөр түвшинд сургаж, бэлтгэсэн байх ёстой;
- Нохой сургагчдыг явганаар үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагчид үргэлж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй;
- Нохойтой алба хаагчдыг жагсаал, цуглаан руу оруулахаас өмнө урьдчилан сануулж, анхааруулах ёстой;
- Нохой хууль зөрчиж байгаа болон хууль зөрчөөгүй хүмүүсийг ялгахгүй;
- Нохойг ашиглах нь өдөөн хатгасан, айж сүрдмээр, дайрч довтолж буй мэт ойлгогдож болох учраас нохой оруулах нь нөхцөл байдлыг улам дэвэргэж болох талтай;
- Нохойг тээвэрлэх тохиромжтой тээврийн хэрэгсэл болон мал эмнэлгийн үйлчилгээ шаарддаг тул нохойг дайчлан оруулахын өмнө сайтар зөвлөгөө авах хэрэгтэй;
- Нохойг хэв журам сахиулахад ашиглах нь нохой ашиглаж ирсэн түүхэн ойлголттой холбоотойгоор зарим итгэл үнэмшил бүхий иргэдийн хувьд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Нөөц ба тусгай хэрэгсэл

Хаалт саад

Жагсаал, цуглааныг тайван зохион байгуулах зохицуулалтыг хийхдээ «нүдэнд харагдаж, чихэнд сонсогдож байх ёстой» гэх зарчмыг баримтлан янз бүрийн төрлийн хаалт саадыг ашиглаж болно. Хүчирхийллийн шинжтэй жагсаал, цуглааны хөдөлгөөнийг хязгаарлах, зарим тохиолдолд эсэргүүцэгч бүлгүүдийн үйлдлийг саармагжуулах зорилгоор хаалт саадыг хийж, зориулж, мөн тохируулан ашиглаж болдог. Үүнд:

- Хийсэн хаалт саад гэдэгт байгалийн хана, барилга байгууламж, бут сөөг, навчис зэргийг ашиглаж болох ба сууц хорооллыг тусгаарлан барьсан тусгаарлагч хана орж болно. Зарим барилга байгууламж тухайлбал, элчин сайдын яамдын барилга байшинд зориудын хаалт ханыг барьсан байдаг;
- Зориулж хийсэн хаалт саад гэдэгт цугласан бөөн хүнийг хянах хаалт саад (заримдаа франц хашлага гэж нэрлэдэг), мөн можо саад (концерт болон тайзтай арга хэмжээнд хэрэглэдэг), хикан саад (олон хүний хөдөлгөөнийг сааруулахад ашигладаг), херас хашлага (олон төрөл байдаг) болон тууз зэргийг хаалт саад болгон ашиглана;
- Тохируулан хийсэн хаалт саад гэдэгт тээврийн хэрэгсэл, цагдаагийн алба хаагчид, унадаг дугуйтай алба хаагчдаас бүрдсэн тасаг нэгж, морьт тасаг болон тээврийн чингэлэг зэрэг орно.

Хаалт саадыг хэрэглэхэд дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Хаалт саадыг жагсаал, цуглаан эхлэхээс өмнө байрлуулсан байна;
- Биет хаалт саадыг жагсаал, цуглаанд хязгаарлалт болдог тул цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг хамгаалахын тулд «гэнэтийн бэлэг байхгүй» гэх аргаар хаалт саад ашиглахаар төлөвлөж байгаа бол зохион байгуулагчдад урьдчилан мэдэгдэх ёстой;
- Хаалт саад нь цагдаагийн алба хаагчдад төдийгүй жагсагчдын хөдөлгөөнд хаалт саад байдлаар ашиглагддаг;
- Цагдаа хаалт саад руу орох, гарах тохиромжтой гарц байгаа эсэхийг сайтар шалгах ёстой;
- Цагдаагийн алба хаагчдыг хаалт саад болгон ашиглахад харилцан яриа хөөрөө хийх боломжийг олгодог ч зарим тохиолдолд огцом ширүүн авир, үйлдэл хийхэд өдөөж болно;
- Биет хаалт саад босгох нь яриа хэлэлцээг хязгаарлаж болох ч цагдаа болон жагсаал, цуглаанд оролцогчдын үзүүлэх хариу үйлдэл байх ёстой хэмжээнээс хэтэрч, бие биендээ хүрэхээс сэргийлж чадна;
- Ашиглаж байгаа хаалт саадны төрөл нь гарч болзошгүй эрсдэлийг тооцсон байх шаардлагатай. Жишээ нь, жагсаал, цуглааны үеэр олныг

хянах саад хаалтыг уурласан жагсагчид зэвсэг болгон амархан хувиргаж болно;

- Биет хаалт саадыг амархан зөөж хөдөлгөж чадахгүй тул хурдан хугацаанд байрлуулахад төвөгтэй байдаг;
- Ихэнх хаалт саад хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлаж, тогтворгүй нөхцөл байдалд орсон хүмүүс хавчигдаж, дарагдах аюултай.

Утаан хөшиг

Утаан хөшгийг ашиглах нь цагдаагийн алба хаагчдыг дахин байрлалаа эзлэх, бусад жагсагчдын хараанаас эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалан зайлуулах боломжийг өгнө.

Утаан хөшиг ашиглахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- Утаан хөшгийг зөвхөн цагдаагийн байгууллагын ашиглаж буй хүчний эсрэг хүчирхийлэл үйлдэж байгаа тохиолдолд ашиглана (галт зэвсэг, галдан шатаах болон тэсрэх төхөөрөмж);
- Утаан хөшгийг зөвхөн үйл ажиллагааны командлалын зөвшөөрөлтэйгээр ашиглана;
- Хүчтэй салхины улмаас утааны чиглэл өөрчлөгдөж, үр дүнгүй болох магадлал бий;
- Утаа нь цагдаа нарыг жагсаал, цуглаанаас, мөн жагсаал, цуглааныг цагдаа нараас халхалж болно;
- Утаан хөшгийг жагсаал, цуглаанд оролцогчид нулимс асгаруулагч хий гэж андуурч, дайсагнасан хариу үйлдэл гаргах, эсвэл сандралд орж болзошгүй;
- Сандралд орсон үед зугтаж гарах гарцыг байлгахад анхаарах хэрэгтэй;
- Утааг цагдаагийн алба хаагчдын эргэлзээтэй үйлдлийг халхлахад ашигласан гэж буруутгаж болно;
- Яаралтай тохиолдлоос бусад тохиолдолд утааг хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулга өгөх ёстой;
- Утааны канистерийг хэзээ ч хүн рүү чиглүүлж болохгүй;
- Утаа нь цагдаагийн байгууллагын арга хэмжээнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Цагдаагийн машин ашиглах

Цагдаагийн машин, тээврийн хэрэгслийг тактик болгон ашиглахаар бол маш нарийн тодорхойлох хэрэгтэй. Жагсаал, цуглааны үеэр тээврийн хэрэгслийг хурдтай жолоодон оруулахыг зөвшөөрөх ямар ч нөхцөл байх ёсгүй. Ийм үйлдэл нь үхэлд ч хүргэж болзошгүй бөгөөд хүний эрхийн үүднээс зөвтгөх ч боломжгүй юм.

Цагдаагийн машиныг ашиглахад дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Машиныг хөдөлгөөнт хаалт болгон ашиглаж болно;
- Машиныг жагсаал, цуглаанд оролцогчидтой харилцах нийтийн индэр болгон ашиглаж болно;
- Машиныг гэрэлтүүлэг болгон ашиглаж болно;
- Машиныг олон тооны цагдаагийн алба хаагчдыг тээвэрлэх, мөн баривчлагдсан хүмүүс болон тоног хэрэгслийг зөөвөрлөхөд ашиглаж болно;
- Машиныг сумнаас хамгаалах зорилгоор ашиглаж болно;
- Машиныг хууль бус үйлдлийг мохоох бат бэх байдлыг харуулах байдлаар ашиглаж болно;
- Жолооч нь зохих сургалтад хамрагдсан, жолоодох эрхийн зохих үнэмлэхтэй байх ёстой;
- Машины дуут дохио болон гэрлийг ашиглах нь жагсаал, цуглаанд оролцогчдын зан төлөвт нөлөөлж болзошгүй.

Хиймэл гэрэлтүүлэг

Гэрэлтүүлгийг хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах аюулыг багасгах, хүмүүсийн танигдахгүй байхыг хичээх явдлыг гаргуулахгүйн тулд тухайн газрыг гэрэлтүүлэх байдлаар ашиглана. Гэрэлтүүлгийг мэдээлэл болон нотлох баримт цуглуулахад ашиглаж болно. Хэрэв жагсаал, цуглааныг байгалийн гэрэл муутай газар зохион байгуулахаар төлөвлөж байгаа бол төлөвлөлтийн шатанд хиймэл гэрэлтүүлэг ашиглах талаар авч үзэж болно.

Хиймэл гэрэлтүүлгийг ашиглахад анхаарах зүйлс:

- Нисэх онгоцноос байрлуулан гэрэлтүүлж болно (шөнийн нар);
- Тээврийн хэрэгсэл дээр байрлуулан гэрэлтүүлж болно;
- Газарт суурилуулан гэрэлтүүлж болно;
- Гартаа барин гэрэлтүүлж болно;
- Зарим гэрэлтүүлэгт тусдаа эрчим хүчний эх үүсвэр шаардлагатай байж болно.

Агаарын дэмжлэг

Боломжтой бол, агаарын дэмжлэг үзүүлэх нь ямар ч командлалын багт тухайн газар нутгийн байр байдалтай танилцах, нотлох баримт, мэдээлэл цуглуулахад томоохон ач холбогдолтой байдаг. Агаарын дэмжлэгийн олон төрөл байдаг ба үүнд дараахыг багтаана:

- Нисдэг тэрэг;
- Нисэх онгоц;
- Агаарын хөлөг;
- Агаарын бөмбөлөг;

- Алсын удирдлагатай дрон.
- Агаарын дэмжлэгийг ашиглахад анхаарах зүйлс:
- Үнэ өртөг;
- Боломжит байдал;
- Шатахуун түлш, нислэгийн цаг;
- Агаарын дэмжлэг нь хүн хүч, нөөцийг дайчлан байршуулахад ихээхэн үр дүнтэй;
- Толгой дээгүүр буюу агаараас тандалт хийх нь өдөөн хатгалга гэж ойлгогдож, газар дээр хурцадмал байдлыг дэврээх магадлалтай;
- Нисгэгчдийн эсрэг лазер гэрлийг хэрэглэж болно;
- Нисэх онгоцны их дуу чимээ нь харилцаа холбоонд саад болдог талтай;
- Буух, хөөрөхөд саадгүй байх шаардлагатай.

Зэвсэг хэрэгсэл

Цагдаагийн байгууллага ямарваа хэлбэрийн зэвсэг хэрэгсэл дайчлан гаргахаасаа өмнө тухайн онцгой нөхцөлд хүч хэрэглэх шаардлагатай эсэх, мөн аливаа хүч хэрэглэхээр эрх олгогдсон бол тэр нь хэзээд тохирсон хэм хэмжээнд байх, өөрөөр хэлбэл ашигласан хүчний хэлбэр, түвшин нь хүссэн зорилгодоо хүрэхэд шаардагдах хамгийн эцсийн арга хэмжээ байж, түүнээс гарах сөрөг үр дагавар нь хууль ёсны зорилгоос давж гараагүй байх ёстойг анхаарч үзэх хэрэгтэй. Энэ нь шаардлагатай хэмжээний хүч хэрэглэхээр төлөвлөж буй хүмүүст хэт их хохирол учруулахаар байвал хүч хэрэглэхгүй байх ёстой бөгөөд хажуунаас харж ажиглаж буй хүмүүст болон тайван замаар оролцож буй хүмүүст хор хохирол учруулахгүй байхад анхаарах хэрэгтэй.

Хүч хэрэглэх нь үхэлд хүргэж болзошгүйг санах нь чухал бөгөөд аливаа байдлаар зэвсэг хэрэглэх нь ялангуяа хүүхэд залуучууд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад эмзэг бүлгийн хүмүүст онцгой хор хөнөөл учруулж болзошгүйг санах нь чухал юм.

Ямарваа байдлаар зэвсэг хэрэглэх, хэрэглэхийг зөвшөөрч эрх олгосон шатлал, анхааруулга зэргийг тухайн үйл явдал дууссаны дараа шат дараалсан хяналт шалгалт явуулахын тулд бүрэн баримтжуулсан байх ёстой.

Бамбайтай хамгаалалт

Дайчилгаанд хамгаалалтын дуулга өмсөж, бамбай барин зогсож буй цагдаагийн алба хаагчид нь хамгаалалтын саад үүсгэж, хүчирхийлэл

үйлдэгдэхээс сэргийлж зогсоож, нэг ёсны бат бэх байдлыг үзүүлж байдаг. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд ийм хамгаалалтыг хийх нь харин ч хүчирхийлэл үйлдэхэд турхирч, эмх замбараагүй байдлыг өдөөх эсрэг үр дагаварт хүргэж болох талтай. Бамбай ашиглах нь ихэвчлэн хамгаалалтын нэг хэрэгсэл бөгөөд харвасан сум цагдаа нарыг онохоос сэргийлдэг. Бамбайг бороохойтой хамт (доор бичснийг үзнэ үү) дайралт довтолгооны үед ашиглаж болохоос гадна бамбайг нүүрээ халхалж бариад хүмүүсийг түлхэхэд ашиглаж болно. Бамбайны ирмэгийг дайралтад хэрэглэхээс болгоомжлох хэрэгтэй, учир нь ноцтой гэмтэл учруулж болох ба ялангуяа толгой, хүзүүний хэсэгт цохивол үхэлд ч хүргэж болзошгүй.

Бамбайтай хамгаалалтыг ашиглахад анхаарах зүйлс:

- Цагдаагийн бүх алба хаагч зохих хамгаалалтын хэрэгслээр хангагдсан байх;
- Бамбай ашиглахын тулд тусгай сургуулилт, биеийн хүчний бэлтгэл, алба хаагчид зэргийг тусгайлан сонгох шаардлагатай;
- Хатуу тушаал, хяналттай байх ёстой ба хэт цочмог хариу үйлдэл үзүүлж буй алба хаагчдыг зогсоох нэгдүгээр шатны ахлагч нар бэлэн байх ёстой;
- Цагдаагийн алба хаагчдыг ийнхүү байршуулах нь цагдаагийн байгууллагад яриа хэлэлцээр хийх, харилцах боломжийг хязгаарлана;
- Бамбайтай хамгаалалт хийх шаардлагагүй болсон үед алба хаагчдыг эргүүлэн татах хэрэгтэй;
- Дайралт, довтолгооны үед гэмт этгээдүүд бамбайг жолооны хүрд шиг эргүүлж, улмаар цагдаагийн албан хаагчдыг хүнд бэртээж болзошгүй.

Бороохой

Цагдаагийн алба хаагчид бороохойг тохируулж, дэг журамтай хэрэглэбэл жагсаал, цуглааны үеэр хүчирхийлэл үйлдэж буй оролцогчдыг зайлуулж, тараахад ашиглаж болохоос гадна цагдаа нарыг халдлагаас хамгаалж чадна. Бороохойгоор цохих тохиолдол бүр нь тохирсон хэм хэмжээнд байх ёстой гэдэг шаардлагыг хангах үндэслэлтэй байх ёстой. Бороохойг зөвхөн бусад анхан шатны хүч хэрэглэх гэж оролдоод үр дүнгүй болсон, эсвэл хэрэглэх боломжгүй үед л ашиглах ёстой.

Бороохой ашиглахад анхаарах зүйлс:

- Цагдаагийн хамгаалалтын бат бэх байдлыг харуулах, мөн хүмүүсийг хүчирхийлэл үйлдэхээс ятган болиулах, эсвэл холдохыг уриалах зорилгоор жагсагчдад харагдах сэрэмжлүүлэг болгон ашиглаж болно;
- Бусдыг өдөөн хатгасан байдлаар ашиглахгүй байх, өөрөөр хэлбэл, бамбайг бороохойгоор цохиж балбан, цугласан олныг «өдөөж» болохгүй;

- Бороохой хэрэглэх нь түрэмгийлэл, заналхийлэл гэж харагдах бөгөөд хурцадмал байдал, хүчирхийллийг даамжрахад хүргэж болзошгүй;
- Бороохой хэрэглэх тухай анхааруулга өгөх ёстой, гэхдээ үүссэн нөхцөл байдлаас болоод ийнхүү анхааруулах боломжгүй бол, эсвэл аливаа аюул заналыг арилгахын тулд бороохойг нэн даруй ашиглах шаардлагатай бол анхааруулга өгөхгүй байж болно;
- Хүний амь нас алдагдах, хүнд бэртэл гэмтэл учруулах эрсдэлгүй бол бороохойгоор хэзээ ч толгой, мөр, түүнчлэн бэлэг эрхтэн, нуруу болон биеийн бусад эмзэг хэсгүүдийг онилон цохиж болохгүй, учир нь энэ нь үхлийн аюулд хүргэх хүч болж болзошгүй буюу ноцтой гэмтэл учруулж болно;
- Нэгэнт хуульд заасны дагуу бороохойгоор цохисон бол дахин хүч хэрэглэхээ шууд зогсооно;
- Хүч хэрэглэх хариуцлагыг бороохой хэрэглэх болон бороохойг далайх тушаал өгсөн албан тушаалтан болон бороохой ашигласан алба хаагчийн аль аль нь хүлээнэ;
- Бороохой хэрэглэх нь өндөр түвшний бэлтгэл сургуулилт, маш нухацтай тушаал, хяналт, хувийн сахилга баттай байхыг шаарддаг.

Усан хөөрөг

Цагдаагийн байгууллагын ашигладаг олон төрлийн усан хөөрөг байдаг бөгөөд тэдгээрийг янз бүрийн зорилгоор ашигладаг. Заримыг нь нотлох баримт цуглуулах камераар тоногдсон (Нотлох баримт цуглуулах багийн тухай дээр бичснийг үзнэ үү) байдаг бол, зарим нь усыг химийн бодистой холиод ашиглах (Химийн бодисын тухай доор бичснийг үзнэ үү) зориулалттай байдаг. Жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалахад зөвхөн усан хөөргийг гал унтраах гэхээсээ илүү хууль сахиулах зориулалтаар ашиглах ёстой. Усан хөөрөг хэрэглэх аливаа нөхцөл нь тохирсон хэм хэмжээнд байх шаардлагыг хангах ёстой.

Усан хөөрөг ашиглах үндсэн зориулалт нь жагсаал, цуглаанд оролцож буй хүмүүсийн эсрэг их хэмжээний усыг харьцангуй их хүчээр шахах явдал юм. Тайван жагсаал, цуглааныг тараахад хэзээ ч усан хөөрөг ашиглаж болохгүй.

Усан хөөрөг ашиглахад анхаарах зүйлс:

- Усан хөөрөг ашиглахын тулд үйл ажиллагааны командлалын түвшин, эсвэл түүнээс дээш түвшинд зөвшөөрөл авсан байх ёстой;
- Усан хөөргийг хурдан хугацаанд дүүргэхүйц хангалттай даралттай найдвартай усны эх үүсвэр бэлэн байх шаардлагатай;

- Усан хөөрөг нь CS буюу нулимс асгаруулагч хийгээр цэнэглэсэн буутай харьцуулахад хүчийг илүү ялгавартай хэрэглэж болдог боловч олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлтэй харьцуулахад хүч нь бага (жишээ нь: бороохой, резинэн сумтай буу, эвхэгддэг толгойтой хуванцар сумтай буу, хөөсөн сумтай буу, резинэн бөмбөг, үрлэн сумтай буу);
- Усан хөөрөг байршуулах нь жагсаал, цуглаанд оролцогчдод айлган сүрдүүлсэн, эсвэл өдөөн хатгасан үйлдэл гэж ойлгогдож болно;
- Усан хөөрөг ашиглахын өмнө жагсаал, цуглаанд оролцогчдод анхааруулга өгөх ёстой;
- Усан хөөрөг ашиглах нь хальтиргаа гулгаа үүсгэх, өндөр даралттай уснаас хүмүүс унаж бэртэх зэрэг эрсдэлтэй;
- Усан хөөрөг нь хөдөлгөөнтэй алхалт, маршаас илүү хөдөлгөөнгүй жагсаал, цуглаанд илүү тохиромжтой;
- Хүмүүсийг аюулгүйгээр явах боломжийг бүрдүүлэхийн тулд тарах, эсвэл гарах гарц хангалттай байх ёстой;
- Барилга байгууламж нурж дарагдах аюултай нөхцөлд орсон хүмүүсийн эсрэг хэзээ ч усан хөөрөг хэрэглэж болохгүй;
- Шаардлагатай хүмүүст эмнэлгийн тусламж хүртээмжтэй байх ёстой;
- Усан хөөргийг зөвхөн сургаж бэлтгэгдсэн баг бүрэлдэхүүн ажиллуулна;
- Командлагчид усан хөөргийг хамгаалах цагдаагийн алба хаагчид зайлшгүй шаардлагатай гэдгийг мэдэж байх ёстой;
- Усан хөөргийг тэгээс доош температурт хэзээ ч хэрэглэж болохгүй.

Химийн бодис

Нулимс асгаруулагч хий гэж нэрлэгддэг CS хийн хэрэглээ нь цагдаагийн алба хаагчдын олон нийтийн жагсаал, цуглааныг хянахдаа ашигладаг тактикуудаас хамгийн нийтлэг нь байж магадгүй (цөөн тооны улс оронд хүч багатай боловч илүү хортой хлорацетофенон буюу CN-ийг ашигладаг). Хлоробензалмалонитрилийн талстуудыг хийнд шахаад цацахад энэ нь амьсгалах үед, эсвэл нүд, амны эргэн тойрон дахь чийглэг арьстай хэсэгт хүрэх үед түлэгдэх мэдрэмж төрүүлж, улмаар ханиаж найтаалгахад хүргэдэг. Ихэнх тохиолдолд нөлөө нь 10-20 минутын дотор арилдаг. Гэхдээ удаан хугацаагаар эсвэл бодис өтгөн байх үед нь өртвөл цэврүү үүсгэж өвтгөдөг.

Нулимс асгаруулагч хийг ихэвчлэн тусгайлан суурилуулсан винтовоос хөөргөх канистраар бууддаг ч гар канистраар бас шидэж болно. Аль ч тохиолдолд жагсаал, цуглаанд оролцогчид канистрыг аваад буцаагаад цагдаагийн хамгаалалт руу шидэж чаддаг. Газардангуутаа хий нь ууршдаг, жижиг хэмжээтэй үрлэн хэлбэрээр гаргадаг өөр төхөөрөмжүүд ч байдаг. Эдгээр аргын аль нь ч байсан хүн рүү шууд чиглэгдэх ёсгүй.

Зарим тохиолдолд нулимс асгаруулагч хийг устай холиод усан хөөргөөр буудаж болдог. Энэ нь хүчийг илүү ялгавартайгаар хэрэглэж буй хэлбэр бөгөөд шууд хэн нэг хүн рүү чиглүүлж болдог. Талст нь агаараар зөөвөрлөгдөөгүй учраас энэ арга нь олон хүнд нөлөөлөх магадлал багатай. Гэсэн хэдий ч нөлөөнд нь өртсөн хүмүүсийн хувьд хийн талстууд нь хувцсанд шингэдэг учраас нулимс асгаруулагч хийн нөлөөнд удаан хугацаагаар өртдөг.

Ажиллагааны зорилго нь зөвхөн жагсаал, цуглааныг тараахад чиглэх ёстой бөгөөд хүмүүс гарах боломжгүй хашигдмал буюу орон зай муутай орчинд нулимс асгаруулагч хийг хэзээ ч хэрэглэж болохгүй. Албадан тараах шийдвэр нь зайлшгүй шаардлагатай, мөн тохирсон хэм хэмжээнд байх ёстой. Оролцогчдыг жагсаал, цуглааныг орхиж явахыг шаардсан боловч шаардлагыг үл тоомсорлосон нөхцөлд хэрэглэнэ. Түүнчлэн жагсаал, цуглааныг тараахад хүрэхдээ эхлээд хор хөнөөл багатай арга хэрэгслийг ашиглах хэрэгтэй. Нулимс асгаруулагч хийг хэрэглэхээс өмнө анхааруулга өгөх ёстой. Жагсаал, цуглаанд тайван байдлаар оролцож буй хүмүүс болон тайван бусаар оролцож буй хүмүүсийн аль алиных нь эрсдэлийг сайтар үнэлж, тэдгээр эрсдэл нь жагсаал, цуглааныг тараах, зогсоохыг зорьж буй бодит хохирлоос давахгүй байх ёстой.

Хэрэглэж болох өөр нэг химийн цочрол өгөх бодис бол хүний нүүр рүү цацах зориулалттай ОС хий (oleoresin capsicum) буюу чинжүүтэй шүршигч юм. Энэ бодисыг жагсаал, цуглааныг тараах, хууль журмыг дагаж мөрдүүлэхээр хэрэглэхэд тохиромжгүй, харин зөвхөн хүчирхийлэл үйлдэж буй хүмүүсийн эсрэг хамгаалалт болгон хэрэглэж болно. Үүнийг ихэвчлэн жижиг гал унтраагч шиг биш, харин гар бууны бариултай адилхан гар төхөөрөмж хэлбэрээр ашигладаг. Шүршигч нь даралт ихтэй учраас хий нь нүүр, нүдийг гэмтээхээс сэргийлж, нэг метрээс бага зайд огт хэрэглэж болохгүй.

Химийн бодисыг цагдаагийн байгууллага өргөнөөр ашигладаг ч хэзээ ч хэрэглэж болохгүй тодорхой нөхцлүүд байдаг. Үүнд химийн бодисоос зугатааж зайлж чадахгүй өндөр настан, хүүхэд болон бусад хүмүүс байгаа битүү хаалттай газар, спортын цэнгэлдэх хүрээлэн зэрэг гарах гарцыг хязгаарласан, хүмүүс дарагдах аюултай газарт тайван жагсаал, цуглааныг тараах арга хэрэгсэл болгон ашиглахыг хориглоно. Зөвхөн зохих ёсоор туршигдсан, зөвшөөрөгдсөн химийн бодисуудыг хэрхэн ашиглах талаар тодорхой зааварчилгаатай, мөн шаардлагагүй буюу их хэмжээний хор хөнөөл, бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээтэй хамт ашиглах ёстой.

Химийн бодисыг ашиглахад анхаарах зүйлс:

- Химийн бодисыг ашиглахдаа хамгийн багадаа үйл ажиллагааны командлалын түвшинд зөвшөөрөл авсан байх ёстой;
- Химийн бодис агуулсан сум болон саваар хүмүүс рүү хэзээ ч буудаж болохгүй;
- Химийн бодис хэрэглэх нь цагдаагийн алба хаагч нарт муу үр дагавартай бөгөөд гэмтээж болзошгүй тул цагдаагийн байгууллага хамгаалах хэрэгсэл сайтай байх ёстой;
- Зэвсгийг ашиглаж буй алба хаагчдыг зөв ашиглахад сургасан байх;
- Газар дээрх ашиглалтыг үйл ажиллагааны захирагч хянаж байх ёстой;
- Зорьсон зорилгодоо хүрсэн бол химийн бодисын ашиглалт, байршуулалтыг үйл ажиллагааны болон тактикийн командлал зогсооно;
- Цаг агаарын нөхцөл байдал нь химийн бодис ашиглахад ихээхэн нөлөөлдөг;
- Химийн бодис нь үндсэндээ жагсаал, цуглааныг тараахад ашигладаг тактик бөгөөд зөвхөн бусад аргууд амжилтгүй болсон, эсвэл оролдсон ч амжилтад хүрэх магадлал багатай тохиолдолд, эсвэл зөвхөн хүчирхийлэл өргөн хүрээнд тархсан тохиолдолд л хэрэглэнэ;
- Хэрэглэхийн өмнө анхааруулга өгөх ёстой;
- Хөлбөмбөгийн цэнгэлдэх хүрээлэн, гарцгүй битүү гудамж гэх мэт жагсаал, цуглааныг тараахад хүндрэлтэй газруудад хэзээ ч ашиглаж болохгүй;
- Хүмүүс сандарч тэвдэх үед зугтах гарц, өргөн чөлөөг гаргаж өгөхөд анхаарах ёстой;
- Салхины чиглэл болон химийн бодис хаана хаягдахыг харгалзан зугатах зам чиглэл нь тохиромжтой байх ёстой;
- Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх буюу багасгахын тулд зугтах зам чиглэл нь жагсаал, цуглааны оролцогчдод тодорхой, ойлгомжтой байх ёстой;
- Зугтах зам чиглэл нь хажуугаараа илүү замгүй цагдаагийн хамгаалалт руу хэзээ ч чиглэх ёсгүй;
- Агаар дуслаар дамждаг бодисуудын хувьд тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй хүн амд анхаарал хандуулах ёстой бөгөөд хийг эмнэлгийн ойролцоо буюу ойр орчимд нь байрлуулахгүй байх ёстой;
- Шаардлагатай хүмүүст эмнэлгийн тусламж хүртээмжтэй байх ёстой;
- Химийн бодис хэрэглэсэн талаар зайлшгүй нарийн тодорхой тайлагнаж мэдээлэх ёстой (яагаад, хэрхэн, амжилттай болсон бол ямар түвшинд, учирсан хор хохирол гэх мэт).

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

Дэлхий даяар үхлийн аюул багатай асар их хэмжээний нөлөөллийн тусгай хэрэгслийг ашиглаж байна. Эдгээрт модон бороохой, резинэн сум, эвхэгддэг толгойтой хуванцар сум, хөөсөн сум, резинэн бөмбөг, үрлэн сум зэрэг орно. Эдгээр сумны хурд, калибрын хэмжээ нь олон янз байдаг бөгөөд энэ гарын авлагад эдгээрийн төрөл, үйлдвэрлэлийн талаарх зөвлөмжийг оруулаагүй. Гэхдээ эдгээрийг жагсаал, цуглааны үеийн хэв журмын хамгаалалтад ашиглахад анхаарах зарим зүйлс байдаг.

Дулаан ялгаруулдаг сумнууд нь цар хүрээний хувьд галт зэвсгийн дараа орох бөгөөд хүчний хэмжээ нь маш өндөр байдаг. Энэ утгаараа цагдаагийн алба хаагчид дулаан ялгаруулдаг сум нь үхэл багатай ч буруу хэрэглэвэл хүний амь нас эрсдэх, хүнд гэмтэл учруулж болзошгүй гэдгийг сайтар ойлгох ёстой. Тиймээс эрсдэлийг бууруулах арга хэмжээг дагаж мөрдөх ёстой.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг ашиглахад анхаарах зүйлс:

- Зөвхөн шалгаж, батлагдсан төрлийн сум ашиглах хэрэгтэй;
- Буудах зай, онилж буй байтай холбоотой тодорхой зааварчилгааг өгсөн байх;
- Алба хаагчид салшгүй эрсдэлийг анхаарч, зааварчилгааг дагаж мөрдөх;
- Дайчлан байршуулах эрхийг үйл ажиллагааны командлагч, ашиглах эрхийг тактикийн командлагч олгох ёстой;
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг зөвхөн хүнд бэртэл гэмтэл учрах, эсвэл хүний амь нас эрсдэх эрсдэл гарсан тохиолдолд л хэрэглэнэ;
- Эдгээрийг зөвхөн зохих ёсоор тоноглогдсон, сургаж бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн ашиглах ёстой;
- Буудлага нь зөвхөн хүнд гэмтэл учруулах, хүний амь нас эрсдэх шууд аюул заналхийлж буй хүмүүс рүү чиглэгдэх ёстой;
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслээр хэзээ ч олон хүн рүү ялгалгүй буудаж болохгүй;
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхдээ зөвхөн их биеийн доод хэсэг, эсвэл хөл рүү чиглүүлэх ёстой (хүнд гэмтэл, амь насаа алдах аюулаас бусад тохиолдолд);
- Байгаа онохын өмнө зориудаар газарт ойлгож болохгүй;
- Газар дээр ашиглахаар бол үйл ажиллагааны захирагчийн хяналтад байх ёстой;
- Зорьсон зорилгодоо хүрсэн тохиолдолд тэдгээрийн ашиглалт, байршуулалтыг үйл ажиллагааны болон тактикийн командлал хянаж байх ёстой;

- Хүмүүст аюулгүй явах боломжийг бүрдүүлэхийн тулд албадан тараах болон гарах гарц хангалттай байх ёстой;
- Шаардлагатай хүмүүст эмнэлгийн тусламж хүртээмжтэй байх ёстой;
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл нь зөвхөн бусад аргууд амжилтгүй болсон, эсвэл бүтэлгүй болсон, оролдсон ч амжилтад хүрэх магадлал багатай тохиолдолд л хэрэглэнэ;
- Боломжтой бол, хэрэглэхийн өмнө анхааруулга өгөх ёстой;

Галт зэвсэг

НҮБ-ын Хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд баримт бичигт галт зэвсгийг зөвхөн хүний амь насанд шууд бөгөөд бодитой заналхийлж буй хүмүүсийн эсрэг хэрэглэж болно гэж заасан байдаг. Галт зэвсэг хэрэглэх нь хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх хамгийн эцсийн арга хэмжээ бөгөөд үхлийн аюултай хувилбар юм. Галт зэвсгийг хэзээ ч олон нийтийн жагсаал, цуглааныг зохицуулах, хэв журам сахиулах үйл ажиллагааны хэрэгсэл гэж үзэж болохгүй. Хүчирхийлэл үргэлжилж байгаа тохиолдолд ч жагсаал, цуглааныг албадан тараахад галт зэвсэг хэрэглэж болохгүй.

Хэрэв ижил, эсвэл ижил төстэй үр дүнд хүрэх өөр сонголт байгаа бол тэр сонголтыг ашиглах нь зүйтэй. Хүний амь насыг хөнөөх нь цагдаагийн байгууллагын нэн тэргүүний зарчим (амь насыг хамгаалах)-тай харшилдаг бөгөөд амьд явах эрхийг зөрчинө. Тиймээс хүний амь насыг эрсдэлд оруулах нь зөвхөн өөр хүний амь насыг хамгаалах, аврах зорилгоор хийгдэж буй нөхцөлд л зөвшөөрөгдөх боломжтой.

Урьдчилан олж авсан мэдээллийн дагуу олон нийтийн арга хэмжээний үеэр тодорхой нөхцөлд хэв журам сахиулахад галт зэвсэгтэй тусгай алба хаагчид (өдөр тутмын хэрэгслээр тоноглогдсон цагдаагийн алба хаагчдыг ажиллуулахын оронд)-ыг байрлуулах онцгой хэрэгцээ байгаа бол эдгээр офицерууд нь сайтар сургаж бэлтгэгдсэн, тусгай хэрэгслээр тоноглогдсон байхаас гадна тухайн арга хэмжээний турш зөвхөн галт зэвсэг хэрэглэх ганцхан чиг үүрэгтэй байдаг.

Галт зэвсэг хэрэглэхэд анхаарах зүйлс:

- Нийтийн хэв журам сахиулах алба хаагчид нь зөвхөн гар буугаар зэвсэглэсэн байх ёстой бөгөөд гар бууг гэрэнд нь хийж, гал хамгаалагчийг нь түгжсэн байна;
- Алба хаагчийн болон өөр бусад хүний амь насанд шууд аюул заналхийлсэн нөхцөлд л галт зэвсгийг хэрэглэх хэрэгтэй;

- Нийтийн хэв журам сахиулах алба хаагчдыг боломжтой бол галт зэвсэг ашиглах эрхтэй алба хаагчдаас бүрдсэн жижиг багаар дэмжиж өгөх хэрэгтэй бөгөөд уг баг нь үзэгдэх байдлыг илүү сайн харуулах тоноглолтой, нарийвчлал сайтай, хоёр гараар барьж хэрэглэдэг зэвсгээр тоноглогдсон байна;
- Галт зэвсэг ашиглах багийг зөвхөн бодит аюул заналд тулгуурлан үйл ажиллагааны командлал хариуцан байрлуулж, харин газар дээр нь тактикийн командлагч нар удирдах хэрэгтэй;
- Галт зэвсэг хэрэглэсний хариуцлагыг тушаал өгсөн болон галт зэвсэг ашигласан алба хаагчид хүлээнэ;
- Галт зэвсгийг зөвхөн бусад аргуудыг туршиж үзсэний дараа, эсвэл тэдгээр нь бүтэлгүй болсон, оролдсон ч амжилтад хүрэх магадлал багатай тохиолдолд л хэрэглэнэ;
- Зөвхөн оновчтой ганц удаагийн буудлага хийх бөгөөд зөвхөн тухайн аюулыг арилгах зорилгоор хийнэ: хэзээ ч автоматаар гал нээхийг хүлээн зөвшөөрөхгүй;
- Олон нийт рүү ялгалгүй буудах нь хэзээ ч хууль ёсны гэж тооцогдохгүй бөгөөд хүлээн зөвшөөрөгдөхгүй;
- Буудлага нь зөвхөн цагдаагийн алба хаагч гэлтгүй аливаа хүний амь насанд шууд бөгөөд бодитой эрсдэл учруулж болзошгүй этгээдэд чиглэгдсэн байх;
- Галт зэвсэг ашиглаж буй алба хаагчид нь тэнэсэн сум тусах, зэргэлдээ байгаа гэм зэмгүй хүнийг онож болзошгүйг мэдэж байх;
- Үндсэн зорилгодоо хүрсэн тохиолдолд галт зэвсэг ашиглахыг зогсоож, байршуулалтыг үйл ажиллагааны болон тактикийн командлал хянаж байх шаардлагатай. Хүч хэрэглэхтэй холбоотой бүх тохиолдлын нэгэн адил галт зэвсэг хэрэглэсэн алба хаагч зорилгодоо хүрсэн, эсвэл хэрэглэх шаардлагагүй болсон үед галт зэвсэг хэрэглэхийг зогсоох ёстой;
- Хүмүүс сандарч тэвдэх үед зугтах гарц, өргөн чөлөөг гаргаж өгөхөд анхаарах ёстой;
- Шаардлагатай хүмүүст эмнэлгийн тусламж хүртээмжтэй байх ёстой;
- Цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн бол энэ тухай тайлагнаж, эргэж хянах ёстой.

Хяналтын хуудас

Ажиллагааны төлөвлөлтийн үе шатанд Командлалын багийн хүлээх үүрэг хариуцлагууд

Стратегийн командлал:

- ✓ Стратегийн төлөвлөгөөг ажиллагааны командлалд дамжуулах;
- ✓ Үйл ажиллагааны төлөвлөгөөний бэлтгэлийг бүхэлд нь хянаж, стратегийн зорилготой нийцэж буйг баталгаажуулах;
- ✓ Зохион байгуулагч нартай яриа хэлэлцээг үргэлжлүүлэх;
- ✓ Тухайн жагсаал, цуглааны хэв журмыг амжилттай хамгаалахад хангалттай нөөц бололцоогоор хангах.

Үйл ажиллагааны командлал:

- ✓ Зохион байгуулагчтай тодорхой яриа хэлэлцээг бий болгож, холбогдох;
- ✓ Ажиллагааны төлөвлөгөөг стратегийн зорилготой нийцүүлэн томъёолж, хүний эрхэд нөлөөлж болох аливаа шийдвэрийг гаргахдаа ил тод тодорхой байх;
- ✓ Аливаа нөхцөл байдалд ажиллагааны ямар хувилбарыг ашиглахаа нарийн тодорхойлж, тэдгээрийг ашиглахад тулгардаг эрсдэлийг хэрхэн шийдвэрлэхээ тодорхойлох;
- ✓ Холбогдох бүх мэдээллийг стратегийн командлалд дамжуулах;
- ✓ Хэв журам сахиулах холбогдох зорилтуудаа тодорхойлох;
- ✓ Эдгээр зорилтдоо хүрэх арга тактикаа тодорхойлж, эрсдэлийг тооцоолох;
- ✓ Үйл ажиллагааны командлагчдаа тодорхойлох.

7-Р БҮЛЭГ. ТАКТИКИЙН ТӨЛӨВЛӨЛГИЙН ҮЕ ШАТ

Үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасны дараа үйл ажиллагааг удирдаж буй командлагч нь зохих тооны алба хаагчдыг тодорхой чиг үүрэг, газарзүйн байрлал бүрээр хуваарилна. Зөвхөн зохих ёсоор сургаж бэлтгэгдсэн алба хаагчдад холбогдох үүрэг даалгавар өгөх ёстой гэдгийг анхааралтай авч үзэх хэрэгтэй.

Тактикийн командлагчдыг томилох, тэдний хүлээх хариуцлага, чиг үүргийг гаргахад анхаарна. Тактикийн командлагчдад үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх хангалттай хугацаа өгч, урьдчилан таамаглаагүй асуудал гарахгүйн тулд тэдэнд шалгаж нягтлах боломжийг олгох шаардлагатай. Тэд өөрсдийн үүрэгт тохирсон тактикийн төлөвлөгөөгөө гаргах хэрэгтэй болно.

Нийтийн жагсаал, цуглаанд тактикийн үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн бүх алба хаагч өөрсдийн хувь хүний эрх, эрх чөлөөгөө хамгаалах эрхтэй. Мөн цагдаагийн алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг анхаарч, алба хаагчдын бэлтгэлийг бүрэн хангуулж, хөрөнгө нөөцөөр хангах хэрэгтэй. Цагдаагийн командлагчдын анхаарах ёстой зарим чухал асуудлуудыг доор оруулав.

Мэдлэг

Мэдээлэл өгөх хурал: Алба хаагчдад мэдээлэл өгөх нь аливаа үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг бөгөөд үүрэг гүйцэтгэж буй алба хаагч бүр тухайн үйл явдлын стратегийн зорилго, түүнчлэн тактикийн параметруудийг мэддэг байх ёстой. Цагдаагийн бүх алба хаагч өөрсдийн онцгой үүрэг, хүлээж буй хариуцлагаа бүрэн ойлгож ухамсарлах ёстой. Түүнчлэн олон улсын хүний эрхийн хуулиар алба хаагчдад ямар үүрэг хариуцлага оногдож байгаа, хүч хэрэглэхэд тавигдах хязгаарлалт, ямар нэг төрлийн хүч хэрэглэсэн тохиолдолд ахлах ажилтанд мэдэгдэх шаардлагатайг сануулах зорилгоор алба хаагчдад мэдээлэл өгөх хэрэгтэй.

Үйл ажиллагааны командлагч нь бүх тактикийн командлагчдад холбогдох мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд тэдгээр нь эргээд өөрийн удирдлагад байгаа бүх алба хаагчид жагсаал, цуглаанд оруулахын өмнө мэдээлэл өгөх ёстой. Цагдаагийн бүх алба хаагч бүрэн мэдээлэл авч, бэлтгэлтэй байхын тулд үйл ажиллагааны төлөвлөгөөг тэдэнд урьдчилан танилцуулах ёстой. Үүнийг хийх өөр нэг арга бол цагдаагийн бүх алба хаагчид ажиллагааны төлөвлөгөөг аюулгүй арга, суваг ашиглан урьдчилан явуулж танилцуулах

явдал юм. Өгч буй бүх мэдээллийнхээ агуулгын талаар тэмдэглэл хөтлөх хэрэгтэй. Томоохон, эсвэл нарийн төвөгтэй байж болзошгүй ажиллагааны үед ажиллагааны командлагч бүх тактикийн командлагч нартай танхимын дасгал сургуулилт зохион байгуулж, янз бүрийн хувилбар, болзошгүй нөхцөл байдлыг загварчлан гаргаж ажиллах нь сайн туршлага юм.

Мэдээлэл өгөх хурлыг үр дүнтэй хийхийн тулд:

- Ажиллагаанд оролцох алба хаагчдын хэмжээнд тохирсон газар байршилд зохион байгуулагдана;
- Цаг хугацаа, байр танхимын хувьд хөндлөнгийн саад тасалдалгүй байх;
- Алба хаагчдад үүрэг хариуцлагаа тодорхой болгохын тулд мэдээлэл өгч буй ажилтнаас асуулт асуухыг зөвшөөрөх;
- Алба хаагч тус бүрээс юу шаардаж байгаа талаар эргэлзэх зүйлгүй байлгахын тулд тактикийн командлагчид зааварчилгааг бичгээр давхар өгч дэмжлэг үзүүлэх;
- Ажиллагааны хэмжээнээс шалтгаалан хэд хэдэн удаагийн мэдээлэл, танилцуулга хийх шаардлагатай үед хурлыг тогтмол тууштай хийх.

Тактикийн командлагчид жагсаал, цуглааны бүхий л явцад гарсан өөрчлөлт, явцын талаар алба хаагчдад мэдээлэл өгөх үүрэгтэй.

Дэмжлэг үзүүлэх

Доорх алхамууд нь аливаа жагсаал, цуглааныг үр дүнтэй хамгаалж, хэв журам сахиулах урьдчилсан нөхцөл юм.

Сургалт: Жагсаал, цуглаанд томилогдон ажиллаж буй алба хаагчид нь гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагынхаа дагуу зохих сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн байх ёстой.

Төхөөрөмж хэрэгслийг шалгах: Бүх алба хаагч өөрсдийн багаж хэрэгсэл, төхөөрөмжийг зорилгодоо нийцэж байгаа эсэхийг шалгах үүрэгтэй. Алба хаагчдыг үхлийн аюул багатай тусгай зориулалтын багаж хэрэгсэл, галт зэвсгээр хангахдаа тухайн зүйлсийн серийн дугаар, хэнд, хэзээ олгосон, хэрэв сум өгсөн бол тухайн алба хаагчид олгосон бүх сумны дугаарыг нарийн бүртгэж авна. Үүнийг хяналтын ажилтан хянаж, гарын үсэг зурсан байх ёстой.

Тактикийн командлагч болон үйл ажиллагааны командлагчийн хооронд холбоо тогтоохын тулд жагсаал, цуглаан болох өдөр хэвийн ажиллагаатай радио төхөөрөмж (нөөц зайны хамт) бэлэн байх ёстой. Ялангуяа алс зайнаас бусдаасаа тусдаа байрлан ажиллах алба хаагчдад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Радио холбоо эвдэрсэн тохиолдолд холбоог хэвийн үргэлжлүүлэхийн тулд нөөц гар утасны дугааруудын жагсаалтыг гаргаж өгөх хэрэгтэй. Бүх радио холбооны шугам болон холбогдох утасны дуудлагыг бүртгэж, тухайн үйл явдалтай холбогдуулан ямарваа асуудлыг шалгаж нягтлахад лавлагаа болгон ашиглах зорилгоор хадгална.

Чанга яригчийг жагсаал, цуглааны хэмжээ, байршил зэрэгт тохирсон эсэхийг шалгаж, цахим гэрлэн тэмдэглэгээг зохих хэлээр байрлуулж, бие даасан цахилгаан хангамжтай байх ёстой.

Тээврийн хэрэгсэл: Жагсаал, цуглаан дээр хамгаалалт хийж буй цагдаагийн алба хаагчдыг жагсаал, цуглаантай холбогдуулан томилсон үүрэгт газар, байршил руу нь хүргэж өгөх хангалттай тооны тээврийн хэрэгсэл бэлэн байх ёстой. Түүнчлэн баривчлагдсан хүмүүсийг аюулгүй тээвэрлэхэд тохиромжтой тээврийн хэрэгслийг бэлэн байлгах ёстой бөгөөд эмнэлгийн баг ажиллаж байгаа тохиолдолд өвчтэй, бэртэж гэмтсэн хүмүүсийг зөөвөрлөхөд тохиромжтой тээврийн хэрэгсэл шаардлагатай. Тухайн газар нутгийн талаар сайн мэдэхгүй алба хаагчаас тусламж хүсэх тохиолдолд орон нутгийн жолооч, чиглэл өгөх хүмүүсийг бэлэн байлгахад анхаарч үзсэн байх хэрэгтэй.

Хоол хүнс: Удаан хугацаагаар ажилласан алба хаагчдад хоол хүнс, бие засах газар хэрэгтэй тул командлагч нар хангалттай хоол хүнс бэлтгэж, бие засах тохиромжтой газраар хангах, эсвэл богино хугацаанд ээлжлэн явах байдлаар зохицуулж өгөх хэрэгтэй. Уух ус халуун цаг агаарт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад онцгой ач холбогдолтой бөгөөд нийтийн хэв журам хамгаалах ажиллагааны үед хэрэгцээ нь бүр илүү нэмэгддэг. Үүний нэгэн адил, хүйтэн цаг агаарт байгаа алба хаагчдад жагсаал, цуглааны дундуур болон дараа нь халуун уух юмыг зөвшөөрөх ёстой.

Амарч, сэргэх: Олон цагаар ажилласан алба хаагчдад амрах завсар чөлөө олгох ёстой. Үүнд командлагч, тэргүүн шугаманд ажиллаж буй алба хаагчид ч орно. Ядарч туйлдах нь хувь хүний шийдвэр гаргах чадварыг бууруулдаг тул алба хаагчид сайн амрах нь нэн чухал. Энэ нь сэлгэж ажиллах боломжтой байх шаардлагатай гэсэн үг юм. Сайтар нарийн төлөвлөснөөр үүрэг гүйцэтгэх нийт хугацааг уртасгахаас урьдчилан сэргийлж чадна.

Оролцогч талууд: Үйл явдлын өмнө бусад гол оролцогч талуудыг тодорхойлж, тэдэнтэй холбогдон татан оролцуулах хэрэгтэй. Гал түймэртэй тэмцэх, аврах алба, эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ нь жагсаал, цуглааны бүхий л хугацаанд хэвийн үргэлжилж байх шаардлагатай бөгөөд тэдний ажил үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс оролдох нь иргэдийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлж болзошгүй юм. Орон нутгийн бусад ажил үйлчилгээ үзүүлэгчдэд ч тухайн жагсаал, цуглаан нөлөөлж болох учраас тэдэнтэй эртнээс хамтран ажиллах нь асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх боломжийг олгоно.

Олон агентлаг хамтран ажиллах тохиолдолд хоорондын уялдаа холбоог сайтар хангах нь чухал. Үүнд удирдлагын тодорхой гинжин командлалыг бий болгох, агентлаг хоорондын харилцаа холбоог хангахын тулд нэг ижил радио давтамжийг ашиглах гэх мэт орно. Бусад гол оролцогч талууд үйл ажиллагааны командлагчтай шууд харилцаж болох хамтарсан тактикийн командын өрөөтэй байх нь зөв байж болох ба ингэснээр иргэд олон нийтийн хэрэгцээг хангаж чадна. Гэхдээ тухайн үйл явдлын үндсэн хяналт нь цагдаагийн байгууллагын командлалын багт байна.

Харилцаа холбоо

«Гэнэтийн бэлэг байхгүй»: Бэлтгэлийн үе шатанд яриа хэлэлцээ хийх сувгийг бий болгож, нээлттэй байлгаснаар зөвхөн жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон цагдаа нарын хооронд төдийгүй бусад бүх оролцогч талуудтай мэдээллийн сувгийг нээлттэй байлгах боломжтой. Энэ нь цагдаагийн байгууллагад тушаал шийдвэрээ сайтар бодож төлөвлөж гаргах, мэдээллээр хангах, аливаа худал мэдээлэл, үл ойлголцлыг арилгах боломжийг олгодог. Цагдаагийн алба хаагчид өөрсдийн үйлдэл, зохион байгуулалтыг бусад хүмүүс буруугаар ойлгож болзошгүйг мэдэж байх ёстой, тиймээс арга хэмжээ авахаасаа өмнө урьдчилан мэдэгдэж мэдээлэх нь хурцадмал байдлыг бууруулж, намжаах болно. Цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан болохоос өмнө иргэдийн гол оролцогч талуудтай холбоо тогтоож, үйл явдал эхлэх хүртэл тэдэнтэй тогтмол холбоо харилцаатай байх хэрэгтэй. Зарим тохиолдолд үйл явдлын бүхий л хугацаанд болон дууссаны дараа ч холбоо барих шаардлагатай болно. Энэ нь цагдаа нар жагсаал, цуглаанаас болж үйл ажиллагаа нь алдагдаж болзошгүй орон нутгийн бизнес эрхлэгчид, эсвэл олон нийтийн зохицуулагч нартай байнга холбоотой байж, санаа зовоосон асуудлуудыг шийдвэрлэх, мэдээлэл дамжуулах шаардлага гарч болно гэсэн үг юм.

Зохион байгуулагчид: Жагсаал, цуглааныг зохион байгуулагчидтай холбоо тогтоохдоо жагсаал, цуглаан эхлэх аваас үргэлжлэх хугацаанд ч хадгалагдаж байх ёстой. Гар утасны дугаараа солилцох нь харилцаа холбоогоо хадгалах хамгийн сайн арга байж болох юм. Үйл явдлын төлөвлөлтийн эхний шатанд холбоо барих нэг ажилтныг томилж өгөх нь сайн туршлага болдог.

Жагсаал, цуглааныг зохицуулагч: Жагсаал, цуглааныг зохион байгуулагчид арга хэмжээг зохицуулах, хууль ёсны дагуу тогтоосон аливаа хязгаарлалтыг дагаж мөрдөхийг баталгаажуулах үүднээс тодорхой танигдахаар хүмүүсийг томилон ажиллуулах нь сайн туршлага (гэхдээ хуулиар хүлээх үүрэг байх ёсгүй) юм. Эдгээр хүмүүс нь хууль сахиулах байгууллагын албан тушаалтны эрх мэдэл эдлэхгүй, мөн хүч хэрэглэх ёсгүй, харин оронд нь шаардлагатай үед оролцогчдод зөвлөмж өгөх, эсвэл ятгах замаар жагсаал, цуглаанд оролцогчдыг хамтран ажиллуулах зорилготой байх ёстой.

Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалагчид нь дангаараа болон бусадтай хамтран хүний эрхийг тайван аргаар сурталчлах, хамгаалахын төлөө ажилладаг хүмүүс юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагуудын эрх, үүрэг хариуцлагын тухай тунхагалд тэдний үүргийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Хүний эрхийн бүлгүүдтэй эртнээс харилцах нь хурцадмал байдлыг намжааж, итгэлцлийг бий болгоход тусална. Хүний эрхийн бүлгүүдтэй шаардлагатай үед арга туршлагаа хуваалцан ажиллах боломжтой. «Гэнэтийн бэлэг байхгүй» арга барилын дагуу цагдаагийн командлагч нар хүний эрхийн холбогдох байгууллагуудтай байнгын хамтран ажиллах, санал солилцохыг дэмжих, хэв журам хамгаалах үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн бүлгүүдийн тавьж буй санаа зовоосон асуудлуудад хариу өгөх чадвартай байх ёстой²⁴. Хүний эрхийг хамгаалагчид жагсаал, цуглаан хийх эрх хэрхэн хангагдаж буй талаар хяналт тавин оролцож болох ба цагдаа нар тэдэнтэй хамтран ажиллаж, ажлыг нь хөнгөвчлөх ёстой.

Бизнесийн байгууллага: Жагсаал, цуглаанаас болж үйл ажиллагаа нь хөндөгдөж болзошгүй орон нутгийн бизнес эрхлэгчидтэй үйл явдал

24 Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж, (Варшав: АИХЭГ, 2014), <<http://www.osce.org/odihr/119633>>.

болохоос өмнө холбогдох нь зүйтэй бөгөөд ингэснээр тэдний ажиллах цагийн хуваарь, ажилчдын тээвэрлэлт, хүргэлтийн талаар өөр зохицуулалт хийх боломжтой болно. Энэ нь ялангуяа тухайн бизнес нь жагсаал, цуглааны анхаарлын төвд байх тохиолдолд онцгой чухал юм.

Орон нутгийн иргэд, олон нийт: Тухайн газар, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа болон тийшээ зорчиж буй хүмүүсийн хувьд жагсаал, цуглааны хэмжээ, цар хүрээг эрт мэдээлж өгснөөр тэр хүмүүст өөр зохицуулалт хийх боломж олгоно. Ингэж мэдээлэх нь жагсаал, цуглаан эхлэхээс өмнө хүмүүст явах зам маршрутаа тохируулах, хүүхдээ харж хандах тохиромжтой арга хэмжээ авах, эсвэл нэн чухал худалдан авалт, хангамж зэргээ зохицуулах боломжийг өгнө. Ингэснээр цагдаагийн командлагчид олон нийт болон жагсаал, цуглаанд оролцогчдын хооронд маргаан, зөрчилдөөн гарах магадлалыг бууруулна.

Ялгаатай байдал

Үйл ажиллагааны болон тактикийн командлагч нар үүрэг гүйцэтгэж буй бүх алба хаагч нарт жагсаал, цуглаанд оролцогчдын олон янз байдлыг, мөн жагсаал, цуглааны явцад тэдгээр хүмүүст янз бүрийн хэрэгцээ шаардлага үүсэж болохыг хүлээн зөвшөөрч, бүхий л хугацаанд тайван ба тайван бус оролцогчдыг хооронд нь ялгаж салгах чадвартай байх, ингэснээр жагсаал, цуглааныг аюулгүй байдлаар явуулах боломжийг хангана гэдгийг бүрэн дүүрэн ойлгуулах ёстой.

Хяналтын хуудас

Бэлтгэлийн төгсгөлийн үе шатанд Командлалын багийн хүлээх үүрэг хариуцлагууд

Стратеги командлал нь:

- ✓ Үйл ажиллагааны төлөвлөгөө нь стратегийн зорилгод нийцэж байгаа эсэхийг шалгах;
- ✓ Хангалттай нөөцийг бэлэн байлгах;
- ✓ Хэвлэл мэдээлэлтэй ажиллах төлөвлөгөө батлагдсан эсэхийг баталгаажуулах;
- ✓ Үйл ажиллагааны командлагчид шинэ мэдээллийг дамжуулах.

Үйл ажиллагааны командлал нь:

- ✓ Зохион байгуулагчид болон оролцогч талуудтай харилцах шугамаа нээлттэй байлгах;
- ✓ Тактикийн командлагчдыг томилж, мэдээлэл өгөх;
- ✓ Тактикийн төлөвлөгөө нь үйл ажиллагааны болон стратегийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг шалгах;
- ✓ Цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөх цаг, байршлыг тогтоох;
- ✓ Тактикийн командлагч нартай танхимын дасгал сургуулилт, эсвэл симуляци буюу нөхцөл байдлыг зохиож, дүр эсгэж зохион байгуулах²⁵;
- ✓ Цагдаагийн байгууллагын зорилго, үйл ажиллагааны хувилбаруудыг эрсдэлийн үнэлгээтэй харьцуулан, тэдгээр нь тохиромжтой эсэхийг байнга эргэн үнэлэлт дүгнэлт хийх;
- ✓ Стратегийн командлалд шинэ мэдээллийг дамжуулах.

Тактикийн командлал нь:

- ✓ Үйл ажиллагааны командлал болон бусад тактикийн командлагч нартай зөвшилцөн тактикийн төлөвлөгөө гаргах;
- ✓ Урьдчилан таамаглаагүй асуудлуудыг эрт үе шатанд шийдвэрлэхийн тулд өөрсдийн хариуцдаг газар байршил, төхөөрөмж хэрэгслийг шалгах;
- ✓ Гүйцэтгэх үүрэгт ажиллах хангалттай бие бүрэлдэхүүн байгаа эсэхийг баталгаажуулах;
- ✓ Бүх алба хаагчид зохих ёсоор сургаж бэлтгэгдэж, ажил үүргээ гүйцэтгэх хэрэгслээр хангагдсан эсэхийг шалгах;
- ✓ Шинэ мэдээлэл ирэхэд үйл ажиллагааны командлал руу дамжуулах;
- ✓ Үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдал, хэрэгцээг хангах.

25 Танхимын дасгал сургуулилт нь ихэвчлэн хурлын том ширээг тойрон төлөвлөгөөний найдвартай байдлыг шалгах зорилгоор үйл явдлын өмнө хийгддэг дасгал сургуулилт юм.

III Хэсэг

ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ДУНДУУР

8-Р БҮЛЭГ. ЖАГСААЛ, ЦУГЛААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Аливаа жагсаал, цуглааны үед нийтийн хэв журмыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх гол түлхүүр нь зөв төлөвлөлт юм. Төлөвлөгөөг хэв журам сахиулах тодорхой зорилттой хамт боловсруулсан тохиолдолд ихэнх жагсаал, цуглаан шийдвэр гаргахад үйл ажиллагааны болон стратегийн командлалын оролцоо шаардлагагүй байдаг. Том, жижиг ихэнх жагсаал, цуглаан ямар нэг томоохон бэрхшээл асуудал үүсгэдэггүй бөгөөд бусдын ажил амьдралд учруулах хүндрэл нь богино хугацаанд үргэлжилдэг. Маш цөөн тооны жагсаал, цуглааны үеэр л хүчирхийлэл, эмх замбараагүй байдал үүсдэг.

Цагдаагийн байгууллага нь жагсаал, цуглааны үед мэдэгдэл ирүүлсний дагуу, эсвэл холбогдох зөвшөөрлийн дагуу хэв журам хамгаалах үүрэгтэй бөгөөд үйл явдлыг тайван явуулахад шаардлагатай хэв журам сахиулах хамгийн бага нөөц хэрэгслийг ашиглахыг үргэлж эрмэлзэх ёстой. Тактикийн командлагчид жагсаал, цуглааны явцад хэв журам хамгаалах үйл ажиллагааг байнга хянаж байх ёстой бөгөөд шийдвэр гаргах загварт тулгуурлан тухайн арга хэмжээний турш хэрэгжүүлж буй нөхцөл байдлаа мэдээлэх ёстой.

Энэ хэсэгт тайван жагсаал, цуглаан зохион байгуулахад цагдаагийн байгууллагын хийх ёстой гол үйл ажиллагаануудыг багтаан авч үзлээ. Үүнд эхлээд жагсаал, цуглаан зохион байгуулагчид эрх бүхий байгууллагад албан ёсоор болон албан бусаар мэдэгдсэний дагуу зохион байгуулсан, эсвэл цагдаагийн тагнуулын мэдээллийн дагуу цагдаагийн байгууллага урьдчилж мэдсэн жагсаал, цуглааны талаар авч үзнэ. Дараа нь аяндаа бий болсон буюу цагдаад ямар ч мэдэгдэлгүй, урьдчилан анхааруулалгүй болдог жагсаал, цуглааны үед цагдаагийн байгууллага хэрхэн хариу үйлдэл үзүүлэх ёстойг авч үзлээ. Түүнчлэн жагсаал, цуглаанд оролцож буй хүмүүсийн зан төлөвт нөлөөлдөг зарим хүчин зүйлсийг авч үзэж, үйл явдал хэрхэн эмх замбараагүй байдал, хүчирхийлэл болж хувирдаг талаар ойлголт өгнө.

Мэдлэг

Цагдаагийн командлагч нар тухайн жагсаал, цуглааны талаарх шинэ мэдлэг мэдээллийг тухай бүрт нь авч, жагсаал цуглаанд оролцогчид болон уг арга хэмжээнд нөлөөлж болзошгүй бусад үйл явдлуудтай холбоотой шинэ мэдээллийг холбогдох офицер, алба хаагчдад уламжлан дамжуулж байгааг баталгаажуулахыг хичээх ёстой.

Дэмжлэг үзүүлэх

Биечлэн байх: Жагсаал, цуглаанд оролцогчдыг цугларч эхлэхээс өмнө боломжтой бол цагдаа нар байраа эзэлсэн байх нь чухал. Цагдаагийн байгууллага офицер, алба хаагчид, техник хэрэгслийг хамгийн тохиромжтой газар байрлуулж, саад бартаа босгох, зам хаах, эрсдэлийн үнэлгээгээ хянаж, жагсаал, цуглааны үед зохицуулалт хийх, оролцогчдыг хамгаалах бусад зохицуулалт хийх боломжийг хангасан байх ёстой.

Жагсаал, цуглаан болох газар, маршрут нь маргаантай, эсвэл эмзэг орон зайд хамаарч байгаа тохиолдолд цагдаагийн алба хаагчдыг эрт байршуулах нь онцгой чухал юм. Хэрэв жагсаал, цуглаанд оролцогчид, эсвэл жагсагчид тодорхой нэг газар цуглахгүй байх нь чухал бол цагдаа эхлээд тэрхүү орон зайг урьдчилан авах нь зүйтэй. Ингэснээр цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг, эсвэл аль нэг тодорхой хэсгийг нь хөдөлгөх, шилжүүлэхэд цагдаагийн хүч хэрэглэх үед үүсэх бухимдал, шаардлагаас зайлсхийх, эсвэл багасгах боломжийг олгоно.

Газар дээр нь эрт очсоноор цагдаагийн ахлах ажилтан зохион байгуулагчид болон бусад гол оролцогч талууд, тэр дундаа хэвлэл мэдээллийнхэнтэй ирэх үед нь уулзаж, «гэнэтийн бэлэг байхгүй» зарчмын дагуу уялдуулан төлөвлөсөн арга хэмжээний талаар мэдээлэл өгөх боломжтой болно.

Цагдаагийн дарга командлагч нар тухайн газар дээр харагдахуйц байх цагдаагийн бие бүрэлдэхүүн болон бодитоор байх цагдаагийн бие бүрэлдэхүүн хоёрын хоорондын ялгааг ойлгох хэрэгтэй. Боломжтой бол ихэнх алба хаагч, техник хэрэгслийг жагсаал, цуглаан хийх газартай ойрхон, гэхдээ арга хэмжээнд оролцож буй хүмүүсийн шууд хараанаас хол байлгах хэрэгтэй. Өөр нэг хувилбар бол шаардлагатай үед бэлтгэгдсэн багуудыг эмх журам алдагдсан үед хэрэглэдэг бүрэн хэрэгсэлгүйгээр, шаардлагатай бол зөвхөн хамгаалалтын хэрэгсэлтэй уян хатан байдлаар байрлуулах явдал юм.

Хүлээцтэй байдал: Цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журам сахиулах, хууль сахин биелүүлэх үүрэгтэй ч, тэдэнд олгогдсон үүрэг хариуцлага нь өөрсдөд нь тодорхой хэмжээний эрх мэдэл өгдөг гэдгийг ямагт ухамсарлаж байх ёстой. Цагдаагийн байгууллага нийтийн жагсаал, цуглааны үед хэв журам сахиулахдаа хууль тогтоомжийн бага зэргийн зөрчил, эмх замбараагүй байдлыг тэвчихэд бэлэн байх ёстой. Хуулийг хэт хатуу хэрэглэх нь жагсаал, цуглаанд оролцогчдын уур хилэнг өдөөж, хурцадмал байдал, цагдаа нарын эсрэг тэмцэлд хүргэж болзошгүй юм.

Үүнийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой тусгаж, мэдээлэл өгөх хурал, танилцуулга дээр тодруулж байх хэрэгтэй.

Шийдвэрүүдийг бүртгэж хөтлөх: Цагдаагийн командлагч нар гаргасан шийдвэр, өгсөн тушаалаа бодит цаг хугацаанд нь протокол хөтлөн бүртгэж, дараа дараагийн мэдээлэл хийх хурал зэрэг дээр мэдээлэхэд бэлэн байлгах ёстой.

Харилцаа холбоо

Үйл явцын бусад үе шагуудын нэгэн адил зохион байгуулагчидтай яриа хэлэлцээг нээлттэй үргэлжлүүлэх ёстой. Зохион байгуулагч нь сайн дурын болон мэргэжлийн зохицуулагчийн үйлчилгээг авсан бол тэдгээр зохицуулагч, эсвэл цуглаан зохион байгуулагчид (зохицуулагч байхгүй тохиолдолд)-д мэдээлэл өгөхийн тулд мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан цагдаагийн ажилтан томилон ажиллуулж болно. Хэв журам хамгаалах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх хурлын үеэр мэдээллээ хуваалцаад, дараа нь жагсаал, цуглаан үргэлжлэх бүхий л хугацаанд уг жагсаал, цуглааныг хариуцаж буй ерөнхий зохицуулагчтай холбоотой ажиллах нь зүйтэй.

Арга хэмжээний үеэр зохион байгуулагчидтай нээлттэй ярилцаж, тэдний хүсэлтийг шуурхай ажиллагааны командлагчид уламжлах, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, хүсэлтийг зохион байгуулагчдад уламжилж байх үүргийг тактикийн ахлагчид хариуцуулах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллага жагсаал, цуглааны үеэр алба хаагчид нь харилцаж буй бүх хүмүүстээ үнэн зөв, нэгдсэн мэдээлэл мессеж өгч байгаа эсэхийг баталгаажуулахыг үргэлж зорьж байх ёстой. Эдгээр хүмүүст арга хэмжээг зохион байгуулагчид, оролцогчид, эсэргүүцэгчид, хэвлэл мэдээллийнхэн, хүний эрхийг хамгаалагчид орно. Мөн мэдээллийн урсгал үйл явдлын туршид тасралтгүй байж, «гэнэтийн бэлэг байхгүй» гэсэн зарчмынхаа дагуу тухайн нөхцөл байдалд гарч болзошгүй аливаа өөрчлөлтийн талаар холбогдох талуудад мэдээлж байх ёстой.

Мөн цагдаагийн байгууллага зөвхөн цагдаагийн үйл ажиллагаандаа тус дөхөм болох мэдээллийг цуглуулах гэж зорихын оронд холбогдох талуудтай хоёр талын харилцан мэдээлэл солилцохыг эрмэлзэх ёстой. Энэ нь зохион байгуулагчид болон оролцогчдын санаа бодлыг цаг тухайд нь авч, аливаа асуудалд хариу өгөх ёстойгоос гадна эргээд зохион байгуулагчдад мэдээлэл

өгч, ингэснээр аливаа хурцадмал байдалд хариу үйлдэл үзүүлэхдээ зохион байгуулагчид өөрсдийн зан төлвөө нийцүүлж ажиллана гэсэн үг юм. Ялангуяа хоёр талын харилцан мэдээлэл солилцох замаар жагсаал, цуглааны үеэр дэгдэж болзошгүй элдэв цуу яриаг үр дүнтэй шийдвэрлэх боломжтой. Зохион байгуулагчид болон цагдаа нарын хоорондын харилцаа муу, хоорондын итгэлцэл байхгүй тохиолдолд элдвийн цуу яриа нь ярвигтай асуудал үүсгэдэг.

Цагдаагийн командлагчид цагдаагийн алба хаагчдын өмсөж буй дүрэмт хувцасны төрөл, авч явах хэрэгсэл, жагсаал, цуглаан болж буй газар дээр шууд харагдах алба хаагчдын тоо, мөн оролцогчдын нүдэн дээр ямар тээврийн хэрэгсэл болон бусад техник хэрэгсэл ил харагдах вэ гэдэг асуудлууд дээр онцгой анхаарч үзэх хэрэгтэй. Цагдаагийн алба хаагчдын гадаад байдал, нөөц хэрэгсэл зэрэг нь аман бус харилцааны нэг хэлбэр бөгөөд цагдаа нарын харагдах байдал жагсаал, цуглаанд оролцохоор цугларч буй зохион байгуулагчид болон хүмүүст зорилго, хүлээлтийн талаар тодорхой мессежийг өгөх болно. Өдөр тутмын дүрэмт хувцас өмссөн цагдаа нарыг харах нь цагдаагийн байгууллага хяналтандаа байлгаж байгаа юм байна гэсэн сэтгэгдэл төрүүлж, тайван арга хэмжээ зохион байгуулагдах хүлээлтийг төрүүлдэг бол, цагдаагийн алба хаагчид бослого самууны үед өмсдөг хувцас хэрэгсэлтэй байвал цагдааг илүү түрэмгий догшин харагдуулж, эмх замбараагүй байдал үүсэх хүлээлтийг төрүүлнэ. Цагдаа нарыг үймээн самууны үед өмсөх хувцас хэрэгсэлтэй байхыг харах нь оролцогчдын дунд хурцадмал байдлыг бий болгох, эсвэл алба хаагчдыг сайн хамгаалалтай гэж үзэж алба хаагчдын эсрэг хүчирхийлэл гарах босгыг бууруулах боломжтой. Энэ нь цагдаагийн байгууллагатай түрэмгий харьцах, хамтран ажиллахгүй байх магадлалыг бодитоор нэмэгдүүлж магадгүй юм.

Ялгаатай байдал

Командлагчид цагдаагийн алба хаагчид нь оролцогчдын олон янз, ялгаатай байдлыг мэдэж, жагсаал цуглааны үеэр олон янзын оролцогчдын хэрэгцээ шаардлага өөрчлөгдөх бүрт хариу үйлдэл үзүүлж ажиллаж буй эсэхийг үргэлж баталгаажуулж байх ёстой. Цагдаагийн алба хаагчид мөн цугларсан хүмүүсийн дотор буй өөр өөр бүлэг хүмүүсийг ялгах чадвартай байж, ялангуяа үг хэллэг, үйлдлээрээ хурцадмал байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж болзошгүй, үйлдлийг нь нэн даруй, эрт үед нь зохицуулах шаардлагатай хүмүүсийг ялган таньж байх ёстой.

Цагдаагийн зан байдал

Цагдаагийн алба хаагчид жагсаал, цуглаанд оролцогчидтой адил олны өөрчлөлт хөдөлгөөнд өртөмтгий байдгийг цагдаагийн командлагч дарга нар анхаарах хэрэгтэй. Цагдаагийн алба хаагчид нь хэв журмыг нь хамгаалж буй хүмүүстэйгээ ижил төстэй хүн ам зүйн зан төрхтэй байх ба ялангуяа хурцадмал байдал нэмэгдэх үед сэтгэлийн түгшүүр, эргэлзээ, уур хилэн, айдас зэрэг янз бүрийн сэтгэл хөдлөлийг мэдэрч байдаг. Цагдаагийн алба хаагчид болон жагсагчид хоёрын гол ялгаа нь цагдаагийн алба хаагчид нийтийн хэв журам хамгаалахад сургаж бэлтгэгдсэн, тусгай зориулалтын тоног хэрэгсэлтэй, ахлах албан тушаалтны удирдлага дор ажилладаг. Иймд үйл ажиллагааны болон тактикийн командлагчид нь цагдаагийн алба хаагчдаа хэл амаар доромжлох болон бусад хэлбэрийн өдөөн хатгалгатай тулгарсан ч сахилга баттай байж, хяналтаа алдахгүй байхыг нь ханган ажиллах нь чухал юм.

Цагдаагийн командлагч нар жагсаал, цуглааны оролцогчидтой харилцаа холбоогоо хэрхэн сайжруулах талаар байнга бодож байх ёстой. Жагсаал, цуглаанд оролцогчид болон цагдаа нарын хоорондын харилцаа, мөн жагсаал цуглааныг зохион байгуулахад цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг хууль ёсны гэж үзэж байгаа зэргээс шалтгаалан жагсаал, цуглааны динамик буюу явц өөрчлөгдөж болно гэдгийг тэд санаж байх ёстой. Бүх л жагсаал, цуглаанд цагдаа болон өөрсдийнхөө талаар өөр өөр үзэл бодол, хандлагатай олон янзын оролцогчид байдаг. Цөөн тооны л жагсаал, цуглаан дээр цагдаа нарт бүхэлдээ дайсагнасан хандлагатай байдаг. Цагдаагийн алба хаагчдын авч буй арга хэмжээнээс болж цагдаагийн эсрэг дайсагнасан хандлага ихэсдэгтэй адил цагдааг ойлгож, хүндлэх нь ч бий. Цагдаагийн алба хаагчдын хүлээцтэй байдал, хүмүүнлэг үйлдэл (жишээ нь, ядарч зовсон нэгэнд туслах) нь жагсагчидтай харилцах харилцааг сайжруулж, хүмүүсийн өөрийгөө хянах чадварыг дэмжиж, хурцадмал байдлыг намжаахад тусалдаг бол, цагдаа нарын аливаа хүч хэрэглэх оролдого нь оролцогчдын зан төлөвт сөргөөр нөлөөлж, жагсаал цуглаан дээр эмх замбараагүй байдал үүсэх магадлалыг нэмэгдүүлж болзошгүй. Цагдаагийн алба хаагчдыг хэв журмыг нь хамгаалж буй хүмүүстэйгээ эерэгээр харилцахыг үргэлж дэмжин урамшуулж байх ёстой.

Цагдаа сөргөлдсөн үйлдэл хийвэл оролцогчдын дунд цагдаа нарын хууль ёсны байдалд итгэл буурч, бүр алдагдаж ч болзошгүй. Харин цагдаа нь дэмжин туслах үүрэг гүйцэтгэж, хүмүүстэй харилцаж холбогдож эхлэхэд хэв журмаа хамгаалуулж байгаа хүмүүс нь хүлээн зөвшөөрч магадгүй юм. Цагдаагийн хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрч буй оролцогчид

тайван амгалан байх магадлал харьцангуй өндөр бөгөөд эмх замбараагүй байдал үүсэх магадлалыг эрс багасгадаг. Эдгээр оролцогчид бусдыг тайван байлгахад илүү их уриалж, бусдын зохисгүй, хүчирхийллийн үйлдлээс өөрсдийгөө холдуулж, зайгаа барих магадлал өндөр байдаг. Жагсаал, цуглааны бүх үе шатанд харилцаа холбоо үүсгэж, дэмжлэг үзүүлэх нь арга хэмжээг тайван, амжилттай үр дүнд хүргэх түлхүүр болдог.

Аяндаа бий болдог жагсаал, цуглаан

Зарим тохиолдолд жагсаал, цуглааныг цаг үеийн чухал асуудал, эсвэл нэн яаралтай шийдвэрлэх асуудлаас үүдэн зохион байгуулдаг бөгөөд зохион байгуулагчид болон оролцогчид нь богино хугацаанд цугларах хүсэлтэй байж болно. Ийм нөхцөлд жагсаал, цуглаан зохион байгуулах хууль ёсны мэдэгдэл хүргүүлэх боломжгүй байдаг. Бусад тохиолдолд ойр орчмын хүмүүсийг гайхшруулах зорилгоор цуглаан зохион байгуулж болно. «Флаш моб» гэдэг нь аяндаа бий болдог жагсаал, цуглааны нэг төрөл (ихэвчлэн гар утсаар зурвас илгээж, эсвэл олон нийтийн сүлжээгээр дамжуулан зохион байгуулдаг) бөгөөд ямар нэг чухал санаа, мэдэгдэл хийх зорилгоор цуглараад, дараа нь маш хурдан тардаг. Зарим жагсаал, цуглааныг зохион байгуулагчид нь цагдаад үл итгэх, эсхүл цуглаан хийхийг хориглох вий гэсэн болгоомжлолоос үүдэн цагдаад мэдэгдэлгүй зохион байгуулдаг учраас жагсаал, цуглаан болох гэж байгаа гэж ойлгуулахыг зорьдоггүй.

Ийм үйл явдал нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байж болох ч цагдаа нар ийм тайван жагсаал, цуглаанд дэмжлэг үзүүлэн ажиллах ёстой. Хэрэв цагдаагийн байгууллага ийм арга хэмжээнд төлөвлөх, нөөц хүчийг хуваарилах боломж байгаагүй бол цагдаагийн байгууллагаас яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай. Ер нь цагдаагийн байгууллага ийм нөхцөл байдалд ажиллах гэнэтийн болзошгүй байдлын төлөвлөгөөтэй байх ёстой.

Нийгмийн сүлжээ, гар утас, интернетийн сүүлийн үеийн технологийн дэвшил нь хүмүүсийг зохион байгуулалтын уламжлалт хэлбэрт найдалгүйгээр богино хугацаанд жагсаж, цугларахад илүү хялбар дөхөм болгож байна. Аяндаа зохион байгуулагддаг олон жагсаал, цуглаан бүр албан ёсны зохион байгуулагч ч байхгүй, харин янз бүрийн албан бус олон нийтийн сүлжээгээр дамжуулан жагсаж цуглардаг.

Жагсаал, цуглаан зохион байгуулагдаж, цагдаад ямар нэгэн урьдчилан мэдэгдэл ирээгүй тохиолдолд тухайн газарт түрүүлж ирсэн цагдаагийн

алба хаагчид анхны арга хэмжээг авна. Түрүүлж ирсэн алба хаагчдын хувьд хамгийн түрүүнд анхаарах зүйл бол тайван жагсаал, цуглаанд дэмжлэг үзүүлж, нөхцөл байдлыг хэрхэн хамгийн сайн тогтворжуулах вэ гэдэг асуудал байх ёстой. Өөрөөр хэлбэл, тэнд ямар ч үйл явдал болж байсан тэр нь тайван явагдаж, оролцогчдын аюулгүй байдлыг ханган, хэрэв эмх замбараагүй байдал үүсвэл зан байдал нь бусдад халдахааргүй, аюул учруулахгүй байх ёстой.

Хэрэв цагдаагийн байгууллага төлөвлөөгүй жагсаал, цуглаанд хариу арга хэмжээ авч байгаа бол цагдаагийн командлагчид (үйл ажиллагааны эсвэл тактикийн түвшний алинд ч ажиллаж буй) эхлээд нөхцөл байдлыг үнэлж, 3-р бүлэгт тодорхойлсон шийдвэр гаргах загварыг ашиглан хэрхэн хариу арга хэмжээ авах, тухайн жагсаал, цуглаанд хэрхэн дэмжлэг үзүүлж ажиллах талаар үнэлэлт дүгнэлт хийнэ. Цагдаагийн байгууллага зохион байгуулагчидтай харилцан яриа хэлэлцээ өрнүүлэхийг хичээх нь цагдаа болон зохион байгуулагчдын аль алиных нь санаа зорилгыг тодорхой болгоход чухал. Жагсаал, цуглаанд оролцогчдын дунд эмх замбараагүй байдал, аюул занал учруулахуйц ямарваа үйлдэл хийхгүй байхад цагдаагийн байгууллагын зүгээс анхаарах хэрэгтэй. Нөхцөл байдлыг нүдээр харж үнэлснээр жагсаал, цуглааныг зохион байгуулахад цагдаа нар хамгийн үр дүнтэйгээр дэмжлэг үзүүлэхэд хэрэгтэй зохих нөөц хэрэгслээ бүрдүүлэх боломжтой болно. Хэрэв жагсаал, цуглаан нь хүчирхийллийн шинжтэй болж ирвэл хүчирхийллийг дарах нь нэн тэргүүнд тавигдах ёстой. Төлөвлөөгүй жагсаал, цуглаануудын ихэнх нь тайван болж өнгөрдөг бөгөөд цагдаагийн анхаарлыг татахаас өөр зүйл гардаггүй.

Цагдаагийн байгууллагын нэн тэргүүний зорилт бол олон нийтийн аюулгүй байдал байх ёстой бөгөөд ихэнх жагсаал, цуглаанд жагсаал, цуглааны эхэнд болон төгсгөлд хүмүүсийг тарах үед замын хөдөлгөөнийг хянаж зохицуулахад тусламж хэрэгтэй болдог. Мөн тухайн жагсаал, цуглааныг эсэргүүцэж буй хүмүүс хурцадмал байдал үүсгэх, хүчирхийлэл үйлдэх магадлалтай эсэхийг анхаарах нь зүйтэй.

Дараа нь цагдаа жагсаал, цуглаанд шууд бусаар оролцож болох хүмүүсийн аюулгүй байдлын асуудлыг авч үзэх ёстой. Замын хөдөлгөөнийг тухайн бүсээс холдуулж, зам тээврийн хөдөлгөөн саатах тухай мэдээллийг хуваалцах шаардлагатай. Ялангуяа гал түймэр, түргэн тусламж зэрэг үйлчилгээний байгууллагуудад зайлшгүй мэдээлэх шаардлагатай, учир нь эдгээр үйлчилгээнд саатал гарах нь аливаа ослын үед яаралтай хариу арга хэмжээ авахад нөлөөлж болзошгүй. Мөн цагдаагийн байгууллага тухайн орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийг ч анхаарч үзэх хэрэгтэй.

Томоохон жагсаал, цуглаанууд нь боломж нөхцөл гарахыг отож байдаг гэмт хэрэгтнүүдийг өөртөө татах магадлалтай. Эцэст нь, цагдаагийн байгууллага оролцогчдын нас, хүйс, мөн жагсаал, цуглааныг харж ажиглах хүмүүс зэрэг бусад хүчин зүйлс дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Хэрэв жагсаал, цуглаан нь удаан үргэлжлэхээр бол цагдаагийн байгууллага командлалын бүтцийг бий болгож, стратегийн зорилго, хэв журам хамгаалах зорилтуудаа тодорхойлж, үйл ажиллагааны сонголт, нөөцүүдийг хуваарилж, зохион байгуулагчидтай албан ёсны харилцаа холбоогоо үргэлжлүүлэх шаардлагатай болно. Аливаа тайван жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалахад олон нийтэд тодорхой хэмжээгээр хүндрэл учирч болзошгүй бөгөөд хэрэв олон нийтийн аюулгүй байдалд тодорхой аюул занал учруулахгүй бол цагдаагийн анхны арга хэмжээ нь жагсаал, цуглааныг зогсоох, тараах явдал байж болохгүй. Жагсаал, цуглааныг хязгаарлах, тараах аливаа шийдвэр гаргахдаа холбогдох бүх хүмүүсийн эрх, эрх чөлөө, түүнчлэн тараах үед учирч болох хохирлыг хурцатгах эрсдэлийг нухацтай авч үзэх шаардлагатай.

Оролцогчдод явах боломжийг олгох

Зарим үед оролцогчид жагсаал, цуглаан болж буй газрыг орхиж явахаар шийддэг. Жагсаал, цуглаанд оролцогчид аяндаа тарж явах боломжтой байх ёстой бөгөөд хүмүүсийг цагдаагийн оролцоогүйгээр талбайг орхин явахыг зөвшөөрөх ёстой. Оролцогчдыг жагсаал, цуглаан болж буй талбайгаас аюулгүй замаар чөлөөтэй нэвтрэн гарах боломжийг хангах, тэднийг хүчирхийлэл үйлдэхээр заналхийлж болзошгүй дайсагнасан эсэргүүцэгчдийн дайралтаас хамгаалах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй.

Хэрэв ямар нэг байдлаар цагдаагийн оролцоотой тараах шаардлага тохиолдвол тодорхой хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Тухайлбал:

- Хүмүүс гарч явахад тохиромжтой гарц, эсвэл зугтах зам бэлэн байх ёстой;
- Тарсан жижиг бүлгүүдэд хэв журам сахиулахад нэг том бүлгээс илүү хэцүү байдаг;
- Нэгэнт тарсан хүмүүс гэртээ харих боломжтой байх шаардлагатай;
- Хүмүүсийн нүдэнд олон тооны цагдаа харагдах нь жагсаал, цуглааныг жам ёсоороо тарах нөхцөлийг удаашруулж болзошгүй тул цагдаагийн алба хаагчдыг хүмүүсийн нүднээс далд байлгаж, гэхдээ шаардлага гарахад бэлэн байлгахаар байрлуулах талаар анхаарч үзэх хэрэгтэй;

- Цагдаагийн байгууллага хүмүүсийг тараахдаа эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аюулгүй байдалд үл зохицох аливаа асуудлуудыг мөн анхаарч үзэх хэрэгтэй.

Хэрэв жагсаал, цуглаан нь бусдын эрх, эрх чөлөө, орон нутгийн иргэдийн сайн сайхан байдалд бага эсвэл огт нөлөө үзүүлэхгүй, мөн аюулгүй газар байгаа бол цагдаа нар жагсаал, цуглаанд оролцогчдыг үлдээж, хүмүүс хоорондоо харилцан ярилцах хэлбэрээр жагсаал, цуглаанд удаан хугацаагаар оролцох боломжийг олгох хэрэгтэй.

Хяналтын хуудас

Дэмжлэг үзүүлэх үе шатанд Командлалын багийн хүлээх үүрэг хариуцлагууд

Стратегийн командлал нь:

- ✓ Тухайн үйл явдал хүний эрхэд нийцсэн хэвээр байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хэв журам сахиулах ажиллагаанд хяналт тавих;
- ✓ Стратегийн зорилгыг тухайн үйл ажиллагаанд тохирсон эсэхийг хянаж үзэх;
- ✓ Ажиллагааны командлагчтай харилцаж хангалттай нөөц байгаа эсэхийг баталгаажуулах;
- ✓ Үйл ажиллагааны командлагчид мэдээлэл өгөх.

Стратегийн командлал нь:

- ✓ Үйл ажиллагааны командлал нь:
- ✓ Тактикийн бүх командлагчдад ажиллагааны талаар мэдээлэл өгөх;
- ✓ Стратегийн командлал руу мэдээлэл дамжуулах;
- ✓ Хүний эрх, стратегийн зорилгод нийцүүлэн арга хэмжээг зохион байгуулах;
- ✓ Эрсдэлийн үнэлгээ, шинэ мэдээлэлтэй уялдуулан хэв журам хамгаалах зорилго, цагдаагийн тактикийн хэрэглээг байнга хянаж, батлах, өөрчлөх;
- ✓ Гэмт хэргийн шинжтэй аливаа зан байдлыг зохих ёсоор шалгаж байгаа эсэхийг баталгаажуулах;
- ✓ Алба хаагчдадаа анхаарал халамж тавих.

Тактикийн командлал нь:

- ✓ Өөрийн удирдлагад байгаа бүх алба хаагчдад мэдээлэл өгөх;
- ✓ Бүх алба хаагчид хүний эрхийн дагуу ажиллаж, зохисгүй зан үйлд шаардлага тавих;
- ✓ Хүч хэрэглэсэн тохиолдолд аль болох шуурхай мэдээлэх;
- ✓ Гэмт хэргийн нотлох баримт, тэр дундаа цагдаагийн хууль бус үйлдлийг шалган нягталж, хадгалж, мөрдөн шалгах багт шилжүүлэх;
- ✓ Үйл ажиллагааны командлалтай харилцан мэдээлэл дамжуулах;
- ✓ Зохих ёсоор цагдаагийн тактикийн эрх олгох буюу татгалзах;
- ✓ Өөрийн удирдлагад байгаа алба хаагчдадаа анхаарал халамж тавих.

9-Р БҮЛЭГ. ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ, ХҮЧИРХИЙЛЛИЙГ УДИРДАХ

Жагсаал, цуглаануудын дийлэнх нь тайван амгалан болж, хууль тогтоомж болон бусад хязгаарлалтуудыг дагаж мөрдөн, оролцогчид эцэст нь чимээгүйхэн тардгийг цагдаа нар санаж байх хэрэгтэй. Эмх замбараагүй байдал, хүчирхийлэл нь харьцангуй ховор тохиолддог хэдий ч ийм хүчирхийллийн талаар байнга мэдээлдэг учраас бодит байдлаасаа илүү түгээмэл гардаг мэт санагдаж болох юм.

Цагдаагийн байгууллага үйл явдал болохоос өмнө, эсвэл жагсаал, цуглаан болж байх үеэр авч буй (эсвэл аваагүй) арга хэмжээ, хийдэг мэдэгдэл (эсвэл хийгээгүй) зэрэг нь хурцадмал байдлыг дэвэргэхэд хэрхэн нөлөөлж болох вэ гэдгийг үргэлж анхаарч үзэх хэрэгтэй. Цагдаа жагсаж цугларч буй хүмүүсийн тоонд хяналт тавьж чадахгүй байж болох ч, харин болж буй яриа хэлэлцээ, харилцаа холбоогоо хянаж удирдаж чадах учраас үр дүнтэй харилцаа холбоо (зөвхөн арга хэмжээнд оролцогчид, зохион байгуулагчидтай төдийгүй нийгмийн сүлжээгээр дамжуулан илүү өргөн хүрээнд) тогтоохын зэрэгцээ «гэнэтийн бэлэг байхгүй» гэдэг бодлогыг баримтлах нь маш чухал юм. Цагдаагийн байгууллага сөрөг муу зан төлөвтэй тулгарах гэж байнга хүлээж байхын оронд эерэг зөв хандлагыг дэмжин ажилласнаар жагсаал, цуглаан амгалан тайван байх боломжийг бүрдүүлнэ.

Жагсаал, цуглаан нь хууль тогтоомж зөрчин зохион байгуулагдсан байсан ч ямарваа хүчирхийлэлгүй хэвээр байвал цагдаа хүч хэрэглэхээс зайлсхийх ёстой. Өмнө нь дурьдсанчлан, хүч хэрэглэхээс өөр сонголт байхгүй тохиолдолд л хүч хэрэглэнэ. Аливаа нөхцөл байдалд ямарваа нэг хүч хэрэглэх нь нийгмийн хэв журмыг сэргээхэд шаардагдах хамгийн эцсийн бөгөөд зайлшгүй шаардлага байх ёстой. Жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалахад хүч хэрэглэх шаардлагыг багасгахын тулд цагдаагийн байгууллага хэзээд үйл ажиллагааны олон янзын сонголттой байх ёстой бөгөөд аливаа хүч хэрэглэхийн өмнө хөндлөнгөөс оролцохоос илүүтэй харилцаа холбоо тогтоох, яриа хэлцэл хийх, нотлох баримт цуглуулах гэх мэт хувилбаруудыг ашиглах ёстой. Боломжтой бол, цагдаагийн байгууллага хурцадмал байдал, эмх замбараагүй байдлыг бууруулахаар албан бус арга хэрэгслээр нөлөөлөх, түүний үр дүнг нь гартал тэвчээртэй хүлээх ёстой.

Хурцадмал байдлыг намжаах

Хурцадмал байдлыг бууруулах, намжаах гэдэг нэр томъёог ихэвчлэн буруугаар ойлгодог. Үүнийг пассив буюу идэвхгүй байхтай андуурч болохгүй. Хурцадмал байдлыг намжаах гэдэг нь эмх замбараагүй байдал, хүчирхийллийн бодит үйлдлүүд гарах хүртэл хүлээх бус, харин харилцан ярилцаж, ялгавартай арга хэмжээ авах замаар хурцадмал байдлыг идэвхтэй бууруулах явдал юм. Хурцадмал байдлыг намжаах нь өөрчлөгдөж буй нөхцөл байдалд цочмог хариу үйлдэл үзүүлэхээс илүүтэй хэв журам хамгаалах эерэг, идэвхтэй тактик гэж үзэх ёстой. Нөхцөл байдал хурцдаж, хүч хэрэглэсэн тохиолдолд цагдаа нар хэвийн байдалдаа эргэн орохын тулд аль болох түргэн шуурхай арга хэмжээ авах ёстой.

Энэхүү гарын авлагад бүхэлд нь дурдсанчлан цагдаагийн командлагчид аль болох харилцан ярилцах арга хэлбэрийг хурцадмал байдлыг бууруулах, нөхцөл байдлыг намжаах арга хэрэгсэл болгон ашиглах ёстой. Тодруулбал, цагдаагийн дарга нь жагсаал, цуглааныг зохион байгуулагч болон бусад холбогдох хүмүүстэй нүүр тулан уулзаж ярилцах, гар утсаар холбоо тогтоон ярилцах хэрэгтэй. Харилцаа холбоо тасарсан тохиолдолд харилцаа холбооны шугамыг дахин нэвтрүүлэх, яриа хэлцэл, зуучлалын хэлбэрийг ашиглах, эсвэл ятган үнэмшүүлж тайвшруулах нь хэзээд чухалд тооцогдох бөгөөд баримтлах хэм хэмжээ байх ёстой. Цагдаагийн байгууллага өөрсдийн үйлдэл, эс үйлдлээ тайлбарлаж, зохих тохиолдолд буруугаа хүлээн зөвшөөрөхөд бэлэн байх ёстой. Харилцан яриа хэлэлцээ хийж, харилцаа холбоо тогтоох нь хурцадмал байдлыг бууруулахад томоохон нөлөө үзүүлж чадна. Цагдаагийн байгууллагын зорилго нь хэзээд нөхцөл байдлыг боломжийн хэмжээнд дэг журамтай, хурцадмал байдлыг бага байлгах явдал байх ёстой. Гэхдээ цагдаагийн болон олон нийтийн ойлголтууд өөр байж болохыг бас мэдэж байх ёстой.

Хурцадмал байдлыг намжаах гэдэгт цагдаагийн зорилгыг хүмүүст илүү өргөн хүрээнд ойлгуулж хүргэхийн тулд аман бус харилцааны аргыг хэрэглэх, тухайлбал, усан буу, эсвэл цагдаагийн бусад машин техникийг шаардлагагүй болсон үед хүмүүсийн нүднээс нь холдуулах гэх мэт арга замууд байж болно. Энэ нь мөн үймээн самууны үеийн хамгаалалтын хэрэгсэл өмссөн цагдаа нарыг стандартын буюу өдөр тутмын дүрэмт хувцастай цагдаагийн алба хаагчдаар солих ч байж болно. Гэхдээ цагдаагийн командлагч шаардлагатай үед алба хаагчдаа хамгаалах үүрэгтэй гэдгээ үргэлж санаж байх ёстой.

Албадан саатуулах

Эмх замбараагүй байдалтай тэмцэх нэг сонголт бол хүчирхийлэл үйлдэж буй хүмүүсийг албадан саатуулах явдал юм. Албадан саатуулах олон хэлбэр байдаг. Байж болох хамгийн энгийн хэлбэр нь жагсаал, цуглаанд оролцсон хүмүүсийг замын хөдөлгөөнд оролцоход нь дагаж зохицуулах явдал юм. Эсвэл хүчирхийлэл гаргаж болзошгүй сөрөг хүчний дэргэдүүр тайван жагсагчдыг хамгаалан дагах байдлаар хэв журам сахиулах асар их нөөц хүч шаарддаг хэлбэр ч байж болох юм.

Цагдаа нарын ашигладаг хамгийн маргаан дагуулдаг аргуудын нэг бол «хайрцаглах» гэж нэрлэдэг арга юм. Энэ нь цагдаа жагсаал, цуглааны хөдөлгөөн (аль нэг хэсгийг)-ийг тодорхой нэг газар байрлуулж, хөдөлгөөнийг нь хязгаарлах явдал юм. Онолын хувьд цагдаа ийм арга хэмжээ авснаар хүчирхийллийн шинжтэй авирласан, эсвэл нийгмийн эмх замбараагүй байдал үүсгэх, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй хэсэг бүлэг хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлаж саатуулах явдал юм. Үүний дараа саатуулагдсан хүмүүсийг хэсэг хугацааны дараа хянах боломжтой байдлаар цөөн цөөнөөр нь гаргаж явуулна.

Албадан саатуулах арга хэмжээ нь үргэлжлэх хугацааны хувьд (ялангуяа төлөвлөлт муутай, зохицуулалт байхгүй тохиолдолд), мөн саатуулагдаж байгаа хүмүүсийн олонхи нь тайван байсан бол тохиромжгүй байх өндөр эрсдэлтэй гэдгийг цагдаагийн командлагч нар үргэлж санаж байх ёстой. Мөн саатуулагдаагүй хүмүүсийн хувьд эв санааны нэгдэл нь эрсдэл учруулах магадлалтай. Тиймээс албадан саатуулах нь сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Санамсаргүй байдлаар албадан саатуулагдсан хүмүүсийг суллаж гаргах тухай журам протокол байх ёстой. Жагсаал, цуглаанд оролцогчдын зөвхөн нэг хэсэг нь хүчирхийлэл үйлдсэн бол жагсаал, цуглаанд оролцож буй бусад хүмүүсийг тайван замаар үргэлжлүүлэхийг нь зөвшөөрөх ёстой. Албадан саатуулах гол зорилго нь хүчирхийллийг үргэлжлүүлэх, даамжруулахаас урьдчилан сэргийлэх, жагсаал, цуглааныг тайван үргэлжлүүлэх боломжийг олгох явдал юм.

Жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон саатуулагдаж болзошгүй хүмүүст саатуулах болсон шалтгаан, хэдий хугацаанд саатуулах талаар хэлж тайлбарлах нь чухал. Албадан саатуулагдах бүсэд байгаа хүмүүсийн бие засах, ус уух зэрэг үндсэн хэрэгцээг шаардлагатай үед нь хангах ёстой (энэ нь хэт халуун, хэт хүйтэн уур амьсгалтай үед онцгой чухал). Цагдаа нар жагсаал, цуглаанд янз бүрийн хүмүүс оролцдог гэдгийг үргэлж санаж байх ёстой бөгөөд иймээс албадан саатуулагдсан хүмүүсээс, ялангуяа жирэмсэн

эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настай, өвчтэй, гэмтэж бэртсэн хүмүүс гэх мэт эмзэг бүлгийн хүмүүсийг саатуулах бүсээс гарах боломж нээлттэй байх ёстой. Албадан саатуулах арга хэмжээ нь зөвхөн шаардлагатай хамгийн бага хугацаанд байх ёстой бөгөөд тогтмол хугацаанд эргэн хянаж байх ёстой.

Албадан саатуулах арга хэмжээ нь жагсаал, цуглааны оролцогчид, хүний эрхийн бүлгүүд болон зарим шүүх байгууллагуудын дунд санаа зовоосон томоохон асуудлын нэг юм. Цөөнгүй тохиолдолд цагдаа нарын «хайрцаглах» арга тактик нь хууль бус үйлдэл болохыг тогтоосон. Учир нь энэ аргыг хэрэглэх нь ялгаварлан гадуурхах хандлагатай байдаг; Цагдаа нар жагсаал, цуглаанд оролцогчид болон оролцоогүй хүмүүс, тайван болон тайван бусаар оролцогчдыг хооронд нь ялгадаггүй. Зарим хүмүүст цагдаагийн хамгаалалтын шугамыг гарахыг зөвшөөрсөн мөртлөө бусдад нь зөвшөөрөхгүй байх нь хурцадмал байдлыг улам дэвэргэж, цагдаагийн хүрэнээс гадагш гарахыг хориглосон хамгаалалт нь хувь хүний эрх чөлөө болон хөдөлгөөний эрх чөлөөг зөрчиж болзошгүй юм²⁶. ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгогдсон гишүүн орнуудын тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих тухай 2014 оны тайланд «олон хүнийг хүчээр албадан саатуулах (хайрцаглах, хаших) аргыг зөвхөн ноцтой хохирол, гэмтэл бэртэл учрахаас урьдчилан сэргийлэх болон хүмүүсийн эрх чөлөөтэй байх, хөдөлгөөний эрх чөлөөг аль болох бага хязгаарлах өөр тактикийн сонголт байхгүй тохиолдолд ашиглахыг зөвлөсөн байна.»²⁷ Хайрцаглан хаших замаар саатуулах нь цагдаагийн алба хаагчдын хувьд мөн хүн хүч их шаарддаг бөгөөд олон тооны алба хаагчийг нэлээд удаан хугацаагаар ажиллуулах шаардлагатай болдог.

Жагсаал, цуглааныг тараах

Цагдаагийн байгууллагын хийх хамгийн сайн сонголт бол хүмүүст аяндаа тарах боломжийг олгох явдал байх ёстой. Цагдаа нар жагсаал, цуглааныг албадан тараах нь дэг журмыг сахиулахад тавигдах хамгийн бага шаардлага байх ёстой бөгөөд зөвхөн хүчирхийлэл, эсвэл хүчирхийллийн аюул занал гарцаагүй бий болсны хариуд л хэрэглэгдэх ёстой.

26 *Тайван цуглаан хийх эрх чөлөөний удирдамж, ши татсан зохиолд.*, 1-р тэмдэглэл, 79-р тал.

27 ЕАБХАБ/АИХЭГ-ын ЕАБХАБ-ын зарим гишүүн орнуудын тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих тухай тайлан. 2014 оны 12-р сарын 17, Варшав, <<http://www.osce.org/odihr/132281?download=true>>.

Цагдаа нар үйл ажиллагааны ямар нэг өөр хувилбарыг ашиглахаасаа өмнө юуны өмнө амаар болон дохио зангаа ашиглах, ярьж тохиролцох байдлаар зохион байгуулагчид, гол нөлөөлөгчид, зохицуулагч нарыг жагсаал, цуглаан болж буй газрыг орхин явахыг хүсэх хэрэгтэй. Хүчирхийлэл аль хэдийн өргөн хүрээнд тархаж, ямарваа байдлаар хойшлуулах нь нийтийн аюулгүй байдлыг хамгаалж буй алба хаагчдад шууд аюул учруулахаар нөхцөл байдал үүсээгүй л бол хүмүүс явахаас татгалзах бүрт энэ арга барилыг баримтлан ажиллах ёстой.

Хүчирхийлэл үүссэн жагсаал, цуглааныг тараахаар хүч хэрэглэх шийдвэр гаргах тохиолдолд үйл ажиллагааны командлагчаас зөвшөөрөл өгөх ёстой. Шийдвэрийг бүрэн баримтжуулж, сонгосон хувилбаруудын бүрэн үндэслэлийг өгөх ёстой.

Аливаа хүч хэрэглэхээс өмнө жагсаал, цуглаанд үргэлж анхааруулж байх ёстой. Үүнд хамаарахгүй цорын ганц зүйл бол шийдвэрийг аливаа байдлаар хойшлуулах нь хүний амь нас алдагдах, эсвэл ноцтой гэмтэл учирч болзошгүй тохиолдол юм. Анхааруулгыг зохих хэл дээр дуу өсгөгч төхөөрөмжийг ашиглан нэгээс олон удаа өгөх ёстой. Анхааруулга нь тодорхой ойлгомжтой бөгөөд дуут анхааруулга байх ёстой бөгөөд машин техникийн хөдөлгүүрийн хэт чанга дуу чимээ зэрэг бусад дуу чимээгээр дарагдаж сонсогдохооргүй байх ёсгүй. Бүх оролцогч анхааруулгыг сонссон байхын тулд өөр өөр байршлаас өгөх шаардлагатай болж магадгүй. Жагсаал, цуглаан нь олон өөр хэлээр явагддаг бол хэд хэдэн хэлээр сэрэмжлүүлэг өгөх талаар цагдаагийн байгууллага бодох ёстой бөгөөд хэрэв боломжтой бол гараар бичсэн тэмдэг, цахим самбар ашиглах талаар ч бодолцох хэрэгтэй.

Цагдаа хоёр дахь удаагаа сануулга өгөх, эсвэл хүч хэрэглэхээс өмнө оролцогчдод зохих хугацааг өгөх ёстой. Боломжтой бол анхааруулгыг болон түүнд олон нийтийн үзүүлж буй хариуг харуулсан дүрс болон дууны бичлэг хийх хэрэгтэй.

Хэрэв цагдаа хүч хэрэглэх шаардлагатай гэж үзвэл энэ нь хүчирхийлэл үйлдэж буй хүмүүст чиглэсэн ажиллагаа байх ёстой бөгөөд хүчирхийллийг таслан зогсоож, нийгмийн хэв журмыг сэргээхэд тавигдах хамгийн эцсийн шаардлага байх ёстой. Цагдаа нар жагсаал, цуглаанд оролцогчдын олон янз байдлыг мэдэж байх ёстой бөгөөд ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст хүч хэрэглэхэд үүсэж болох аливаа үр дагаврыг харгалзан үзэх ёстой.

Оролцогчдын багахан хэсэг нь хүчирхийллийн шинжтэй авирласан тохиолдолд зөвхөн тухайн хүмүүсийн эсрэг арга хэмжээ авах ёстой, харин жагсаал, цуглааны бусад хүмүүсийг жагсаал, цуглаанаа үргэлжлүүлэх, эсвэл өөрсдөө тарах боломжийг олгох ёстой. Албадан тараах тактик хэрэглэх шийдвэр гаргахдаа цөөн хэдэн хүмүүсийн үйлдлээс бус, харин олонхийн үйлдэл, зан төлөв дээр үндэслэсэн байх ёстой.

Хяналтын хуудас

Командлалын багийн хүлээх үүрэг хариуцлагууд

Стратегийн командлал нь:

- ✓ Арга хэмжээг албадан тараахдаа хүний эрхэд нийцэж буйг хянах;
- ✓ Албадан тараах ажиллагааг хийхдээ хүч хэрэглэх шаардлагатай эсэхийг шийдэх;
- ✓ Үйл ажиллагааны тушаалаар ашиглах шаардлагагүй болсон нөөцийг хяналтдаа авах;
- ✓ Цагдаагийн алба хаагчдын хууль бус үйлдлийн талаарх мэдээлэл, эсвэл өөр байгууллага мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа бол энэ талаар цаг алдалгүй мэдээлэх, холбогдох бүх нотлох баримтыг бэлэн байлгах.

Үйл ажиллагааны командлал нь:

- ✓ Жагсаал, цуглааныг тайван замаар тараахад дэмжлэг үзүүлэх;
- ✓ Зохион байгуулагчид болон оролцогч талуудтай яриа хэлэлцээгээ үргэлжлүүлэх;
- ✓ Хэрэв тайван замаар тараах боломжгүй бол зөвхөн зохих тохиолдолд хүч хэрэглэх эрх мэдлийг эрэлхийлэх буюу олгох;
- ✓ Үйл ажиллагааны хувилбаруудыг ашиглах эрх мэдлийг тогтмол хянаж байх ба нөхцөл байдал цаашид хамаарахгүй болсон тохиолдолд эрхээ эргүүлэн татах;
- ✓ Шаардлагагүй болсон аливаа нөөцийг стратегийн командлалын хяналтад шилжүүлэх;
- ✓ Холбогдох мэдээллийг стратегийн эсвэл тактикийн командлалд тогтмол дамжуулна.

Тактикийн командлал нь:

- ✓ Үйл ажиллагааны командлал руу мэдээллийг тогтмол дамжуулах;
- ✓ Цагдаагийн алба хаагч хүч хэрэглэсэн тухай бүртгэж, шуурхай ажиллагааны командлалд мэдээлэл өгөх;
- ✓ Албан тушаалтнууд мэргэжлийн, хууль ёсны бөгөөд хүний эрхэд нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг дагаж мөрдөж буйг баталгаажуулах;
- ✓ Алба хаагчдадаа тогтмол анхаарал халамж тавих;
- ✓ Жагсаал, цуглаанаас явж буй хүмүүсийн аюулгүй байдалд хяналт тавьж, эрсдэлт шинжтэй хүмүүст, тухайлбал, гэртээ ганцаараа явж буй эмэгтэйчүүд, хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс, ЛГБТИ оролцогчдод онцгой анхаарал хандуулах.

IV Хэсэг

ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ДАРАА

10-Р БҮЛЭГ. ПРАКТИК АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ

Жагсаал, цуглааныг түр зуурын арга хэмжээ гэж тодорхойлсон боловч хэр богино хугацаанд, эсвэл удаан үргэлжлэх талаар тохиролцоо байдаггүй мөртлөө жагсаал, цуглааныг ерөнхийдөө түр хугацааных гэж тооцдог. Сүүлийн жилүүдэд урт хугацаанд үргэлжлэх жагсаал, цуглааны тоо нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд жагсагчид ихэвчлэн өөрсдийн хэрэгцээг хангах майхан шиг бүтэцтэй болон бусад байгууламж бүхий газарт хагас байнгын ажиллагаатай оролцдог.

Энэ бүлэгт заасан үндсэн зарчим, үйл ажиллагааг хүчирхийлэл, эмх замбараагүй байдал үүссэн эсэхээс үл хамааран бүх төрлийн жагсаал, цуглаанд хэрэгжүүлэх нь зүйтэй. Ялангуяа жагсаал, цуглаан хүчирхийллийн шинжтэй эсэргүүцэлтэй тулгарч, үзэн ядалтын гэмт хэрэг гарах эрсдэлтэй тохиолдолд тухайн газрыг орхин явж буй хүмүүсийг хамгаалах шаардлагатай.

Ихэнхдээ томоохон хэмжээний жагсаал, цуглааны дараа эмзэг бүлгийн хүмүүс, тэр дундаа төөрсөн хүүхдүүд, эсвэл хувь хүнд чиглэсэн гэмт хэргийн хохирогчид цагдаа нарын анхаарлын төвд ирдэг бөгөөд ийм тохиолдлуудыг шийдвэрлэхэд зохих ёсоор бэлтгэгдсэн хүн хүч бэлэн байх ёстой. Эмнэлгийн ажилтнууд болон тоног төхөөрөмжийг жагсаал, цуглаан бүрэн тарах хүртэл бэлэн байлгах ёстой.

Нөөцийн менежмент

Аливаа жагсаал, цуглааны дараа нөөц хэрэгслийг орон нутгийн хариу арга хэмжээний цагдаагийн командлагчдад аажмаар хүлээлгэн өгөх шаардлагатай бөгөөд тэд тухайн бүс нутагт цагдаагийн өдөр тутмын ажлыг үргэлжлүүлнэ. Нийтийн хэв журам сахиулах цагдаагийн нөөцийг эргүүлэн татах хурд нь тухайн тодорхой нөхцөл байдлаас шалтгаална. Гэхдээ алба хаагчид нь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөхөөс өмнө байрандаа буцаж ирээд хэсэг хугацаанд бэлэн байдалд байх ёстой. Үүний зорилго нь жагсаал, цуглааныг тараах явцад ямар нэгэн осол зөрчил гарсан тохиолдолд асуудлыг шийдвэрлэхэд цагдаагийн командлалын багт хангалттай нөөц бэлэн байх хэрэгтэй.

Ийнхүү түр зогсолт буюу түр хүлээх хугацаанд стратегийн командлагч дараах нөхцөл байдалд үүссэн байж болзошгүй аливаа осол зөрчлийг шийдвэрлэх нөөц хэрэгслийг хуваарилахад анхаарах шаардлагатай. Үүнд:

- Гэмт хэргийн газар;
- Хаалт, замын тэмдгийг буулгах;
- Баривчлагдсан хүмүүсийг харж хамгаалах, тээвэрлэх, асуудлыг нь шийдвэрлэх;
- Нотлох баримтыг хянах;
- Цагдаагийн төхөөрөмж, хэрэгслийг буцааж өгөх, нягтлан бодох бүртгэл хийх.

Хүч хэрэглэсэн тухай тайлагнах

Алба хаагч хүч хэрэглэсэн талаар ахлах тушаалын офицерт нэн даруй мэдэгдэх ёстой бөгөөд аль болох хурдан хугацаанд бичгээр тэмдэглэл үйлдэх ёстой. Тухайн алба хаагч хүч хэрэглэсэн нь үндэслэлгүй гэж үзвэл, эсвэл цагдаагийн алба хаагчийн эсрэг гомдол гаргасан гэж үзвэл стратегийн командлагч нотлох баримтыг хамгаалах болон хүч хэрэглэх тухай журмын дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулахад хангалттай нөөцийг хуваарилна. Үйл ажиллагааны командлагчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу дараагийн шуурхай мэдээлэл өгөх, эргэн хянах ажилд хамаарах аливаа материалыг цуглуулах тусгай баг байгуулах нь зүйтэй.

Цагдаагийн алба хаагч гэмтэж бэртэх

Бэртэж гэмтсэн цагдаагийн алба хаагчдад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байх ёстой. Үүнд стрессийн цочмог хариу үйлдэл, гэмтлийн дараах стрессийн эмгэг зэрэг асуудлуудаар урт хугацааны зөвлөгөө өгөх, стрессийг зохицуулах үйлчилгээ орно. Гэмтэл бэртэл бүхий осолд оролцсон цагдаагийн алба хаагчид нь бие махбодийн хувьд илт гэмтэл учраагүй ч бусад хэлбэрээр илэрч болох сэтгэл санааны гэмтэл авсан байж болно. Ийм тохиолдолд алба хаагчдад албан үүргээ дахин гүйцэтгэж эхлэхээс нь өмнө мэргэжлийн эмчилгээ хийлгэх шаардлагатай.

Тоног төхөөрөмж, хэрэгслийг буцаах

Галт зэвсэг болон үхлийн аюул багатай хэрэгслийг буцааж өгөхдөө тухайн үйл явдал болохоос өмнө өгсөн техник хэрэгсэл, сумыг тухайн үйл явдлын дараа тоо ёсоор буцаасан эсэхийг ахлах тушаалын ажилтан шалгаж бүртгэх нь чухал. Аливаа зөрүү гарсан бол энэ тухай бичгээр тайланд хавсаргаж,

шаардлагатай бол хүч хэрэглэсэн тухай тайланд хавсаргана. Бүртгэгдээгүй болон алдагдсан төхөөрөмж хэрэгслийг шалгах хэрэгтэй.

Баривчлагдсан хүмүүс

Жагсаал, цуглааны үеэр оролцогчдыг баривчлах нь (захиргааны, эрүүгийн болон бусад зөрчил гаргасан үндэслэлээр) эрх чөлөөтэй байх, аюулгүй байдлыг хангах эрхийг ханган маш өндөр босготой байх ёстой бөгөөд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцох нь цаг хугацааны хувьд мэдрэмтгий байдаг. Цагдан хорих арга хэмжээг зөвхөн цагдан хорихгүй бол эрүүгийн ноцтой гэмт хэрэг үйлдэгдэх аюултай нөхцөлд л хэрэглэнэ²⁸.

Арга хэмжээний үеэр хууль ёсны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүст хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Тэднийг цаг алдалгүй зохих цагдаагийн хэлтэст хүргэж, баривчилсан болон хүлээн авсан цагдаагийн алба хаагчийн ажиллагааны тэмдэглэлийг хөтлөх ёстой.

Цагдан хоригдож байгаа хүнд өөрийнх нь ойлгодог хэлээр баривчилсан шалтгааныг нь хэлж, түүнийг суллах эсвэл цагдан хорих нь хууль ёсны эсэхийг шалгахын тулд аль болох түргэн хугацаанд шүүхэд хандах ёстой. Тухайн хүнийг цагдан хоригдож байх хугацаанд нь цагдан хорьж, хэрхэн харьцсан талаар бүрэн тэмдэглэл хөтлөх ёстой. Баривчлагдсан хүн баривчлагдсан тухайгаа гуравдагч этгээдэд мэдэгдэх, хууль зүйн зөвлөгөө авах, эмчийн үзлэгт хамрагдах эрхтэй.

Баривчлагдсан хүмүүсийн нас, хүйс, саатуулагдсан шалтгааныг харгалзан ангиллынх нь дагуу тусад нь байлгах нь чухал юм. Тиймээс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тусад нь, хүүхдийг насанд хүрэгчдээс тусад нь байлгах ёстой. Баривчлагдсан хүмүүсийг байлгаж буй байр нь тохилог, эрүүл ахуйн шаардлага хангасан, гэрэл гэгээтэй, хөдөлж болох зайтай байх ёстой. Тохиромжтой ариун цэврийн байгууламжууд, тэр дундаа угаалгын өрөөтэй байх ёстой бөгөөд тохиромжтой хоол хүнсээр хангана. Хүссэн үед нь ундны ус өгөх, мөн эмчилгээ хийлгэх шаардлагатай.

Оролцогчдыг зогсоох, нэгжих, саатуулах, баривчлах журмыг боловсруулж гаргах ёстой. Жагсаал, цуглаанд оролцогчдыг хууль ёсны дагуу зогсоох,

28 Хүний эрхийг хамгаалагчдын гарын авлага, иш татсан бүтээлд, Тэмдэглэл 1.

нэгжлэг хийх, баривчлах тодорхой журмуудыг улс орон бүр гаргах нь нэн чухал юм. Ийм журмуудад тухайн арга хэмжээг авах нь хэзээ тохиромжтой, хэзээ тохиромжгүй, хэрхэн хийх, баривчлагдсаны дараа хувь хүмүүст хэрхэн хандах талаар зааварчилгаа өгөх ёстой. Эдгээр журмын төслийг боловсруулахдаа хувийн болон гэр бүлийн амьдрал, эрх чөлөө, чөлөөтэй зорчих эрхийн талаарх олон улсын хууль тогтоомжийг анхаарч үзэх хэрэгтэй²⁹.

Хяналтын хуудас

Командлалын багийн хүлээх үүрэг хариуцлагууд

Стратегийн командлал:

- ✓ Хяналтыг өдөр тутмын энгийн хууль сахиулах горимд аажмаар шилжүүлэх;
- ✓ Мөрдөн шалгах ажиллагаанд нөөцийг хуваарилах;
- ✓ Мөрдөн шалгах ажиллагаа үр дүнтэй явагдахыг хангуулах.

Тактикийн командлал нь:

- ✓ Баривчлагдсан хүмүүст зохих ёсоор халамж үзүүлэх, тээвэрлэх, боловсруулахад хяналт тавих;
- ✓ Нотлох баримтыг цуглуулах, мөрдөн шалгах ажлыг удирдан хянах.

Үйл ажиллагааны командлал нь:

- ✓ Цагдаагийн алба хаагчийн хүч хэрэглэсэн үйлдлийг зохих ёсоор бүртгэх;
- ✓ Гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй тохиолдолд зохих тайланг гаргаж, эрүүгийн байцаан шийтгэх журмыг дагаж мөрдөх;
- ✓ Баривчлагдсан хүмүүсийн талаарх мэдээллийг зохих ёсоор бүртгэсэн эсэхийг баталгаажуулах;
- ✓ Баривчлагдсан болон цагдан хоригдсон хүмүүстэй зөв харьцаж, тэдэнд зөв хандах;
- ✓ Гэмт хэргийн газрыг удирдах;
- ✓ Төхөөрөмж, хэрэгслийг буцаах;
- ✓ Шаардлагатай тохиолдолд алба хаагчдад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх.

29 Мөн өмнөх зүүлт тайлбарт дурдсан.

11-Р БҮЛЭГ. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ БА СУРАЛЦАХ

Цагдаагийн байгууллага амжилт болон алдаанаасаа сургамж авах нь чухал юм. Жагсаал, цуглааны төгсгөлд бүх үйл ажиллагааг нэгтгэн дүгнэн ярилцаж, юу болоод өнгөрөв, үр дүн нь Стратегийн төлөвлөгөө болон хэв журам хамгаалах стратегийн зорилгын дагуу гарсан эсэхийг хянан үзэх шаардлагатай.

Бүх зүйл хэвийн явагдаж байгаа мэт харагдаж байсан ч арга хэмжээ дууссаны дараа цагдаагийн алба хаагчид болон гадны гол оролцогч талуудтай уулзаж, бүрэн хэмжээний мэдээлэл өгөх шаардлагатай. Энэ нь болж бүтсэн зүйлийг төдийгүй болж бүтэхгүй байгаа зүйлсээ ч хэлэлцэн тэмдэглэх нь чухал гэсэн үг юм. Холбогдох бүх мэдээллийг цуглуулснаар алба хаагчид, оролцогч талууд болон боломжтой бол жагсаал, цуглааныг зохион байгуулагчдад ч өөрсдийн үзэл бодол, туршлагаа хуваалцах боломжийг олгох бөгөөд ингэснээр сурсан сургамжуудаа тодорхойлж, цаашдын төлөвлөгөө, зохион байгуулалтын бодлого журамдаа өөрчлөлт оруулах, улмаар аливаа арга хэмжээг удирдан зохион байгуулах цагдаагийн байгууллагын ур чадварыг сайжруулах чиглэлээр хийгдэх сургалтуудаа уялдуулах боломжтой болно.

Мэдээлэл солилцох хурал нь хэн нэгнийг буруутгахад биш, харин тухайн болоод өнгөрсөн үйл явдлын талаар бүрэн бөгөөд үнэн зөв мэдээлэл авч, гүйцэтгэлийг сайжруулах гол зорилготой гэдгийг албан тушаалын зэрэглэлээс үл хамааран холбогдох бүх алба хаагч ойлгох нь чухал юм. Хэв журам сахиулах үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулсан бүх алба хаагч мэдээлэл солилцох хуралд оролцож, санал бодлоо хуваалцах боломжтой байх ёстой. Энэ талаар тухайн үйл явцад оролцож буй сонирхогч талууд болон бусад талуудад тайлбарлах, эсвэл энэ тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах нь зүйтэй.

Мэдээлэл солилцох хурлын төрлүүд

Мэдээлэл солилцох хурал нь ерөнхийдөө гурван төрөл байдаг: «халуун» (эсвэл шууд) буюу шуурхай хурал, байгууллагын дотоод мэдээлэл солилцох хурал, олон агентлаг хамтарсан мэдээлэл солилцох хурал. Халуун буюу шуурхай хурал нь үйл явдал бүрийн дараа болдог; байгууллагын мэдээлэл солилцох хурал нь аливаа томоохон арга хэмжээний дараа зохион байгуулагддаг; олон агентлаг хамтран мэдээлэл солилцох хурал нь тухайн арга хэмжээг зохион байгуулахад олон агентлаг хамтран ажиллаж байгаа

тохиолдолд, эсвэл янз бүрийн олон нийтийн бүлгүүдийг хамарсан арга хэмжээ болж буй тохиолдолд хийгддэг.

Мэдээлэл солилцох хурлыг хийхдээ дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

Үүнд:

- Нээлттэй, шударга явуулах;
- Хувь хүн, бүлэг хамт олон болон байгууллагын түвшинд ойлголт мэдлэг өгөх, суралцахад чиглэгдсэн байх;
- Мэргэжлийн үүрэг, хариуцлагатай нь уялдаж нийцсэн байх;
- Холбогдох бүх хүнийг адилхан чухалчлан үзэж, үнэ цэн өгсөн байх ёстой.
- Мэдээллийг үнэн зөв тэмдэглэж бүртгээд, үр дүнг багийн бүх гишүүдэд тараана.

Халуун (буюу Шууд) шуурхай хурал: Энэхүү хурал нь тухайн үйл явдал болоод, тарж дууссаны дараа шууд явагдана. Бүх командлагч өөрсдийн удирдлага дор байгаа офицеруудаас мэдээллийг авч нэгтгэх бол, олон нийттэй харилцах буюу яриа хэлэлцээ хариусан ажилтнууд нь цуглаан зохион байгуулагчдаас мэдээлэл авч нэгтгэнэ. Дараа нь эдгээр мэдээллийг стратегийн командлагчид цаашдын арга хэмжээ авхуулахаар дамжуулна.

Хүчирхийлэл гарч болзошгүй, эсвэл олон тооны хүн баривчлагдсан жагсаал, цуглааны үеэр алба хаагч бүрийг үүрэгт ажилдаа гарахаас нь өмнө уулзаж мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилготой мэдээлэл солилцох тусгай багийг ажиллуулах талаар анхаарч үзэх хэрэгтэй. Энэ баг нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Хүч хэрэглэсэн бүх тохиолдлыг зохих журмын дагуу бүртгэсэн эсэхийг хянах;
- Алба хаагчдын олж авсан нотлох баримтуудыг цуглуулж, мөрдөн шалгах ажиллагааны багт дамжуулсан эсэх;
- Аливаа гэмтэлтэй холбоотой зөвлөгөө өгөх гэх мэт дэмжлэг шаардлагатай ажилтнуудыг тодорхойлох.

Мэдээлэл солилцох шуурхай хурал нь:

- Шуурхай хуралд оролцогчдоос чухал мэдээллүүдийг түргэн шуурхай цуглуулахыг баталгаажуулах;
- Аливаа хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг цуглуулах, бүртгэх;
- Санаа зовоосон аливаа асуудлыг шуурхай хэлэлцэх боломжийг олгох;
- Аюулгүй ажиллагаатай холбоотой чухал асуудлуудыг шийдвэрлэх;
- Алба хаагчид болон оролцогч талуудад талархал илэрхийлэх.

Тактикийн командлагч бүр өөрийн дүгнэлтийг үйл ажиллагааны командлалд танилцуулахаас өмнө мэдээлэл солилцох товч хурлыг хийнэ.

Үйл ажиллагааны дараа хийгддэг дүгнэлтийн хурал нь баг хамт олонд цааш цаашдын сургамж, анхаарах зүйлсээ тодорхойлоход тусгайлан чиглэгдсэн энгийн хялбар, үр дүнтэй шуурхай хурал юм³⁰. Энэ нь дараах дөрвөн асуултад хариулахад чиглэгдэнэ:

- *Бид юу хийхээр зорьсон бэ?* Бидний зорилго юу байсан бэ? Юу болох ёстой байсан бэ? Дарга, офицеруудын санаа зорилго өөр байсан уу? Та юу бодож санаж байсан бэ?
- *Бид яг юу хийсэн бэ?* Видео камерт юу харагдаж байсан бэ? Хэн нэгнийг буруутгахгүй, зөвхөн гол үйл явдлууд, болсон дараалал, гүйцэтгэсэн үүрэг ролиудыг харна.
- *Бид юу сурсан бэ?* Цаашид хийх зүйлдээ бус, харин сурсан зүйлдээ анхаарлаа хандуулах. Өмнө нь мэддэггүй байсан ямар зүйлээ бид одоо сурч авсан бэ? Ямар давуу болон сул талуудаа олж мэдсэн бэ? Одоо эхэлж байгаа хүнд бид ямар зөвлөгөө өгөх вэ?
- *Цаашид бид юу хийх вэ?* Ийм төрлийн дараагийн арга хэмжээнд бид хэрхэн бэлдэх вэ? Бид юуг өөрчлөх вэ?

Суралцахад хэрэгтэй өөр нэг үр дүнтэй хувилбар бол харилцан бие биедээ үнэлэлт өгөх үнэлгээний багийг ажиллуулах арга бөгөөд энэ нь өөр өөр хууль сахиулах байгууллагын туршлагатай цагдаагийн офицеруудыг эрдэм шинжилгээний ажилтнууд, судлаачидтай хамтран ажиллуулж, сайн туршлага, сургамжийг тодорхойлохын тулд хээрийн ажиглалт судалгаа хийлгэх явдал юм³¹.

Байгууллагын мэдээлэл солилцох хурал: Тухайн үйл явдлын талаар илүү нарийн тодорхой мэдээлэл шаардлагатай бол, эсвэл тухайн үйл явдал нь удаан хугацаанд үргэлжлэх үед байгууллагын мэдээлэл солилцох хурлыг хийх ёстой. Энэ төрлийн хурал нь ижил төстэй хэлбэрээр явагддаг боловч тайлан илтгэл нь бичгээр байна.

30 Үйл ажиллагааны дараа эргэн хянах удирамжийг дараах хаягаар орж үзнэ үү: <[http://www.commonknowledge.org/docs/Nancy%20Dixon%20-%20After%20Action%20Review%20\(AAR\)%20Guidelines.pdf](http://www.commonknowledge.org/docs/Nancy%20Dixon%20-%20After%20Action%20Review%20(AAR)%20Guidelines.pdf)>.

31 *GODIAC – Европ дахь улс төрийн жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад яриа хэлэлцээ, харилцаа холбоог стратегийн гол зарчим болгон ашиглах сайн туршлага. Судалгааны гарын авлага*, (Стокгольм: Полисен, 2013), <http://polisen.se/PageFiles/321996/Field_study_Handbook_2013.pdf>.

Байгууллагын мэдээлэл солилцох хурал нь:

- Үйл явдал болсноос хойш дөрвөн долоо хоногийн дотор явагдана (онцгой тохиолдолд үүнээс илүү урт байж болно);
- Шуурхай хуралтай адил гол оролцогч талуудыг оролцуулна;
- Хувийн асуудлаас илүүтэй зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;
- Давуу болон сул тал, цаашдын санаа оноогоо эрэлхийлэх ёстой;
- Ажилтнууд болон оролцогч талуудад талархал илэрхийлэх боломжийг олгодог.

Олон агентлаг хамтарсан хурал: Жагсаал, цуглааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхэд олон агентлаг хүчин чармайлт гарган хамтран оролцсон, эсвэл янз бүрийн олон нийтийн бүлгүүд, оролцогч талууд оролцож байгаа тохиолдолд олон агентлаг хамтарсан мэдээлэл солилцох хурлыг хийх талаар авч үзэх хэрэгтэй.

Мэдээлэл солилцох хэлбэр нь ижилхэн байна. Гэхдээ янз бүрийн агентлагуудын хүрээнд ижил төстэй мэдээллийг шаталсан процессоор хийгээд дараа нь төвлөрсөн нэг байгууллагад бүх мэдээллийг нэгтгэж, боловсруулах байдлаар зохион байгуулж болно.

Олон агентлагийн хамтарсан хурал нь:

- Үйл явдал болсноос хойш зургаан долоо хоногийн дотор явуулна (онцгой тохиолдолд үүнээс илүү урт байж болно);
- Агентлаг хоорондын уялдаа холбоо, мөн олон нийтэд үзүүлэх үр нөлөө дээр анхаарах ёстой;
- Цаашид анхаарах давуу болон сул талуудыг эрэлхийлэх ёстой;
- Гол оролцогч талуудад хөндлөнгөөс оролцох боломжуудыг оруулж өгөхөөс гадна олон нийтийн яриа хэлэлцээ, олон нийтийн янз бүрийн арга хэмжээний хэлбэрийг багтааж болно;
- Ажилтнууд болон оролцогч талуудад талархал илэрхийлэх боломжийг олгодог.

Бие даасан [ямар нэг] байгууллага дараах тохиолдолд мэдээлэл хийх нь зүйтэй. Үүнд:

- Жагсаал, цуглааны үеэр болон жагсаал, цуглааныг тараах явцад томоохон хэрэг зөрчил гарсан;
- Томоохон хэмжээний хүчирхийлэл дэгдсэн;
- Олон тооны цагдаагийн алба хаагчдыг дайчилсан;
- Цагдаа ёс зүйн зөрчил гаргасан тухай ноцтой мэдээлэл ирсэн;
- Цаашид цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд үр өгөөжтэй гэж стратегийн командлагч үзэж байгаа бол.

Хэрэв ийм мэдээлэл хийх шаардлагатай гэж үзэж байгаа бол үүнд жагсаал, цуглааныг зохион байгуулагчид, оролцогчид болон бусад чухал оролцогч талуудын төлөөллийг оролцох боломжийг олгох ёстой.

Сурсан сургамж

Мэдээлэл солилцох байгууллагын болон шуурхай хурлуудыг хийж, бүх бүртгэл мэдээллийг шинэчилж нэгтгэсний дараа стратегийн командлагч нь нэгдсэн тайланг гаргах үүрэгтэй бөгөөд уг тайлан нь тухайн үйл явдлаас авсан сургамжуудыг тодорхойлох үндэслэл болж өгнө.

Энэхүү тайлан нь:

- Үйл явдлын дарааллыг нэгтгэн дүгнэх;
- Ажиллагаанд оролцсон бүх чиг үүргийг тодорхойлох;
- Алба хаагчдын гүйцэтгэсэн арга хэмжээнүүдийг тайлбарлах;
- Хувь хүний үйлдлийг шүүмжлэхийг эсэргүүцэх;
- Цаг хугацааг үнэн зөв гаргах;
- Баримт фактыг тусгасан, товч бөгөөд бодитой байх.

Энэхүү тайлан нь цагдаагийн албанд дараах зүйлийг хийх боломжийг олгоно:

- Хариу арга хэмжээ нь хаана үр дүнтэй байсан, хаана үр дүн муутай байсан гэдгийг харуулж, яагаад ийм зүйл болсныг бодитойгоор тогтоох;
- Цаашдын хариу арга хэмжээг сайжруулах арга замуудыг санал болгох;
- Нээлттэй байх хандлага, соёлыг дэмжих.

Олон нийттэй холбогдох: Сургамжийн талаар бичсэн баримт бичгийг цагдаагийн байгууллага дотроо суралцах үйл явцад зориулах ёстой хэдий ч жагсаал, цуглааныг зохион байгуулагчид, оролцогчид, улс төрчид, улс төрийн намууд, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтай дахин холбогдох, тэдэнтэй харилцаа холбоо, итгэлцлийг сэргээх, эсвэл олон нийтийн өмнө байнга хүлээж буй хариуцлагынхаа нэг хэсэг болгон ашиглах ёстой.

Ийм яриа хэлцэл, харилцаа холбоо нь ялангуяа тухайн жагсаал, цуглаан дээр ямар нэгэн хүчирхийлэл, эмх замбараагүй байдал гарсан, эсвэл тухайн үйл явдлыг хэв журам хамгаалах талаар олон нийт шүүмжлэлтэй хандсан тохиолдолд онцгой чухал. Энэ бол эерэг, олон нийтэд чиглэсэн, хариуцлагатайгаар хэв журам сахиулах үйл ажиллагааны чухал элемент мөн бөгөөд хэв журам сахиулах үйл ажиллагаанд баримтлах хүний эрхийн

аливаа хандлагын суурь үндсэн хэсэг юм. Жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалах үйл ажиллагаа сөргөөр ойлгогдох, ялангуяа цагдаа хүч хэрэглэсэн (эсвэл жагсаал, цуглааныг бусдаас хамгаалж чадаагүй) тохиолдолд энэ нь муу нэр зүүхэд хүргэж, цааш цаашдын үйл ажиллагаанд дарамт болж, илүү бухимдал, дайсгал, уур хилэн үүсэх эрсдэлийг нэмдэг. Энэ байдал нь дараагийн удаа цагдаа нартай амархан сөргөлдөхөд хүргэдэг. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд олон нийттэй зохистой харилцаж, үйл ажиллагаагаа ил тод үнэлж дүгнэн, шаардлагатай үед мөрдөн шалгах ажиллагаа ч явуулж болно.

Бүртгэл хөтлөх: Төлөвлөлтийн үйл явцад гарсан мэдээлэл, үүрэг, хариуцлагууд, шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлдог стратегийн зорилго, тэдгээр шийдвэрийн үр дүнгүүд, ялангуяа хувь хүний эрх, эрх чөлөөнд нөлөөлж буй шийдвэрүүдийг шалгаж нягтлахад бэлэн байлгах шаардлагатай. Энэхүү гарын авлагад тусгагдсан шийдвэр гаргах загвар, төлөвлөлтийн бүтцийг ашиглан цагдаагийн командлалын баг тодорхой үе шаттай төлөвлөгөө, шийдвэрийн протоколуудыг гаргаж чадах бөгөөд эдгээр нь мэдээлэл солилцох хурал дээр үндсэн мэдээлэл болж өгөхийн зэрэгцээ цаашдын үйл ажиллагааг анхлан төлөвлөхөд хэрэг болох баримт бичгүүд юм.

Аливаа арга хэмжээ дуусахад, эсхүл үүрэг гүйцэтгэх хугацаа дуусах хүртэл хэд хоногийн турш үргэлжилсэн үйл явдлын хувьд цагдаагийн бүх алба хаагч ажлаа дүгнэж, өөрсдийн болон бусдын үйлдлийн талаар үнэн зөв бүртгэл хөтлөх ёстой. Бүх протокол бүртгэлд гарын үсэг зурж, огноо, цаг хугацааг тэмдэглэж, удирдлагадаа хянуулж гарын үсэг зуруулахаар өгнө.

Бүх алба хаагч аливаа гэмт хэрэг, сахилгын зөрчлийн талаар ажигласан, эсвэл энэ тухай нотлох баримтыг бүртгэж баримтжуулах ёстой. Мөн алба хаагч хүч хэрэглэсэн аливаа тохиолдлыг бүртгэж авах ёстой бөгөөд энэ тухай ахлагчдаа аль болох хурдан мэдэгдэх ёстой.

Үүнээс гадна командлагч нар албан үүргээ гүйцэтгэж байхдаа хүлээн авсан мэдээлэл, гаргасан шийдвэрүүдээ бичгээр баримтжуулж байх ёстой. Үйл ажиллагааны командлал нь холбогдох бүх шийдвэрийг тухайн шийдвэрийн үндэслэл, боломжит хувилбарууд, шийдвэрийн үр дүн зэргийг бичиж баримтжуулах ёстой. Шийдвэр гаргах загварыг ашигласнаар командлагчид холбогдох бүх баримтыг баримтжуулан бүртгэсэн гэдэгт итгэлтэй байж болно. Тактикийн командлагчид ч мөн адил үйл ажиллагааны командлалд шилжүүлсэн бүх мэдээллээ бүртгэх ёстой, учир нь эдгээр нь шийдвэр гаргахад нь ашиглагдах болно. Тактикийн

командлагч өөр офицерыг бүртгэл хийж, протокол хөтлөхөд туслуулахаар томилсон бол бүх бүртгэл мэдээллийг баримт факттай нь үнэн зөв бүртгэж буйд хяналт тавина.

Үйл ажиллагааны командлагч өөрийн удирдлагад байгаа алба хаагчид нь холбогдох бүх бүртгэл протоколыг бүрэн бичиж бүртгэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй бөгөөд бүх алба хаагч үүргээ гүйцэтгэж дуусахаас өмнө баримт бичгүүдэд гарын үсэг зурж, огноог тавина. Энэ дүрэмд үл хамаарах алба хаагчид нь гэмтэл бэртлийн улмаас эмнэлгийн тусламж авч байгаа, эсвэл албан үүргээ гүйцэтгэх бусад нөхцөл байдлын улмаас байхгүй байгаа офицерууд багтаж болно. Эдгээр тохиолдолд тэдний бүртгэлийг аль болох хурдан бөглөж, гарын үсэг зурах хэрэгтэй.

Үйл ажиллагааны командлагч нь хүлээн авсан мэдээлэл, цагдаагийн алба хаагчдын дайчилгаа, авсан арга хэмжээ, гэмт хэрэг зөрчил, цагдаагийн хариу арга хэмжээ зэргийг багтаасан үйл явдлын цагийн бүртгэлийг хөтлөх шаардлагатай. Командлагчид энэ бүх мэдээллийг бүртгэж баримтжуулахад туслах баг байх боловч зөвхөн үйл ажиллагааны командлагч өөрөө бүх бүртгэл мэдээлэл үнэн зөв эсэхийг баталгаажуулж, үйл явдал, баримт фактын үнэн зөв бүртгэл болгон гарын үсэг зурах ёстой. Үйл ажиллагааны командлагч нь гаргасан шийдвэрүүд, стратегийн командлалд дамжуулсан бүх мэдээлэлдээ хувийн тэмдэглэл хөтлөх үүрэгтэй. Тэрээр мөн үйл ажиллагааны командлагчдын бүртгэлийг шалгаж, гарын үсэг зурна.

Стратегийн командлал нь шийдвэр гаргасан тухайгаа, мөн стратегийн зорилгод ямарваа өөрчлөлт орсон бол үндэслэлийг нь баримтжуулах шаардлагатай. Тэд мөн үйл ажиллагааны командлалын ирүүлсэн бүртгэл баримтыг шалгаж, гарын үсэг зурах үүрэгтэй.

Эдгээр бүртгэл нь нотлох баримтын ил тод, хариуцлагатай байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд төр, иргэд, бусад хяналтын байгууллагуудаас хяналт шалгалт хийх боломжийг олгодог. Эдгээр бүртгэл баримтууд нь мөн мэдээлэл солилцох хуралд ашиглах мэдээллийг бүрдүүлж өгдөг. Хүмүүсийн хувийн нууцад шаардлагагүйгээр халдахгүйн тулд эмзэг шинж чанартай мэдээлэлтэй болгоомжтой харьцах хэрэгтэй гэдгийг санах нь зүйтэй. Цагдаагийн байгууллага хувь хүний шударга байдал, гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, гэм буруугүйд тооцогдох зарчим, үндэсний аюулгүй байдал зэрэг олон шалтгааны улмаас мэдээллийн нууцлалыг хүндэтгэх ёстой. Гэхдээ цагдаагийн байгууллага тухайн мэдээлэлтэй танилцаад, хувийн нууцыг хамгаалах эрхийг хадгалахын тулд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн задруулах, эсхүл нууцлах хоёрын хооронд тэнцвэрийг

барих ёстой. Цагдаагийн байгууллага зөвхөн буруу үйлдэл, цагдаагийн алдаа, ёс бус үйлдлийг нуун дарагдуулахын тулд мэдээллийг хэзээ ч нууж болохгүй.

Үйл ажиллагааны төлөвлөгөө: Сурсан сургамжийн талаар бичсэн тайлангийн сүүлийн хэсэгт цаашид засаж сайжруулах зөвлөмжүүдийг оруулна. Эдгээр зөвлөмжийг байгууллагын дотор сайжруулах төлөвлөгөөг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө болгон боловсруулах ёстой.

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь дараах шинж чанартай байх ёстой. Үүнд:

- **Тодорхой** — Энэ нь үйл ажиллагаа, бүтэлгүйтэл, шилдэг туршлага, алдаа дутагдал зэргийг нарийвчлан тодорхойлох бөгөөд сайжруулахын тулд юу хийх ёстойг тоймлон харуулна;
- **Хэмжигдэхүйц** — Энэ нь ахиц, дэвшил гарч, сайжирч байна гэдгийг хэрхэн харуулахыг заана;
- **Хэрэгжихүйц** — Энэ нь байгууллага хүрч чадах зорилготой байхыг хэлнэ;
- **Хамаарахуйц** — Энэ нь зөвхөн цагдаагийн байгууллагад бодитоор хамаарах сайжруулах ёстой ажлуудыг агуулах бөгөөд бусад агентлагт хандсан зөвлөмжүүдийг зөвхөн тухайн байгууллагууд нь өөрсдөө хянан үзэх зорилгоор хуваалцана;
- **Цаг хугацаатай** — Энэ нь сайжруулах ажлуудаа хэрэгжүүлэх бодит цаг хугацааг заасан байна.

Тайлан болон тайлангийн үр дүнг ямар нэг нууц мэдээлэл байгаа эсэхийг шалган, бусад агентлагуудад болон олон нийтэд мэдээлнэ. Мэдээллийг олон нийтэд мэдээлэхээс өмнө тайлангаас хувийн нууцад хамаарах мэдээллийг хассан эсэхэд анхаарах хэрэгтэй. Аливаа сургамжийг бүх тушаалын цагдаагийн алба хаагчдад зориулан хийх сургалтын хөтөлбөртөө өөрчлөлт оруулах байдлаар тусгах бөгөөд ялангуяа командлагчдад онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.

Хяналтын хуудас

Мэдээлэл солилцох, үнэлгээ хийх үеэр командлалын багийн хүлээх үүрэг хариуцлага

Стратегийн командлал нь:

- ✓ Үйл явдал бүрийн талаар зохих мэдээлэл өгөх;
- ✓ Үйл ажиллагааны командлагчаас мэдээлэл хүлээн авч нэгтгээд, санал дүгнэлт өгөх;
- ✓ Мэдээлэл солилцох хурал дээр үндэслэн зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаасан тайлан бэлтгэж, эмхэтгэх;
- ✓ Стратегийн аливаа шийдвэрийн протоколыг хөтөлж, үйл ажиллагааны командлагчийн тэмдэглэлийг шалгаж, гарын үсэг зурна.

Үйл ажиллагааны командлал нь:

- ✓ Тактикийн командлагчдаас ирүүлсэн мэдээллийн үр дүнг цуглуулж, санал дүгнэлт өгөх;
- ✓ Стратегийн командлагчид танилцуулахаас өмнө мэдээллийг цуглуулж, нэгтгэх;
- ✓ Тухайн үйл явдлын цаг хугацаа, цагдаагийн алба хаагчдын дайчилгаа, хэрэг зөрчил, авсан арга хэмжээний талаар протокол хөтлөх;
- ✓ Холбогдох аливаа шийдвэрийн протоколыг хөтлөх;
- ✓ Тактикийн командлагчийн тэмдэглэлийг шалгаж, гарын үсэг зурах.

Тактикийн командлал нь:

- ✓ Мэдээлэл солилцох хурлын үр дүнг алба хаагчдаасаа болон холбогдох оролцогч талуудаас цуглуулж, санал дүгнэлт өгөх;
- ✓ Мэдээллийг үйл ажиллагааны командлагчид танилцуулахаас өмнө цуглуулж, нэгтгэх;
- ✓ Өөрийн удирдлагад байгаа бүх ажилтнууд протокол, тэмдэглэл хөтөлсөн эсэхийг шалгаж, гарын үсэг зурах;
- ✓ Өөрсдийн гаргасан шийдвэрүүд болон бусад холбогдох мэдээллийг бүрэн баримтжуулж бүртгэх;
- ✓ Үйл явдлын дараа алба хаагчдад халамж анхаарал тавих (амрах, илүү цагийн нөхөн олговор олгох, гэмтэл бэртлийг эмчлэх, стрессийг зохицуулах, зөвлөгөө өгөх, гүйцэтгэлийг хянах, урамшуулах гэх мэт).

Хавсралт

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Энэхүү нэр томъёоны тайлбар тольд уг гарын авлагад ашигласан гол нэр томъёонуудыг тодруулав. Доорх тодорхойлолтуудыг зөвхөн энэхүү гарын авлагад зориулан ашигласан бөгөөд ЕАБХАБ-ын албан ёсны тодорхойлолтууд биш болно.

Жагсаал, цуглаан

Нийтлэг эрх ашгийг илэрхийлэх зорилгоор олон нийтийн газар олон хүн зориудаар цугларах

Эсрэг жагсаал

Өөр жагсаал, цуглаан дээр илэрхийлж буй үзэл бодолтой санал нийлэхгүй байгаагаа илэрхийлэхээр эхний жагсаал, цуглаантай ижил цаг хугацаанд ижил газар, байршилд цуглан хийж буй жагсаал, цуглаан

Аюул

Хүнийг бэртэл гэмтэлд хүргэх аливаа зүйл

Хууль ёсны жагсаал, цуглаан

Дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаан

Үхлийн аюул багатай хүч

Зориулалт нь үхэлд хүргэхээргүй ч тодорхой аргаар хэрэглэвэл ноцтой гэмтэл бэртэлд хүргэх аюултай зэвсэг, эсвэл үйл ажиллагааны тактикийн сонголт

Мэдэгдэл

Удахгүй болох гэж буй жагсаал, цуглааны талаарх мэдээллийг агуулсан мэдэгдэл бөгөөд зөвшөөрөл хүссэн хүсэлт биш юм

Үйл ажиллагааны командлагч	Тухайн нутаг дэвсгэр, эсвэл тодорхой чиг үүргийг хариуцан ажилладаг бага тушаалын офицер
Зохион байгуулагч	Жагсаал, цуглааныг зохион байгуулахтай холбоотой үндсэн үүрэг хүлээсэн хувь хүн, хүмүүс
Тайван жагсаал, цуглаан	Оролцож буй бүлгүүд, хувь хүмүүсийн үйл ажиллагаа нь тайван шинж чанартай болдог жагсаал, цуглаан (цөөн тооны хүмүүс хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд ч)-ыг хэлнэ
Хэв журам хамгаалах зорилтууд	Жагсаал, цуглааны үеэр ажиллахдаа стратегийн зорилгодоо хүрэхээр үйл ажиллагааны тактикийн сонголтуудыг ашигладаг цагдаагийн байгууллагын хэв журам хамгаалах хууль ёсны зорилтууд
Тохирсон хэм хэмжээнд байх зарчим	Эрх бүхий байгууллагуудыг зорьж буй хууль ёсны зорилгодоо хүрэхийн тулд хөндлөнгөөс оролцохдоо хэзээд хамгийн эцсийн арга хэрэгсэл болгон ашиглахыг шаарддаг зарчим
Эсэргүүцэл	Холбогдох хувь хүн, бүлэг эсвэл байгууллагаас гаргаж буй эсэргүүцлийн албан ёсны мэдэгдэл бөгөөд үүнд жагсаал, цуглаан, хүчирхийллийн бус шинжтэй шууд үйлдэл, иргэний эсэргүүцэл зэргийг оруулна
Жагсаал	Хөдөлгөөнгүй жагсаал
Эрсдэл	Ард иргэд, эд хөрөнгөд гэмтэл, хор хохирол учирч болзошгүй аюул
Нэгэн зэрэг болдог жагсаал, цуглаан	Нэг ижил цаг хугацаанд, нэг газар байршилд болж буй жагсаал, цуглааныг хэлэх бөгөөд нөгөө жагсаал, цуглаантай ямар нэгэн холбоогүй явагддаг
Аяндаа бий болдог жагсаал, цуглаан	Аливаа үйл явдал, мэдээ мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэн зохион байгуулагддаг жагсаал, цуглаан

Зохицуулагч	Жагсаал, цуглааныг зохион байгуулагч(ид)-тай хамтран ажиллаж, арга хэмжээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж буйг хянан баталгаажуулах үүрэгтэй хүнийг хэлнэ
Стратегийн командлагч	Жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалах үйл ажиллагааг хангах, хянах эрх бүхий цагдаагийн ахлах албан тушаалтан
Стратегийн зорилго	Жагсаал, цуглаантай холбоотой хэв журам хамгаалах үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон ерөнхий зорилго
Тактикийн командлагч	Жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, удирдах үүрэг бүхий дунд тушаалын цагдаагийн ажилтан
Тактикийн сонголтууд	Хэв журам хамгаалах зорилтдоо хүрэхийн тулд ашиглаж буй цагдаагийн байгууллагын тодорхой арга хэрэгслүүд
Хууль ёсны бус жагсаал, цуглаан	Жагсаал, цуглааныг зохицуулах хууль тогтоомжийг зөрчиж зохион байгуулсан жагсаал, цуглаан
Хүчирхийлэл	Биеийн хүчийг хууль бусаар буюу зүй бусаар ашиглах
Хүчирхийллийн шинжтэй зан авир	Бусдад бие махбодийн болон сэтгэл санааны хохирол учруулах, заналхийлэх зан авир
Хүчирхийллийн шинжтэй жагсаал, цуглаан	Бусдад бие махбодийн болон сэтгэл санааны хохирол учруулах, заналхийлэх зан авирыг хамтдаа нэгдэн гаргаж буй жагсаал, цуглаан

ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ӨМНӨ, ДУНДУУР, ДАРАА КОМАНДЛАЛЫН ТҮВШИН ТУС БҮРИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ НЭГТГЭН ТОЙМЛОСОН БАЙДАЛ

Жагсаал, цуглааны ӨМНӨ

Стратегийн командлал:

- Хэв журам хамгаалахад ямар арга хэлбэрээр ажиллах, мөн хэвлэл мэдээлэлтэй ажиллах бодлогыг багтаасан жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах стратегийн зорилго бүхий стратеги төлөвлөгөө боловсруулах;
- Мэдлэг, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, ялгаатай байдал гэсэн дөрвөн үндсэн зарчмыг агуулсан стратеги төлөвлөгөө гаргах;
- Стратегийн төлөвлөгөөг боловсруулахад ямар мэдээлэл шаардлагатай, энэ мэдээллийг хаанаас авч болох, мэдээллээ хэрхэн ашиглах талаар мэдэж байх; Тухайн жагсаалыг хэрхэн чиглүүлэх, үүний тулд юу шаардлагатай, ямар эрсдэл тулгарах зэргийг мэдэж байх;
- Зохион байгуулагчид болон бусад оролцогч талуудтай хэрхэн харилцах, хэн энэ ажлыг хариуцахыг төлөвлөх;
- «Гэнэтийн бэлэг байхгүй» гэх зарчмыг баримталж, харилцан яриа хэлэлцээг бий болгохыг зорих;
- Итгэлцлийг бий болгох, үүний тулд хэвлэл мэдээлэлтэй ажиллах стратеги боловсруулах;
- Оролцогчдын олон янз байдалд ялгаатай хандаж, тэдгээрийн (байж болох) өөр өөр зорилгыг ойлгох;
- Үйл ажиллагааны болон тактикийн командлалыг стратегийн төлөвлөгөө, тэр дундаа хэвлэл мэдээлэлтэй ажиллах стратегийн талаар бүрэн мэдээлэлтэй байлгах;
- Тагнуул, мөрдөн шалгах ажиллагаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг зэрэг шаардлагатай чиг үүргүүдийг багтаасан нэгдсэн командлалын бүтэц зохион байгуулалт (мөн нэгээс дээш үйл ажиллагааны командлагч шаардлагатай бол командын болон харилцааны тодорхой шатлалтай байгаа эсэхийг баталгаажуулах)-ыг хийх;
- Үйл ажиллагааны тактикийн сонголтуудад хязгаарлалт тавих;
- Тактикийн сонголтуудаа үйл ажиллагааны түвшинд дамжуулж хүргэх;
- Нөөц хэрэгслийг хуваарилах асуудлыг шийдвэрлэх;
- Зохион байгуулагчид болон бусад оролцогч талуудтай харилцах;
- Үйл ажиллагааны төлөвлөгөө(үүд)-нд гарын үсэг зурах;
- Гаргасан шийдвэрүүдийнхээ тэмдэглэлийг бүртгэн хөтлөх.

Үйл ажиллагааны командлал:

- Стратегийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн жагсаал, цуглаанд зориулсан бодит төлөвлөлтийг хийж, стратеги төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх, жагсаал, цуглааныг ерөнхийд нь хэрхэн зохицуулах талаар тайлбарласан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах;
- Хэв журам сахиулах зорилтууд (стратегийн зорилгод тулгуурлан)-ыг тодорхойлж, үйл ажиллагааны тактикийн сонголтуудаа гаргах; Мэдээлэл өгөх хурал, бие бүрэлдэхүүнийг байршуулах зэрэгт бэлтгэж, арга хэмжээний үеэр нөөцийг хэрхэн удирдах зэргээ тогтоох;
- Үйл ажиллагааны төлөвлөгөө нь стратегийн зорилгод нийцэж байгаа эсэхийг стратегийн удирдлагаас шалгаж нягтлах;
- Үйл ажиллагаанаас эхлээд газар дээр ажиллах командлалын бүтцийг тодорхойлон гаргах;
- Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг байршуулсан нь тухайн жагсаал, цуглаантай болон мэдээллийн дагуу тодорхойлсон аюул занал (хэрэв байгаа бол)-тай харьцуулахад тохирсон хэм хэмжээнд байгаа эсэхийг нягтлах;
- Гаргасан шийдвэрүүдийнхээ тэмдэглэлийг бүртгэн хөтлөх;
- Үйл ажиллагааны командлалын түвшинд танилцуулах мэдээллийг бэлтгэж, стратегийн зорилго, түүнчлэн стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний дотор хэв журам хамгаалахад тавигдаж буй зорилтууд болон үйл ажиллагааны боломжит сонголтуудаас үүдэн тавигдаж болох аливаа хязгаарлалтыг тайлбарлах.

Тактикийн командлал:

- Стратегийн зорилгыг ойлгож, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Тодорхой нутаг дэвсгэр, эсвэл чиг үүрэгт хамааруулан байршуулсан нөөц хэрэгслийг хянах;
- Стратегийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар өөрийн удирдлагад байгаа алба хаагчдад танилцуулж мэдээлэх.

Жагсаал, цуглааны ДУНДУУР

Стратегийн командлал:

- Үйл явдлыг хянах, үйл ажиллагааны талаарх ерөнхий тоймыг авч байх;
- Шаардлагатай үед стратегийн зорилгоо эргэн хянах;
- Үйл ажиллагааны командлагчтай холбоотой байж, харилцах;
- Гаргасан шийдвэрүүдийнхээ тэмдэглэлийг бүртгэн хөтлөх;
- Зохион байгуулагчид зэрэг оролцогч талуудтай холбоотой байх.

Үйл ажиллагааны командлал:

- Арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;
- Хэв журам сахиулахад ашигласан зорилго, тактикуудаа эргэн хянаж, шаардлагатай үед уялдуулан өөрчлөх;
- Тактикийн командлагчид нь стратегийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж буйг хянах;
- Хэв журам хамгаалж буй алба хаагчдаа анхаарал халамж тавих;
- Гаргасан шийдвэрүүдийнхээ тэмдэглэлийг хөтлөх;
- Аливаа гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг шалгаж, мөрдөн шалгах ажиллагаа хийгдэж байгаа, мөн хийгдэх эсэхийг хянах;
- Холбогдох мэдээллийг стратегийн командлалд дамжуулж буй эсэхийг баталгаажуулах;
- Холбогдох мэдээллийг тактикийн командлалд шилжүүлж буй эсэхийг баталгаажуулах.

Тактикийн командлал:

- Алба хаагчдад хяналт тавьж, тэднийг удирдах;
- Өөрийн удирдлагад байгаа алба хаагчдын үйлдэлд хариуцлага хүлээх;
- Хүч хэрэглэсэн аливаа тохиолдолд аль болох шуурхай мэдээлэх;
- Гэмт хэргийн нотлох баримтууд, тухайлбал цагдаагийн ёс зүйн зөрчилтэй холбоотой нотлох баримтыг зохих ёсоор хамгаалж, хадгалж, мөрдөн шалгах багт шилжүүлэх;
- Өөрийн хүлээх үүрэг хариуцлагын хүрээнд цагдаагийн тодорхой тактик хэрэглэхийг зөвшөөрөх, татгалзах шийдвэр гаргах;
- Холбогдох мэдээллийг үйл ажиллагааны командлалд дамжуулж буй эсэхийг баталгаажуулах;
- Холбогдох мэдээллийг үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад дамжуулж буй эсэхийг баталгаажуулах;
- Өөрийн удирдлагад буй алба хаагчдаа анхаарал халамж тавих.

Жагсаал, цуглааны ДАРАА

Стратегийн командлал:

- Мэдээлэл солилцох хурлыг зохих ёсоор хийсэн эсэхийг хянах;
- Үйл ажиллагааны командлалаас бүх мэдээллийг нэгтгэн цуглуулах;
- Сурсан сургамжуудыг оруулсан тайланг бэлтгэн, эмхэтгэх;
- Стратегийн аливаа шийдвэрийг нэг бүрчлэн баримтжуулан бүртгэсэн эсэхийг хянах;
- Үйл ажиллагааны тайланд гарын үсэг зурах.

Үйл ажиллагааны командлал:

- Тактикийн командлалын зохион байгуулсан хурлууд дээр яригдсан мэдээллийг цуглуулах;
- Тактикийн командлалаас бүх мэдээллийг нэгтгэж, стратегийн командлалд шилжүүлэх;
- Тухайн үйл явдлын болсон цаг хугацаа, цагдаагийн алба хаагчдын дайчилгаа, аливаа зөрчил, авсан арга хэмжээний талаар протокол хөтлөх;
- Холбогдох шийдвэрүүдийн талаар протокол хөтөлсөн эсэхийг хянан баталгаажуулах;
- Тактикийн командлалын тайланд гарын үсэг зурах.

Тактикийн командлал:

- Ажиллагаанд оролцсон алба хаагчдад мэдээлэл өгөх;
- Мэдээлэл солилцсон хурлуудын болон оролцогч талуудыг оролцуулан хийсэн хурлуудын үр дүнг цуглуулж, үйл ажиллагааны командлалд шилжүүлэх;
- Өөрийн удирдлагад буй бүх алба хаагч холбогдох протокол бүртгэлүүдээ бүрэн бөглөсөн эсэхийг баталгаажуулж, тэдгээрийг шалгаж, давхар гарын үсэг зурах;
- Гаргасан шийдвэрүүдийнхээ тэмдэглэлийг бүртгэн хөтлөх;
- Шаардлагатай алба хаагчдад арга хэмжээний дараах тусламж дэмжлэг үзүүлэх.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ, ХЭРЭГТЭЙ ХОЛБООСУУД

Хэвлэмэл эх сурвалжууд

«Жагсаал, цуглааны үеэр хэв журам хамгаалах нь», Эмнести интернэшнл, 2013.

https://www.amnesty.nl/sites/default/files/ainl_php_short_paper_policing_assemblies.pdf

«Энх тайвныг сахиулах удирдамжийн гарын авлага», Цагдаагийн дарга нарын холбоо (АСРО), 2010,

<http://www.acpo.police.uk/ProfessionalPractice/UniformedOperations.aspx>

Александр Э.Берлонги «Олон нийтийн цугларалтыг ойлгож, төлөвлөх нь», Аюулгүй байдлын шинжлэх ухаан, боть. 18, № 4, 1995, хуудас 239-247.

Ж.Блисс, К.Фэллон, Н.Хиден, Р.Гаскинс «Үхэлд хүргэж болзошгүй зэвсэгт үзүүлэх олон нийтийн хариу үйлдэл: Олон нийтийн хүчирхийллийг өдөөгч нийтлэг хүчин зүйлс», *Хүний хүчин зүйл ба эргономикийн нийгэмлэгийн жилийн уулзалтын эмхэтгэл*, боть. 48, 2004, хуудас 243-254.

«Европын цагдаагийн ёс зүйн дүрэм», Европын зөвлөл, 2001.,

<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=223251>

«Олон нийтийн зан төлвийг ойлгох удирдамж, сурсан сургамжууд», *Онцгой байдлын төлөвлөлтийн коллеж* (Лидс: Лидсийн их сургууль, 2009),

<https://www.gov.uk/government/publications/understanding-crowd-behaviours-documents>

«Египет - Эмэгтэйчүүдийг гадуур гаргах нь: Олон нийтийн орчин дахь эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл», FIDH, 2014,

<http://www.fidh.org/en/north-africa-middle-east/egypt/15140-egypt-epidemic-of-sexual-violence-continues>

«Европ дахь улс төрийн сүрт жагсаалын үеэр хэв журам хамгаалах зөвлөмж», Годиак 2013,

<http://polisen.se/en/Languages/The-Swedish-Police/International-cooperation/Cooperation-in-Europe/The-Godiac-Project/>

«Газар дээрх судалгааны гарын авлага», Годиак, 2013,

http://polisen.se/PageFiles/321996/Field_study_Handbook_2013.pdf

«Эсэргүүцлийн жагсаалд дасан зохицох нь», Цог Жавхлант Хатан Хааны Цагдаагийн газрын байцаагч, 2009,
<http://www.hmic.gov.uk/publication/adapting-to-protest/>

«Эсэргүүцлийн жагсаалд дасан зохицох нь – Британийн хэв журам хамгаалах загварыг төлөвшүүлэх нь», Цог Жавхлант Хатан Хааны Цагдаагийн газрын байцаагч, 2010 он,
<http://www.hmic.gov.uk/publication/adapting-to-protest-nurturing-the-british-model-of-policing>

Ж.Хоггетт, К.Стотт, «Олон нийтийн сэтгэл зүй, нийтийн хэв журам сахиулах цагдаагийн сургалт, хөл бөмбөгийн хөгжөөн дэмжигчдэд хэв журам сахиулах нь», *Хэв журам сахиулах: Олон улсын цагдаагийн стратеги ба менежментийн сэтгүүл, боть. 33 No: 2*, 2010, хуудас.218–235.

«Эрхийг хүндэтгэж байгаагаа харуулах уу? Эсэргүүцлийн жагсаалын үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн хандлага», Парламентын танхим, Хүний эрхийн нэгдсэн хороо, 2009,
<http://www.publications.parliament.uk/pa/jt200809/jtselect/jtrights/47/4702.htm>

К.Лансинг, Эргэн ирэх ёслол: Үүрэг хүлээсэн гэмтлийн дараах стрессийн эмгэг (PTSD)-ээс буцаж ирэх нь, (АНУ: High Ground Press, 2012).

Т.Д.Маденсен, Ж.Кнутссон, «Олон нийтийг хамарсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь» (Линне Ринер, Боулдер, Колорадо, 2011).

«Улс төрийн жагсаалын үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллах нь, Ажиглалт ба зөвлөмж», ЕАБХАБ-ын Тусгай тайлан, 2007,
<http://www.osce.org/fom/25744>

«ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын цагдаагийн ахлах зөвлөхийн Ардчилсан зарчмаар хэв журам сахиулах үйл ажиллагааны гарын авлага», ЕАБХАБ, *SPMU хэвлэлийн цуврал боть. 1, 2-р хэвлэл*, 2008,
<http://www.osce.org/spmu/23804>

«Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх удирдамж» (2 дахь хэвлэл), ЕАБХАБ-ын АИХЭГ ба Венецийн комисс, 2010,
<http://www.osce.org/odhr/73405>

«Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд хяналт тавих гарын авлага»,
ЕАБХАБ-ын АИХЭГ, 2011,
<http://www.osce.org/odihr/82979>

«Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж», ЕАБХАБ-ын АИХЭГ,
2014,
<http://www.osce.org/odihr/119633>

С.Рейхер, *Олон нийтийн динамикийн сэтгэл зүй*, М.А.Хогг, Р.С. Тиндэйл
(редактор.), *Нийгмийн сэтгэл судлалын Блэквелл гарын авлага: Бүлгийн
үйл явц*,. (Оксфорд: Блэквелл, 2001).

С.Рейхер, К.Стотт, Ж.Друри, О.Аданг, П.Кронин, А.Ливингстон, «Мэдлэгт
суурилсан нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа: Зарчим ба
практик», Цагдаа, боть. 1, Но.4, 2007, хуудас 403-415.

С.Рейхер, К.Стотт, П.Кронин, О.Аданг, «Олон нийтийн сэтгэл зүй,
нийтийн хэв журам хамгаалах нэгдсэн арга барил. Цагдаа: Олон улсын
цагдаагийн стратеги ба менежментийн сэтгүүл», 2004, хуудас 558-572.

Робертс, Т.Гартон Эш, (редактор), *Иргэний эсэргүүцэл ба эрх мэдлийн улс
төр: Гандигаас өнөөг хүртэлх хүчирхийллийн бус үйлдлийн туршлага*
(Оксфорд: Оксфордын их сургуулийн хэвлэл, 2011).

С.Стотт, О.Аданг, *Эрсдэлийг ойлгох ба удирдах нь. Европын Холбоонд олон
улсын хэмжүүрээр хөл бөмбөгийн тэмцээнд хэв журам сахиулах нь*,
(Их Британи: Бавнебанке хэвлэл, Слагелсе, 2009).

«Ярилцдаг цагдаа: Туршлага, ажиглалт, боломжууд», Шведийн
Цагдаагийн үндэсний зөвлөл, 2010,
<http://polisen.se/en/Languages/Service/Publications/Hallare/Dialogue-Police>

«Хоригдолтой харьцах хамгийн наад захын стандарт дүрэм», НҮБ, 1977,
<http://www.refworld.org/docid/3ae6b36e8.html>

«Хууль сахиулах албан тушаалтны ёс зүйн дүрэм», НҮБ, 1979,
<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/LawEnforcementOfficials.aspx>

«Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүч, галт зэвсэг хэрэглэх
үндсэн зарчим», НҮБ, 1990,
<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/UseOfForceAndFirearms.aspx>

«Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагааны эрх мэдэл, командлал, хяналт», НҮБ, Бодлого, Энхийг сахиулах ажиллагааны газар/Хээрийн дэмжлэг үзүүлэх газар, Ref. 2008.4, 2008 оны 2-р сар,

<http://www.peacekeepingbestpractices.unlb.org/PBPS/Library/Authority,%20Command%20and%20Control%20in%20UN%20PKOs%20FINAL%20SIGNED%2015%20Feb%2008.pdf>

«Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд байгуулагдсан цагдаагийн нэгжүүд, Бодлого (Шинэчилсэн)», НҮБ, Энхийг сахиулах ажиллагааны газар/ Талбайд дэмжлэг үзүүлэх газар, Реф. 2009, 32, 2009,

http://www.un.org/en/peacekeeping/sites/police/documents/formed_police_unit_policy_032010.pdf

Онлайн эх сурвалжууд

Байгууллага	Вебсайт
Америкийн Иргэний Эрх Чөлөөний Холбоо	https://www.aclu.org/
Эмнести Интернэшнл	www.amnesty.org
«Article 19» Олон Улсын Байгууллага	http://www.article19.org/
Цагдаагийн Дарга Нарын Холбоо (Их Британи)	www.acpo.police.uk
Канадын Иргэний Эрх Чөлөөний Нийгэмлэг	http://ccla.org/
Хамтын Нөхөрлөлийн Хүний Эрхийн Санаачилга	www.humanrightsinitiative.org
Европын Зөвлөл	www.coe.int
Европын Хүний Эрхийн Шүүх	www.echr.coe.int
Хүний Эрхийн Олон Улсын Холбоод (FIDH)	http://www.fidh.org/en/
Хүний Эрхийн Ажиглагч	www.hrw.org
Цагдаагийн Дарга Нарын Олон Улсын Холбоо	www.theiacp.org/
Олон Улсын Эрүүгийн Шүүх	www.un.org/law/icc/index
Олон Улсын Улаан Загалмайн Нийгэмлэг	www.ifrc.org
Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар	www.osce.org/odihr
Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага	www.osce.org
Америкийн Муж Улсуудын Байгууллага	www.oas.org
Нэгдсэн Үндэстний Байгууллага	www.un.org
НҮБ-ын Албан Бичиг Баримтын Систем	http://documents.un.org